

**ХАЛДВАРТ БУС ӨВЧИН, ОСОЛ ГЭМТЛИЙН ШАЛТГААН,
ЭРСДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ТАРХАЛТЫН
СУДАЛГАА-2009**

ДЭМБ-ЫН НОМЫН САН

ХАЛДВАРТ БУС ӨВЧИН, ОСОЛ ГЭМТЛИЙН ШАЛТГААН, ЭРСДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ТАРХАЛТЫН СУДАЛГАА-2009

1. Халдварт бус өвчин
2. Ядуурал
3. Хөгжиж буй орон

© Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага 2010

Хэвлэлийн эрх хамгаалагдсан.

Энэхүү стратегийн баримт бичигт дурьдагдсан улс орон, түүний газар нутаг, захирагаа% хил хязгаарын зөвхөөрлийг авахдаа арилжааны бус шугамаар түгээх эсвэл худалдаа зорилготой байгаа эсэхээ хэвлэлийн газарт мэдэгдэх ёстой. (Fax: +41 22 791 4806; E-mail: permissions@who.int)

Уг товхимолд аливаа байгууллага болон үйлдвэрийн бүтээгдэхүүний талаар дурьдагдсан бол энэ нь ДЭМБ-ас сайшаан зөвлөж байгаа гэсэн үг биш болохыг анхаар. Түүнчлэн алдаа мадаг, орхигдуулсан зүйл байхыг үгүйсгэхгүй бөгөөд өмчлөгдсөн бүтээгдэхүүний нэрийг том үсгээр ялгаж бичсэн болно.

Энэхүү стратегийн баримт бичигт орсон мэдээллийг бүрэн төгс, зөв гэдгийг баталгаажуулаагүй, үүнээс урган гарах аливаа хохирлын хариуцлагыг ДЭМБ хүлээхгүйг анхаарна уу.

ДЭМБ-ас эрхлэн хэвлүүлсэн материалыг World Health Organization, 20 Avenue Appia, 1211 Geneva 27 Switzerland (Tel: +41 22 791 2476; Fax: +41 22 791 4857; E-mail: bookorders@who.int) гэсэн хязгаар Зах Зээл, Түгээлтийн Газраас захиалан авч болно.

ДЭМБ-ас хэвлэсэн материалыг орчуулах, дахин хэвлэх зөвшөөрлийг авахдаа арилжааны бус шугамаар түгээх эсвэл худалдаа зорилготой байгаа эсэхээ хэвлэлийн газарт мэдэгдэх ёстой. (Fax: +41 22 791 4806; E-mail: permissions@who.int)

ДЭМБ-ЫН НОМХОН ДАЛАЙН БАРУУН ЭРГИЙН БҮСЭЭС ЭНЭХҮҮ СТРАТЕГИЙГ ДАХИН ХЭВЛЭХ ЗӨВШӨӨРЛИЙГ АВАХ ТОХИОЛДОЛД World Health Organization, Regional Office for the Western Pacific, P.O.Box 2932, 1000, Manila, Philippines, Fax.No. (632) 521-1036, E-mail: publications@wpro.who.int гэсэн хаяг руу хандана уу.

ГАРЧИГ

1. ХҮСНЭГТ	4
2. ДҮРСЛЭЛ	6
3. ТОВЧ ҮГИЙН ТАЙЛБАР	7
4. ӨМНӨХ ҮГ	8
5. ТОВЧ ХУРААНГУЙ	15
 БҮЛЭГ 1. ҮНДЭСЛЭЛ, СУДЛАГДСАН БАЙДАЛ	 21
о Дэлхий дахинд ба манай улс дахь Халдварт бус өвчин (ХБӨ)-ний байдал	22
о ХБӨ-ний эрсдэлт хүчин зүйлсийн тархалт	23
о Судалгааны зорилго, зорилт, ач холбогдол	24
 БҮЛЭГ 2. СУДАЛГААНЫ АРГА, АРГАЧЛАЛ	 25
о Судалгааны хүрээ	26
о Судалгааны хүн ам, түүврийн хэмжээ, түүвэрлэлт	26
о Судалгааны арга зүйн болон судлаач бэлтгэх сургалтууд	28
о Судалгааны мэдээлэл цуглуулсан байдал	29
о Мэдээлэл цуглуулах явиад хийгдсэн хяналт, шинжилгээ, үнэлгээ	35
о Судалгааны мэдээлэл оруулах, цэвэрлэгээ	35
о Судалгааны мэдээллийг жинилэх	35
о Судалгааны мэдээлэл боловсруулах	35
 БҮЛЭГ 3. СУДАЛГААНЫ ҮР ДҮН	 37
3.1. Хүн ам зүйн үзүүлэлт	38
3.2. ХБӨ-ний анхдагч эрсдэлт хүчин зүйлсийн тархалт	41
о Тамхи таталт	41
о Архины хэрэглээ	45
о Жимс, хүнсний ногооны хэрэглээ	49
о Хөдөлгөөний идэвхийн түвшин	55
о Бие бялдрын хөгжил, чийрэгжилт	58
3.3. ХБӨ-ний хоёрдогч эрсдэлт хүчин зүйлсийн тархалт	60
о Илүүдэл жин ба таргалалт	60
о Бүсэлхийн таргалалт, өөхлөг эдийн хэмжээ	64
о Биохимиийн эрсдэлт хүчин зүйлс	69
о Артерийн дараалт ихсэлт	74
о Чихрийн цижин	77
о Хөх, умайн хүзүүний хавдар	81
3.4. Осол гэмтэл ба хүчирхийлэл	84
о Осол гэмтэл	84
о Хүчирхийлэл	90
3.5. Харьцуулсан судалгааны үр дүн	96
о Анхдагч эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын чиг хандлага	96
о Хоёрдогч эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын чиг хандлага	98
 БҮЛЭГ 4. ДҮГНЭЛТ	 108
НОМ ЗҮЙ	109
ХАВСРАЛТУУД	111

ХҮСНЭГТ

Хүснэгт 1. Хот, хөдөөгөөс сонгогдсон кластерийн тоо	27
Хүснэгт 2. Судалгаанд сонгогдсон түүврийн нэгж ба судалгааны хүн амыг төлөөлөх хувь	29
Хүснэгт 3. Архины стандарт уулт	30
Хүснэгт 4. Архины хэрэглээний эрсдлийн зэрэг, хүйсээр	30
Хүснэгт 5. Биеийн өөхлөгийн лавламж хэмжээ	33
Хүснэгт 6. Бие бялдрын чийрэгжилтийн түвшинг үнэлэх аргачлал	34
Хүснэгт 7. Биохимийн үзүүлэлтүүдийг үнэлэх шалгур үзүүлэлтүүд (ДЭМБ)	34
Хүснэгт 8. Судалгааны түүвэрлэлт (нас ба хүйсээр)	38
Хүснэгт 9. Судалгааны хэмжээ (яс үндэс, нас, хүйсээр)	38
Хүснэгт 10. Сургуульд суралцсан нийт жил (нас ба хүйсээр)	39
Хүснэгт 11. Өрхийн нэг гишүүний жилийн дундаж орлого (насны бүлгээр)	40
Хүснэгт 12. Ажил эрхэлдэг хүн ам (нас ба хүйсээр)	40
Хүснэгт 13. Ажил эрхэлэгчийг хүн амын судалгаа (нас ба хүйсээр)	41
Хүснэгт 14. Тамхины хэрэглээний байдал (нас, хүйсээр)	42
Хүснэгт 15. Тамхины хэрэглээний давтамж	42
Хүснэгт 16. Тамхи хэрэглэж эхэлсэн дундаж нас	43
Хүснэгт 17. Архины хэрэглээний байдал, насны бүлгээр	45
Хүснэгт 18. Архины хэрэглээний байдал, хүйсээр	45
Хүснэгт 19. Архи согтууруулах ундаа хэрэглэгсдийн 1 удаагийн уултаар хэрэглэж буй стандарт уултын дундаж тоо (сүүлийн 30 хоногт)	46
Хүснэгт 20. Архины хэрэглээний эрсдлийн байдал, нийт хүн амын дунд, хүйсээр	47
Хүснэгт 21. Архины хэрэглээний эрсдлийн байдал, архи согтууруулах ундаа хэрэглэгсдийн дунд, хүйсээр	47
Хүснэгт 22. Архийг хэтрүүлэн хэрэглэгсдийн байдал, хүйсээр	47
Хүснэгт 23. Жимсний 7 хоногийн хэрэглээний давтамж (хүйс, байршилаар)	49
Хүснэгт 24. Жимсний хоногийн дундаж хэрэглээ (хүйс, байршилаар)	50
Хүснэгт 25. Хүнсний ногооны 7 хоногийн хэрэглээ (хүйс, байршилаар)	50
Хүснэгт 26. Хоногт хэрэглэх хүнсний ногооны дундаж хэмжээ	51
Хүснэгт 27. Хоногт хэрэглэх жимс, хүнсний ногооны дундаж хэмжээ	51
Хүснэгт 28. Жимс, хүнсний ногооны хоногийн дундаж хэрэглээний үзүүлэлт, хүн амын насны бүлэг, "нэгж" хэмжигдэхүүний ангилалаар	52
Хүснэгт 29. Жимс, хүнсний ногооны хоногийн хэрэглээний үзүүлэлт хүн амын байршил ба "нэгж" хэмжигдэхүүний ангилалаар	53
Хүснэгт 30. Биеийн жин, өндрийн дундаж үзүүлэлт (нас ба хүйсээр)	60
Хүснэгт 31. Биеийн жин, өндрийн дундаж үзүүлэлт (хүн амын байршилаар)	60
Хүснэгт 32. Биеийн жингийн индексийн дундаж үзүүлэлт (нас ба хүйсээр)	61
Хүснэгт 33. БЖИ-ийн дундаж үзүүлэлт (байршилаар)	61
Хүснэгт 34. Биеийн жингийн эрсдэлийн үнэлгээ (хүйс болон байршилаар)	63
Хүснэгт 35. Бүсэлхийн тойргийн дундаж хэмжээ (насны бүлэг ба хүйсээр)	64
Хүснэгт 36. Бүсэлхийн тойргийн дундаж хэмжээ (байршил ба хүйсээр)	64
Хүснэгт 37. Төвийн таргалалтын тархалт (насны бүлэг ба хүйсээр)	65
Хүснэгт 38. Төвийн таргалалтын тархалт (байршилаар)	65
Хүснэгт 39. Биед агуулагдах өөхлөг эдийн хэмжээг үнэлэх хязгаар	65
Хүснэгт 40. Биед агуулагдах өөхлөг эдийн дундаж хэмжээ (нас ба хүйсээр)	66
Хүснэгт 41. Биед агуулагдах өөхлөг эдийн дундаж хэмжээ (байршилаар)	66
Хүснэгт 42. Биед агуулагдах өөхлөг эдийн эрсдэлийн үнэлгээ (байршилаар)	67
Хүснэгт 43. Цусан дахь холестерины дундаж хэмжээ (ммоль/л)	69

Хүснэгт 44. Нийт холестерины хэмжээ ихсэх эрсдэлтэй болон ихэссэн (≥ 5.0 ммоль/л) хүний хувь	69
Хүснэгт 45. Нийт холестерины хэмжээ ихэссэн (≥ 6.2 ммоль/л) хүний хувь	70
Хүснэгт 46. Цусан дахь триглицеридийн дундаж хэмжээ (ммоль/л)	70
Хүснэгт 47. Триглицеридийн хэмжээ ихсэх эрсдэлтэй болон ихэссэн (≥ 1.7 ммоль/л) хүний хувь	70
Хүснэгт 48. Триглицеридийн хэмжээ ихэссэн (≥ 2.0 ммоль/л) хүний хувь	71
Хүснэгт 49. Цусан дахь бага нягттай липопротеины дундаж хэмжээ (ммоль/л)	71
Хүснэгт 50. Бага нягттай липопротеины хэмжээ ихсэх эрсдэлтэй болон ихэссэн (≥ 3.0 ммоль/л) хүн амын тархалт	71
Хүснэгт 51. Бага нягттай липопротеины хэмжээ ихэссэн (≥ 4.15 ммоль/л) хүний хувь	72
Хүснэгт 52. Цусан дахь их нягттай липопротеины дундаж хэмжээ (ммоль/л)	72
Хүснэгт 53. Цусан дахь их нягттай липопротеины хэмжээ (ммоль/л)	72
Хүснэгт 54. Артерийн даралтын дундаж хэмжээ (хүйс ба байршилаар)	74
Хүснэгт 55. Цусны даралт ихэссэн (САД ≥ 140 мм/муб ба/эсвэл ДАД ≥ 90 мм/муб) болов даралт бууруулах эм хэрэглэж буй хүн амын эзлэх хувь	74
Хүснэгт 56. Артерийн гипертензийн тархалт	75
Хүснэгт 57. Артерийн гипертензийн эмчилгээ хяналт	76
Хүснэгт 58. Өлөн цусан дахь сахарын дундаж хэмжээ (ммоль/л)	77
Хүснэгт 59. Өлөн цусан дахь сахарын дундаж хэмжээ (байршилаар)	77
Хүснэгт 60. Өлөн цусан дахь сахарын өөрчлөлт, насны бүлэг, хүйсээр	78
Хүснэгт 61. Өлөн цусан дахь сахарын өөрчлөлт, байршил, хүйсээр	78
Хүснэгт 62. Цусны сахар ихэссэн болон ЧШӨ-ний эмчилгээ хийлгэж буй байдал, насны бүлэг, хүйсээр	78
Хүснэгт 63. Цусны сахар ихэссэн болон ЧШӨ-ний эмчилгээ хийлгэж буй байдал, байршил, хүйсээр	79
Хүснэгт 64. Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэх үзлэгт хамрагдсан байдал (байршилаар)	81
Хүснэгт 65. Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэх үзлэгт хамрагдсан байдал(насаар)	81
Хүснэгт 66. Хөхний хорт хавдрын эрт илрүүлэх үзлэгт хамрагдсан байдал (насаар)	82
Хүснэгт 67. Хөхний хорт хавдрын эрт илрүүлэх үзлэгт хамрагдсан байдал (байршилаар)	83
Хүснэгт 68. Зам тээврийн оспоос бусад оспоор санамсаргүй гэмтэж эмнэлгийн тусламж авсан байдал (насны бүлэг, хүйсээр)	84
Хүснэгт 69. Зам тээврийн ослын байдал (насны бүлэг, хүйс, байршилаар)	86
Хүснэгт 70. Зам тээврийн ослын байдал (хот, хөдөөгөөр, байршил, нөлөөлж буй хүчин зүйлээр	87
Хүснэгт 71. Тээврийн хэрэгсэл жолоодох буюу зорчих үед хамгаалалтын бүс бүсэлдэггүй байдал, (насны бүлэг, хүйсээр)	88
Хүснэгт 72. Эмэгтэйчүүд хүчирхийлэлд өртөж буй байдал	91
Хүснэгт 73. Хүчирхийлийн давтамж	92
Хүснэгт 74. Хэн нэгний уур бухимдлаас болж гэр булийн аюулгүй байдалдаа саная зовных байдал	92
Хүснэгт 75. Хүүхэд насандaa хүчирхийлэлд өртсөн байдал	93

ДҮРСЛЭЛ

Дүрслэл зураг 1. Судалгаанд сонгогдсон түүвэрлэлтийн анхны нэгж буюу кластерийн байршил	26
Дүрслэл 2. Олон үет санамсаргүй түүврийн үе шатууд	26
Дүрслэл 3: Тамхины хэрэглээний давтамж, хүйсээр	28
Дүрслэл 4: Сүүлийн 12 сард архи согтууруулах ундаа-хэрэглэсэн давтамж	43
Дүрслэл 5. Хүн амын жимс, хүнсний ногооны хоногийн хэрэглээ нэгжээр	46
Дүрслэл 6. Хүн амын жимс, хүнсний ногооны хоногийн хэрэглээ, нэгжээр	52
Дүрслэл 7. Өөхөн тосны хэрэглээ (байршилаар)	53
Дүрслэл 8. Идэвхитэй хөдөлгөөн хийдэг хүн амын хувь(насны бүлэг, хүйсээр)	54
Дүрслэл 9. Идэвхитэй хөдөлгөөнд хоногт зарцуулдаг голч хугацаа (Хүйс, байршил, ажлын байр, ирж очих, чөлөөт цагаар)	55
Дүрслэл 10. Бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин (хүйсээр)	57
Дүрслэл 11. Бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин (насны бүлгээр)	58
Дүрслэл 12. Бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин, эрэгтэйчүүдэд (насны бүлгээр)	58
Дүрслэл 13. Илүүдэл жин ба таргалалтын тархалт (хүйсээр)	59
Дүрслэл 14. Илүүдэл жин ба таргалалтын тархалт, насны бүлэг ба хүйсээр	62
Дүрслэл 15. Илүүдэл жин ба таргалалтын тархалт, байршил ба хүйсээр	62
Дүрслэл 16. Биед агуулагдах өөхлөг эдийн хэмжээ ихсэлтийн хүн амын эзлэх хувь, насны бүлэг ба хүйсээр	63
Дүрслэл 17. Биед агуулагдах өөхлөг эдийн хэмжээ ихсэлтийн хүн амын эзлэх хувь, насны бүлэг ба хүйсээр	66
Дүрслэл 18. Артерын даралт ихсэх өвчний тархалт, эмчилгээ, хяналт	67
Дүрслэл 19. Зам тээврийн ослоос бусад ослоор санамсаргүй гэмтэж эмнэлгийн тусламж авсан байдал (Насны бүлэг, ослын төрлөөр)	75
Дүрслэл 20. Зам тээврийн ослоос бусад ослоор санамсаргүй гэмтэж эмнэлгийн тусламж авсан байдал (Осол авсан байршилаар)	85
Дүрслэл 21. Зам тээврийн ослын байдал (насны бүлэг, нөлөөлж буй хүчин зүйлээр)	85
Дүрслэл 22. Тээврийн хэрэгсэл дотор хамгаалалтын бүс бүсэлдэгтүй байдал (байршил, хүйсээр)	87
Дүрслэл 23. Хүчирхийлэлд өртсөн байдал (нас, хүйсээр)	88
Дүрслэл 24. Хүчирхийлэл үйлдэгдэх үед хүйтэн зэвсэг хэрэглэсэн байдал	90
Дүрслэл 25. 15-24 насныхан хүчирхийлэл үйлдэгчийг нэрлэсэн байдал	0
Дүрслэл 26. Хүүхийн эсрэг хүчирхийллийн давтамж	91
Дүрслэл 27. Хүчирхийлэлд өртөгсдөд үзүүлэх тусламж үйлчилгээ, хот хөдөөгөөр	93
	94

ТОВЧ ҮГИЙН ТАЙЛБАР

АД	- Артерийн даралт
АДИӨ	- Артерийн даралт ихсэх өвчин
АНДБЭБ	- Ази Номхон Далайн Баруун Эргийн Бус
АҮҮХ	- Анагаах Ухааны Үндэсний Хүрээлэн
АҮ	- Анагаах Ухаан
БОЭТ	- Бүсийн Оношлогоо, Эмчилгээний Төвүүд
БЖИ	- Биенэйн жингийн индекс
БҮССТ	- Биотехнологийн Үйлдвэр, Судалгаа, Сургалтын Төв
БТ	- Бүсэлхийн тойрог
БТХ	- Бүсэлхийн ташааны харьцаа
БТСҮХ	- Биенэйн Тамир, Спортын Улсын Хороо
ДЭМБ	- Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага
DM	- Diabetes Mellitus
ЗСӨ	- Зүрх судасны өвчин
IFG	- Impaired fasting glucose
IGT	- Impaired glucose tolerance
ММСС	- Монголын Мянганы Сорилтын Сан
МХШҮТ	- Мэдээлэл Хяналт Шинжилгээ Үнэлгээний Газар
МЭТ	- Бодисын солилцооны стандарт хэмжээ
МУБ	- Мөнгөн усны багана
НЭМХ	- Нийгмийн Эрүүл Мэндийн Хүрээлэн
НЭМБХЗГ	- Нийгмийн Эрүүл Мэндийн Бодлогын Хэрэгжилтийг Зохицуулах Газар
ОУ	- Олон улс
ХСҮТ	- Хавдар Судлалын Үндэсний Төв
ХБӨ	- Халдварт Бус Өвчин
CI	- Confidence interval
СБТГ	- Стратегийн Бодлого Төлөвлөлтийн Газар
СЭМҮҮТ	- Сэтгэцийн Эрүүл Мэндийн Үндэсний Төв
PDA	- Гар компьютер
ТТ	- Ташаан тойрог
ЧШӨ	- Чихрийн шижин өвчин
ЭХЗ	- Эрсдэлт хүчин зүйл
ЭМШГУИС	- Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Сургууль
ЭМГ	- Эрүүл Мэндийн Газар
ЭМЯ	- Эрүүл Мэндийн Яам
ЭША	- Эрдэм шинжилгээний ажилтан
ШГУ	- Шинжлэх Ухаан
УМ	- Удирдлагын магистр

ӨМНӨХ ҮГ

Монгол Улсын Засгийн Газар 2005 онд “Халдварт Бус Өвчин (ХБӨ)-өөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр”-ийг батлан 2013 он хүртэл хоёр үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

ХБӨ-ний эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын түвшин тогтоох аихны судалгааг 2005 онд үндэсний хэмжээнд зохион явуулсан нь “Халдварт Бус Өвчин (ХБӨ)-өөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр”-ийн суурь үзүүлэлтийг тогтоох, тандалтын тогтолцоог бурдүүлэх ажлын эх үндэс нь болсон юм.

“ХБӨ-ний эрсдэлт хүчин зүйлсийн тархалт”-ын судалгааг хавдар, осол гэмтлийн шалтгаан, тархалтын байдлыг оруулсан өргөтгэж ЭМЯ-ны харьяа Нийгмийн Эрүүл Мэндийн Хүрээлэн нь үндэсний хэмжээнд 2 дахь-удаагаа амжилттай зохион явууллаа.

Энэ удаагийн судалгааны зорилго нь Монголын Мянганы Сорилтын Сан (ММСС)-гийн Эрүүл мэндийн төслийн үйл ажиллагааны цаашдын чиглэлийг тодорхойлох, ХБӨ-өөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн дунд хугацааны явцад үнэлгээ өгөхөд чиглэгдсэн болно.

Судалгааны үр дүн нь нийт хүн амын дунд ХБӨ-өөр өвчлөх эрсдэл, хөх умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэлтийн байдал, осол гэмтэл, хүчирхийллийн цар хүрээг тодорхойлон, эдгээрээс сэргийлэх, хянах бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлэх мэдээллийн гол эх үүсвэр болохоос гадна эрдэмтэн судлаач, хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэгчдийг хэрэгцээтэй мэдээлгээр хангахад зохих хувь нэмрээ оруулна хэмээн найдаж байна.

Энэхүү судалгааны ач холбогдол нь Монгол улсад ХБӨ, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлсийн тандалтын тогтолцоог бурдүүлэх, ДЭМБ-ын ХБӨ-ний Дэлхийн Мэдээллийн Санд нэгдсэнээр Монгол хүн амын дундах эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын чиг хандлагыг бусад улс оронтой харьцуулан дүгнэлт өгөх бололцоо олгох, улмаар нотолгоонд сууриссан бодлогын арга хэмжээ, төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх чухал үндэслэл, баримт бичиг болж байгаад оршино.

Халдварт Бус Өвчин, Осол Гэмтлийн шалтгаан, Эрсдэлт Хүчин Зүйлсийн тархалтын энэхүү судалгаа нь ДЭМБ-ын техникийн тусламж, ММСС-ийн Эрүүл Мэндийн Төслийн санхүүгийн дэмжлэгт тулгуурлан, бусад холбогдох байгуулагуудын зөвлөх мэргэжилтийн үр дүнтгэй хамтын ажиллагаанд түшиглэн явагдсаныг цохон тэмдэглэж байна.

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

 С. ЛАМБАА

ХАМТРАН АЖИЛЛАСАН БАЙГУУЛЛАГУУД:

Эрүүл Мэндийн Яам
Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага
Монголын Мянганы Сорилтын Сангийн Эрүүл Мэнд Төсөл
Нийгмийн Эрүүл Мэндийн Хүрээлэн
Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их Сургууль
Анагаах Ухааны Үндэсний Хүрээлэн
Хавдар Судлалын Үндэсний Төв
Биеийн Тамир, Спортын Улсын Хороо
Гэмтэл Согог, Сэргээн Засах Клиникийн Төв
Хүүхдийн Эсрэг Хүчирхийллийн Төв
Нийслэлийн Эрүүл Мэндийн Газар
Бүсийн Оношилоогоо, Эмчилгээний Төвүүд
Дүүрэг, Аймгийн Эрүүл Мэндийн Газрууд

Судалгааны зөвлөх

Лесани Рилли, АУ-ны доктор
Дарга, ХБӨ-ний Судалгаа, Тандалтын Тогтолцоо ба Эрүүл Мэндийг дэмжих алба, ДЭМБ,
Женев

Кован Мелани, НЭМ-ийн магистр
Мэргэжилтэн, ХБӨ-ний Судалгаа Тандалтын Тогтолцоо ба Эрүүл Мэндийг дэмжих алба,
ДЭМБ, Женев

Судалгааны удирдагч

Ж. Оюунбилэг, Академич, Проф, БШУ-ны доктор
Ерөнхий Захирал, Нийгмийн Эрүүл Мэндийн Хүрээлэн

ЭМЯ-ны дэргэдэх Судалгааны Зохицуулах хороо

С.Төгсдэлгэр, *Darga*
Газрын дарга, НЭМБХЗГ, Эрүүл Мэндийн Яам

Ж.Оюунбилэг, *Orlogch darga*
Ерөнхий захирал, Нийгмийн Эрүүл Мэндийн Хүрээлэн

Г.Цэцэгдарь, *Nariin bichgiih darga*
Ахлах мэргэжилтэн, НЭМБХЗГ, Эрүүл Мэндийн Яам

Б.Бурмаа, АУ-ны доктор
Ахлах мэргэжилтэн, СБТГазар, Эрүүл Мэндийн Яам

Б.Хонгорзул
Орлогч дарга, МХШҮГазар, Эрүүл Мэндийн Яам

И.Болормаа, АУ-ны доктор
Эрдэмтэн Нарийн Бичгийн Дарга, Нийгмийн Эрүүл Мэндийн Хүрээлэн

П.Энхтуяа, АУ-ны доктор
Дэд захирал, Нийгмийн Эрүүл Мэндийн Хүрээлэн

Ж.Батжаргал, АУ-ны доктор

Захирал, Хоол Судлалын Төв, Нийгмийн Эрүүл Мэндийн Хүрээлэн
Ц.Энхжаргал, БШУ-ны доктор
Захирал, Нийгмийн Эрүүл Мэндийн Төв Лаборатори, Нийгмийн Эрүүл Мэндийн Хүрээлэн
Д.Огтонтуяа, АҮ-ны магистр
ЭША, Хоол Судлалын Төв, Нийгмийн Эрүүл Мэндийн Хүрээлэн
Б.Мөнхбат, БШУ-ны доктор
Дэд захирал, Монголын Мянганы Сорилтын Сангийн Эрүүл Мэндийн Төсөл
Ж.Энхсайхан, АҮ-ны доктор
Төслийн ажилтан, Монголын Мянганы Сорилтын Сангийн Эрүүл Мэндийн төсөл
Ж.Тунгалааг
Хэлтсийн дарга, Биеийн Тамир Спортын Улсын Хороо
Д.Нарантуяа, АҮ-ны доктор
Тэнхмийн эрхлэгч, ЭМШУИС
Х.Алтайсайхан, АҮ-ны доктор
Дэд захирал, ЭМШУИС
Д.Оюунчимэг
Дарга, Сургалт, мэдээлэл, судалгааны алба, Хавдар Судлалын Үндэсний Төвийн
В.Баярмаа
Дарга, Гадаад харилцаа, эрдэм шинжилгээ, сургалт хариуцсан алба, СЭМҮТ
Х.Нансалмаа
Нийгмийн эрүүл мэндийн эмч, Гэмтэл Согог Судлалын Үндэсний Төв
С.Энхтөр
Дарга, Олон нийттэй харилцах алба, Замын Цагдаагийн Газар
С.Говинд, НЭМ-ийн магистр
Нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн, ДЭМБ-ын Монгол дахь суурин төлөөлөгчийн газар
Б.Цогзолмаа, АҮ-ны магистр
Хөтөлбөрийн ажилтан, ДЭМБ-ын Монгол дахь суурин төлөөлөгчийн газар
Ш.Энхцэцэг, АҮ-ны доктор
Хөтөлбөрийн ажилтан, ДЭМБ-ын Монгол дахь суурин төлөөлөгчийн газар

Судалгааны багийн зохицуулагч

Д. Отгонтуяа, АҮ-ны магистр
АҮ-ны магистр, ЭША, Хоол Судлалын Төв, Нийгмийн Эрүүл Мэндийн Хүрээлэн

Судалгааны хамтарсан багийн ахлагч

И. Болормаа, АҮ-ны доктор
Эрдэмтэн нарийн бичгийн дарга, Нийгмийн Эрүүл Мэндийн Хүрээлэн
Ц. Энхжаргал, Академич
Захирал, Нийгмийн Эрүүл Мэндийн Төв лаборатори, Нийгмийн Эрүүл Мэндийн Хүрээлэн

Судалгааны багийн гишүүд

Ж. Тунгалаг

Хэлтсийн дарга, Биеийн Тамир Спортын Улсын Хороо

Б.Содгэрэл, АУ-ны доктор

ЭШАА, Анагаах Ухааны Хүрээлэн

Н. Болормаа, АУ-ны магистр

ЭША, Хоол Судлалын Төв, Нийгмийн Эрүүл Мэндийн Хүрээлэн

У.Цэрэндолгор, АШУ-ны доктор

ЭШТА, Хоол Судлалын Төв, Нийгмийн Эрүүл Мэндийн Хүрээлэн

Т. Эрдэнэзул, АУ-ны доктор

Багш, Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их Сургууль

Б. Үндармаа, АУ-ны доктор

Мэргэжилтэн, Улсын Мэргэжлийн Хяналтын Алба

С. Цэгмэд, АУ-ны магистр

ЭША, Эрүүл Ахуй, Хүний Экологийн Төв, Нийгмийн Эрүүл Мэндийн Хүрээлэн

Б.Сонинхүү, Их эмч

Хэлтсийн дарга, Нийслэлийн Эрүүл Мэндийн Газар

Б.Даваахүү, Их эмч

Мэргэжилтэн, Нийслэлийн Эрүүл Мэндийн Газар

Ж.Цогзолмаа

Мэргэжилтэн, Үндэсний Статистикийн Газар

Ж.Дэмбэрэлсүрэн, АУ-ны магистр

ЭША, Эрүүл Мэндийн Сургалт Судалгааны Төв, Нийгмийн Эрүүл Мэндийн Хүрээлэн

Д. Эрвээхэй, Их эмч

Баруун бусийн зохицуулагч, Бүсийн Оношлогоо, Эмчилгээний Төв, Ховд аймаг

Ц.Ганбат, Их эмч

Зүүн бусийн зохицуулагч, Бүсийн Оношлогоо, Эмчилгээний Төв, Дорнод аймаг

Ц.Баттүвшин, Их эмч

Дарга, Нэгдсэн Эмнэлэг, Орхон Уул аймаг

Х.Бакытжан

Ахлах мэргэжилтэн, Биеийн Тамир Спортын Улсын Хороо

Ц. Март

Мэргэжилтэн, Эрүүл Мэндийн Газар

Б. Даваадулам

ЭШДА, Хоол Судлалын Төв, Нийгмийн Эрүүл Мэндийн Хүрээлэн

А. Эрдэнэбат, Их эмч

Эрүүл Мэндийн Сургалт Судалгааны төв, Нийгмийн Эрүүл Мэндийн Хүрээлэн

Х. Цэрэнсүрэн, АУ-ны магистр

ЭШДА, БУССТ, Нийгмийн Эрүүл Мэндийн Хүрээлэн

Ц. Цэвээнсүрэн, АУ-ны магистр

ЭШДА, БУССТ, Нийгмийн Эрүүл Мэндийн Хүрээлэн

Д.Жавзандолгор
ЭШДА, Эрүүл Мэндийн Сургалт Судалгааны Төв, Нийгмийн Эрүүл Мэндийн Хүрээлэн
Х.Нансалмаа,
Нийгмийн эрүүл мэндийн эмч, Гэмтэл Согог Судлалын Үндэсний Төв
Н. Энхчимэг
Мэргэжилтэн, Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төв
Д. Оджаргал
ЭШДА, Хор Судлалын Төв, Нийгмийн Эрүүл Мэндийн Хүрээлэн
М. Оюунчимэг
ЭШДА, Экологи, Эрүүл Ахуйн Төв, Нийгмийн Эрүүл Мэндийн Хүрээлэн
Б. Хишигжаргал
Их эмч, Сүхбаатар Дүүргийн Эрүүл Мэндийн Нэгдэл
О. Алтансүх
Программын инженер, Эрүүл Мэндийн Сургалт Судалгааны Төв, Нийгмийн Эрүүл Мэндийн Хүрээлэн
Б. Дуламсүрэн
ЭШДА, Нийгмийн Эрүүл Мэндийн Төв Лаборатори, Нийгмийн Эрүүл Мэндийн Хүрээлэн
Х. Мандахцэнцэн
ЭШДА, БУССТ, Нийгмийн Эрүүл Мэндийн Хүрээлэн
Д. Оюунжаргал
Мэргэжилтэн, Баянзүрх Дүүргийн Эрүүл Мэндийн Нэгдэл
Г. Баттуяга
Мэргэжилтэн, Баянзүрх Дүүргийн Эрүүл Мэндийн Нэгдэл
Л. Лхагва
Лаборант, БУССТ, Нийгмийн Эрүүл Мэндийн Хүрээлэн
Д. Саранцэцэг
Лаборант, Баянзүрх Дүүргийн Эрүүл Мэндийн Нэгдэл
Б. Нямцэцэг
Мэргэжилтэн, Баянзүрх Дүүргийн Нэгдсэн Эмнэлэг
Н.Одшүр
Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их Сургууль
Д. Хишигбуян
ЭШДА, Нийгмийн Эрүүл Мэндийн Төв Лаборатори, Нийгмийн Эрүүл Мэндийн Хүрээлэн
Ч.Батхүү
Их эмч, Клиникийн Нэгдсэн II эмнэлэг
Б. Содномцэрэн
ЭШДА, Нийгмийн Эрүүл Мэндийн Төв Лаборатори, Нийгмийн Эрүүл Мэндийн Хүрээлэн
Д. Отгонбаяр
ЭШДА, Эрүүл Ахуй, Хүний Экологийн Төв, Нийгмийн Эрүүл Мэндийн Хүрээлэн
Л. Алтантуяа
Вирусологич, БУССТ, Нийгмийн Эрүүл Мэндийн Хүрээлэн
А. Ариунзул
Мэргэжилтэн, Хавдар Судлалын Үндэсний Төв

Статистик боловсруулалтын баг

Кован Мелани, НЭМ-ийн магистр
ДЭМБ-ын зөвлөх, ХБӨ-ний судалгаа тандалтын тогтолцоо ба Эрүүл Мэндийг дэмжих алба
ДЭМБ, Женев

Д.Огтонтуяа, АУ-ны магистр
ЭША, Хоол Судлалын Төв, Нийгмийн Эрүүл Мэндийн Хүрээлэн

О.Алтансүх
Программын инженер, НЭМХ-ийн Эрүүл Мэндийн Сургалт Судалгааны Төв

С.Цэгмэд, АУ-ны магистр
ЭШДА, Эрүүл Ахуй, Хүний Экологийн Төв, Нийгмийн Эрүүл Мэндийн Хүрээлэн

Тайлан бичсэн:

Д.Огтонтуяа, АУ-ны магистр
ЭША, Хоол Судлалын Төвийн ЭША, Нийгмийн Эрүүл Мэндийн Хүрээлэн

И.Болормаа, АУ-ны доктор
Эрдэмтэн нарийн бичгийн дарга, Нийгмийн Эрүүл Мэндийн Хүрээлэн

П. Энхтуяа, АУ-ны доктор
Дэд захирал, Нийгмийн Эрүүл Мэндийн Хүрээлэн

У.Цэрэндолгор, АШУ-ны доктор
ЭШТА, Хоол Судлалын Төв, Нийгмийн Эрүүл Мэндийн Хүрээлэн

Ж.Тунгалааг
Биеийн тамир, үндэсний спортын хөгжлийн тасгийн дарга, Биеийн Тамир Спортын Улсын
Хороо

Х. Бакытжан
Ахлах мэргэжилтэн, Биеийн Тамир Спортын Улсын Хороо

Д. Нарантуяа, АУ-ны доктор,
Зүрх судасны тэнхмийн эрхлэгч, Анагаахын Сургууль, Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны
Сургууль

Н. Болормаа, АУ-ны магистр,
ЭША, Хоол Судлалын Төвийн ЭША, Нийгмийн Эрүүл Мэндийн Хүрээлэн

Н. Нарантуяа, АУ-ны магистр
Удирдлага зохион байгуулалтын хэлтсийн дарга, Нийгмийн Эрүүл Мэндийн Хүрээлэн

Д. Оюунчимэг, АУ-ны магистр
Дарга, Сургалт Арга зүйн Алба, Хавдар Судлалын Төв

Х. Алтайсайхан, АУ-ны доктор
Дэд Захирал, Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Сургууль

Ж. Эрдэнэзул, АУ-ны доктор
Багш, Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Сургууль

Ц. Энхжаргал, БШУ-ны доктор
Захирал, Нийгмийн Эрүүл Мэндийн Төв Лаборатори, Нийгмийн Эрүүл Мэндийн Хүрээлэн

Ш. Нансалмаа

НЭМ-ийн эмч, Гэмтэл Согог Судлалын Үндэсний Төв

Б. Бадамцэцэг

Захирал, Хүүхдийн Эсрэг Хүчирхийллийн Төв

Б. Сүх-Очир

Гүйцэтгэх захирал, Мэргэжлийн Нийгмийн Ажилтны Нийгэмлэг

М. Де. Коуртен, Профессор

Копенхаген Нийгмийн Эрүүл Мэндийн Сургууль, Дани

Чернан Варгхез, АУ-ны доктор

Зөвлөх мэргэжилтэн, Номхон Далайн Баруун Эргийн Бүс, ДЭМБ

Хэвлэлийн эх бэлтгэсэн:

Ц.Гангандэцэг

Тайлан орчуулсан:

С.Төгсдэлгэр, НЭМ-ийн магистр

Дарга, Нийгмийн Эрүүл Мэндийн Бодлого Зохицуулалтын Газар, ЭМЯ

Хянан тохиолдуулсан:

Л. Лхагва, Академич, АШУ-ны доктор

Захирал, Эм Судлалын Хүрээлэн

Г. Цэцэгдарь, АУ-ны доктор

Ахлах мэргэжилтэн, Нийгмийн Эрүүл мэндийн Бодлого Зохицуулалтын Газар, ЭМЯ

П. Энхтуяа, АУ-ны доктор

Дэд захирал, Нийгмийн Эрүүл Мэндийн Хүрээлэн

Жич: Судалгаанд хамаарах асуудлаар та бүхний санал зөвлөгөө манай ажилд үнэтэй хувь нэмэр оруулах учраас үзэл бодлоо дараах хаягаар ирүүлбэл бил баяртайгаар хүлээн авч цаашдын судалгаандаа тусгах болно.

ХАЯГ: ЭМЯ-ны харьяа Нийгмийн Эрүүл Мэндийн хүрээлэн

Энх тайвны гудамж-17, Улаанбаатар-210349

E-mail: , pubhealth@magicnet.mn

jobileg@magicnet.mn

ТОВЧ ХУРААНГУЙ

ХАЛДВАРТ БУС ӨВЧИН, ОСОЛ ГЭМТЛИЙН ШАЛТГААН, ЭРСДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ТАРХАЛТЫН түвшин тогтоох судалгаа нь ХБӨ-өөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн дунд хугацааны үнэлгээг хийх, Монголын Мянганы Сорилтын Сангийн Эрүүл Мэнд төслийн суурь үзүүлэлтүүдийг тодорхойлох зорилгоор хийгдсэн үндэсний хэмжээний судалгаа болно.

Энэхүү нэгэн агшингийн судалгаанд ДЭМБ-ын боловсруулсан “Шаталсан” судалгааны арга аргачлалыг өөрийн орны онцлогт тохируулан боловсруулж ашиглалаа. Судалгаагаар ХБӨ, осол гэмтлийн шалтгаан, эрсдэлт хүчин зүйлсийн тархалтыг ДЭМБ-аас батлагдсан аргуудаар тодорхойлж, энэ чиглэлээр цаашид хийгдэх үйл ажиллагааны чиглэлийг гаргах зорилгоор дараах зорилтуудыг дэвшүүллээ. Үүнд:

- ХБӨ-ний анхдагч эрсдэлт хүчин зүйлс, осол гэмтлийн шалтгаан, тархалтын түвшинг тодорхойлох
- Цусны даралт ихсэлт, илүүдэл жин, таргалалтын тархалт, цусан дахь холестерин, сахарын хэмжээ ихсэлтийн түвшинг тогтоох
- ХБӨ-ний эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын чиг хандлагыг өмнөх судалгааны дунтэй харьцуулан судлах

Судалгаанд Монгол улсын 20 аймгийн 36 сум, Улаанбаатар хотын 6 дүүргийн 15-64 насны нийт хүн амын дундаас санамсаргүйгээр сонгогдсон 5638 хүн хамрагдлаа. Судалгааны мэдээлэл цутгуулах ажлыг хөдөө орон нутагт 2009 оны 10-р сар, Улаанбаатар хотод 12-р сард зохион байгуулж явуулав.

Судалгааны бүхий л үе шатны мэдээллийг PDA буюу гар компюүтер ашиглан пүглүүлав. Судалгааны түүврийн хүн амын мэдээллийг Монгол улсын нийт хүн амыг төлөөлөхүйц байхаар жинзэн, нас хүйсээр тохируулга хийж судалгааны үр дунд оруулан тоодсон болно. Мэдээллийн үр дүнгийн статистик боловсруулалтыг EPI INFO 3.5.1 программд түшиглэн хийв. ХБӨ-ний эрсдэлт хүчин зүйлсийн байдал нь хүн амын дундаас тархалтын хувь ба дундаж үзүүлэлтээр илэрхийлэгдэж гарлаа. Үр дүнгийн нарийвчлалын хэмжүүр (тархалтын хувь болон дундажийн хэлбэлзэл) болоод бүлгүүдийн (нас, хүйс, хот хөдөө) ялгааг тодорхойлоход 95 хувийн итгэх хязгаар (95%CI)-ын хэлбэлзлийн утгуудыг ашиглав.

Судалгааны дүнгээр нийт хүн амын 27.7 хувь, үүнээс эрэгтэйчүүдийн 48.0 хувь, эмэгтэйчүүдийн 6.9 хувь нь тамхи татдаг байна. Тамхи хэрэглэгсдийн ихэнх нь (87.9%) тамхийг өдөр бүр тогтмол татдаг байв. Судалгаанд хамрагдсан 2 хүн тутмын 1 нь (42.9%) гэрийн дотоод орчинд, 3 хүн тутмын 1 нь (35.6%) ажлын байрандаа дам тамхидалтад өртөж байна.

Хүн амын 38.6 хувь сүүлийн 1 сард архи согтууруулах ундаа хэрэглэсэн нь эрэгтэйчүүдэд 49.8 хувь, эмэгтэйчүүдэд 27.2 хувь байна. Архи, согтууруулах ундаа хэрэглэгсэд нэг удаад уухдаа дундажаар 7.7 уулт, үүнээс эрэгтэйчүүд 9.2, эмэгтэйчүүд 5.1 стандарт уултын хэмжээний архийг ууж хэрэглэжээ.

Эрэгтэйчүүдийн 39.7 хувь, эмэгтэйчүүдийн 15.1 хувь нь архийг хэтрүүлэн хэрэглэдэг дадалтай байв.

Монголын хүн ам хоногт дундажаар 1.8 нэгж жимс, хүнсний ногоо хэрэглэж байгаа нь ДЭМБ-ын зөвлөмж хэмжээнээс 3.2 нэгжээр доогуур байна. Хүн амын ихэнх хувь (92.3%) нь хоногт 5 нэгжээс бага жимс, хүнсний ногоо хэрэглэж байна. Хөдөөгийн хүн амын жимс, хүнсний ногооны хэрэглээ нь хотын хүн амынхаас 2 дахин бага байна. Хүн амын давсны хоногийн

дундаж хэрэглээ 7.3 грамм байгаа бөгөөд хөдөөгийн хүн амын давсны хэрэглээ хотын хүн амынхаас 1,6 граммаар их байна.

Нийт хүн амын 7.5 хувийг хөдөлгөөний хомсдол бүхий эрсдэлт бүлэг эзэлж байгаа бөгөөд хотын 10 хүн тутмын 1 нь энэхүү эрсдэлд өргсөн байв. Хөдөөгийн эрэгтэйчүүдээс хотын эрэгтэйчүүд 4, эмэгтэйчүүд 2 дахин илүү хөдөлгөөний хомсдолд орох эрсдэлтэй байна. Хүн амын хоногт идэвхтэй хөдөлгөөнд зарцуулах голч хугацааг тооцоход ажлын байранд 214.2 минут, ирж очих хөдөлгөөнд 30.0 минут, амралт чөлөөт цагаар 51.4 минут тус тус зарцуулдаг байв.

Хүн амын БЖИ-ийн дундаж хэмжээ 24.6 кг/м² байгаа ба эрэгтэйчүүдэд 24.3кг/м², эмэгтэйчүүдэд 24.9 кг/м² тус тус байна. БЖИ-ийн эрсдэлийн үнэлгээгээр нийт хүн амын 39.8% илүүдэл жинтэй ба үүнээс 12.5% нь таргалалттай байна. Илүүдэл жин ба таргалалтын тархалт нас ахих тутам нэмэгдэх хандлагатай байгаа бөгөөд бүх насны бүлэгт илүүдэл жин, таргалалттай эмэгтэйчүүдийн эзлэх хувь эрэгтэйчүүдээс харьцангуй өндөр байв. Эрэгтэйчүүдийн 29.1 хувь, эмэгтэйчүүдийн 55.7 хувь бүсэлхийн таргалалттай байна.

Судалгааны насны нийт хүн амын 25.0 хувьд цусан дахь нийт холестерины хэмжээ ихсэх эрсдэлтэй ба ихэссэн, үүнээс 8.5 хувьд нь холестерины түвшин ихэссэн узуулэлттэй байна. Цусан дахь триглицеридын хэмжээ ихсэх эрсдэлтэй ба ихэссэн хүн амын тархалт 22.4 хувь байсан ба энэхүү эрсдэл эрэгтэйчүүдийн дунд (29.5%) эмэгтэйчүүдээс (15.4%) их байна. Цусан дахь бага нягттай липопротеины хэмжээ ихэссэн болон ихсэх эрсдэлтэй хүн амын тархалт өндөр (62.7%) байгаа нь анхаарал татаж байна. Их нягттай липопротеины түвшин эрсдэлтэй хэмжээнд хүрсэн эмэгтэйчүүдийн хувь эрэгтэйчүүдээс 2.7 дахин их байна.

Судалгааны насны эрэгтэйчүүдийн систолын артерийн даралт (САД)-ын дундаж хэмжээ 129.8 мм/МУБ, эмэгтэйчүүдэд 121.4 мм/ МУБ байсан ба САД-ын түвшин эрэгтэйчүүдэд эмэгтэйчүүдээс өндөр байна. Хүн амын дунд артерийн гипертензийн тархалт 27.3 хувь байна. Эрэгтэйчүүдийн дунд АГ-ийн тархалт илүү байна. Артерийн гипертензийн тархалт нь хот хөдөөд ижил байв.

Хүн амын өлөн цусан дахь сахарын дундаж хэмжээ 4,7 ммоль/л байгаа нь хүйсийн ялгаагүй байв. Энэ узүүлэлт нь хотын хүн амд 4,9 ммоль/л, хөдөөд 4,6 ммоль/л буюу хотод харьцангуй өндөр байлаа. Өлөн цусан дахь сахарын өөрчлөлттэй хүн амын тархалт 9,5 хувь, үүнээс эрэгтэйчүүдэд 11,5 хувь, эмэгтэйчүүдэд 7,5 хувь байна. Өлөн цусанд сахарын хэмжээ ихэссэн ба сахар бууруулах эм хэрэглэж буй хүн амын тархалт 6,5 хувь байгаа ба эрэгтэйчүүдэд 8,9 хувь, эмэгтэйчүүдэд 4,1 хувь байв.

Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн 5.2 хувь нь цууны хүчлийн сорилд, 11.4 хувь нь РАР сорилд хамрагдсан үзүүлэлтээс хараад умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэлтийн хамралтын хувь хэт доогуур байна. Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэлтийн шинжилгээнд 35-54 насны эмэгтэйчүүд илүү хамрагдаж байгаа нь манай улсад умайн хүзүүний өмөнгийн өвчлөл хамгийн өндөр байгаа настай дүйж байна. Судалгааны насны 3 эмэгтэй тутмын 1 нь хөхөө өөрөө шинждэг, зөвхөн 3.2 хувь хөхийг эмнэл зүйн аргаар шинжлүүлдэг, 1.7 хувь нь маммаграфийн шинжилгээнд, хамрагдсан нь хөхний хорт хавдрын эрт илрүүлэлтийн хамралт хангалтгүй байгааг харуулж байна. Хөх, умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэлтийн шинжилгээнд хамрагдсан байдал хот хөдөөд ялгаагүй байна.

Судалгааны хүн амын 4 хувь нь сүүлийн 12 сард зам тээврийн осолд өргсөн гэжээ. Зам тээврийн осолд өргсөн 5 хүн тутмын 1 нь (22.7%) замын хөдөлгөөнд хурд хэтрүүлснээс, 10 хүн тутмын 1 нь (9.1%) согтууруулах ундаа хэрэглэсэнээс үдэн осолд өргсөн байна. Тээврийн хэрэгслээр жолооч болон зорчигч байдлаар замын хөдөлгөөнд оролцсон 10 хүн тутмын 8 нь (83.6%) хамгаалалтын бус тогтмол хэрэглэдэггүй буюу огт бүсэлдэггүй байв.

Судалгааны хүн амын 3,5 хувь, үүнээс эрэгтэйчүүдийн 4.4 хувь, эмэгтэйчүүдийн 2.5 хувь нь сүүлийн 12 сард хүчирхийлэлд өртөж эмнэлгийн тусlamж авчээ. Эрэгтэйчүүд, эрэгтэйчүүдийнхээ хүчирхийлэлд илүү өртдөг нь үзэл бодлын зөрүүг ч өөр хоорондоо хүч хэрэглэх аргаар шийдвэрлэдэг зан үйлтэй холбон тайлбарлаж болохор байна. Харин, хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн 38.6 хувь нь гэр бүл, дотно хүнийхээ, 24.2 хувь нь танил найз нөхдийнхээ хүчирхийлэлд өртжээ. Судалгаанд оролцогчдын 62,3 хувь нь хүүхэд насандаа хүчирхийлэлд өртдөг байсан гэжээ.

Халдварт бус өвчиний нийтлэг эрсдэлт хүчин зүйлсийн тархалтыг өмнөх судалгааны дунтэй харьцуулахад тамхи таталтын тархалт хүн амын дунд тогтвортой, буурах хандлага ажиглагдахгүй байв. Эмэгтэйчүүдийн тамхи татаж эхэлсэн дундаж нас залуужиж байна. Сүүлийн 12 сард архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн амын эзлэх хувь буурсанч, архи хэрэглэж буй хүмүүсийн хэрэглээний давтамж аажмаар нэмэгдэж буй хандлага ажиглагдаа.

Харьцуулсан судалгааны дунгээр, өнгөрсөн 4 жилд хүн амын хоногт хэрэглэх жимсний дундаж хэрэглээ 2 дахин (0.8 ба 0.4 нэгж), хүнсний ногооны хэрэглээ (1.6 ба 1.3 нэгж) 20 хувиар буурсан байна. Хүн амын хоногт идэвхтэй хөдөлгөөнд зарцуулж буй голч хугацаа (181.4 мин ба 347.1 мин) болон идэвхтэй хөдөлгөөн бүхий хүн амын тархалт (70.4% ба 81.8%) нэмэгдсэн хэдий ч хөдөлгөөний хомсдолтой хүн амын бүлэгт төдийлөн өөрчлөлт гарсангүй.

Насанд хүрэгсдийн биеийн жингийн индексийн дундаж түвшин нэмэгдэж, илүүдэл жин ба таргалалтын тархалт 8.3 хувь, үүнээс таргалалтын тархалт 2.7 хувиар тус тус өссөн байна. Цусан дахь холестерины дундаж хэмжээ болон холестерины хэмжээ ихсэх эрсдэлтэй ба ихэссэн хүн амын тархалтад өөрчлөлт гараагүй, тогтвортой байна.

Артерийн гипертензийн тархалт өөрчлөгдөөгүй, тогтвортой байгаа ч arterийн гипертензи бүхий хүн амын эмийн эмчилгээнд хамрагдах байдал буурсан байна. Насанд хүрсэн хүн амын өлөн цусан дахь сахарын дундаж хэмжээ болон цусны сахарын хэмжээ ихэссэн ба сахар бууруулах эм хэрэглэж буй хүн амын тархалт өмнөх судалгааны дунгээс өөрчлөгдөөгүй, тогтвортой хэвээр байна.

ДЭМБ-ын аргачлалын дагуу дээрх эрсдэлт хүчин зүйлсээс өдөр бүр тогтмол тамхи татдаг хүн ам, хоногт 5 нэгжээс бага жисим, хүнсний ногоо хэрэглэж буй хүн ам, хөдөлгөөний хомсдолтой хүн ам, илүүдэл жин ба таргалалтай хүн ам болон цусны даралт ихтэй хүн амын эзлэх хувь зэрэг 5 нийтлэг эрсдэлт хүчин зүйлсийн хавсран тохиолдсон байдлаар нийт хүн ам болоод хүн амын бүлгүүдийн ХБӨ-өөр өвчлөх эрсдлийн зэргийг тодорхойлдог.

Энэхүү үнэлгээгээр монгол 5 хүн тутмын 1-д (26.4 хувь), 45-с дээш насын 2 хүн тутмын 1-д (53.8 хувь) ХБӨ-ний 3-аас дээш эрсдэл хавсран тохиолдож байгаа буюу өвчлөх өндөр эрсдэлтэй байна. Эмэгтэйчүүдтэй харьцуулахад, (26.0% ба 12.4%) залуу насын (15-34 нас) эрэгтэйчүүдэд (26.0% ба 12.4%) ХБӨ-өөр өвчлөх өндөр эрсдэл 2 дахин их байна.


**Халдварт Бус Өвчин, Осол Гэмтлийн Шалтгаан, Эрдэлт Хүчин
Зүйлсийн Тархалтын Судалгаа-2009**

Үр дүнгийн хүснэгт

Халдварт бус өвчин, осол гэмтлийн шалтгаан, эрдэлт хүчин зүйлсийн тархалтын судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг 2009 оны 10 - 12 дугаар сард Монгол улсын нийт аймаг, хотуудыг хамруулан явууллаа. Судалгааны мэдээллийн 3 шаталалаар цуглувсанас, I шатлагд нийгэм эдийн засаг, зан улсын талаарх мэдээллийг асуулжсийн, II шатлагд биеийн жин, ондөр, үснэг дараалтыг бие махбодийн хэмжилтийн, III шатлагд цусан дахь глюкоз, холестерин, триглицерид, их нягттай липопротеид, бага нягттай липопротеидын түвшинг биохимийн шинэжилгээний аргаар тодорхойллоо. Судалгаанд Монгол улсын 15 - 64 наасны нийт хүн амыг төлөвлөхүүц 5438 хүн хамрагдас. Судалгааны хамралтын хувь 95% байлаа. Давтан судалгаа 2013 онд хийгдэнэ.

15-64 наасны хүн амын судалгааны үр дүн (95% CI)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
I шат: Тамхины хэрэглээ			
Тамхи таталтын тархалт	27.6% (26.0 - 29.4)	48.0% (44.5 - 51.5)	6.9% (5.2 - 8.5)
Өдөр бүр тамхи татдаг хүний эзлэх хувь	24.3% (22.9 - 25.7)	43.0% (39.9 - 46.0)	5.2% (3.8 - 6.7)
Өдөр бүр тамхи татдаг хүмүүсийн дотор:			
Тамхи хэрэглэж эхэлсэн дундаж нас (жилээр)	19.2 (18.7-19.6)	18.7 (18.2-19.2)	23.2 (21.3-25.1)
Үйлдвэрийн тамхи өдөр бүр хэрэглэгчдийн эзлэх хувь	84.6% (78.8-90.3)	84.3% (78.3-90.2)	86.9% (72.7-100.0)
Өдөрт татдаг үйлдвэрийн тамхины дундаж тоо (үйлдвэрийн тамхи хэрэглэгчдийн дунд)	8.7 (7.8-9.6)	8.9 (7.9-9.8)	7.0 (5.6-8.4)
Архины хэрэглээ			
Амьдралынхаа туршид архи, согтууруулах ундаа огт хэрэглэгүй хүн амын эзлэх хувь	34.2% (28.7 - 39.6)	24.0% (19.3 - 28.8)	44.5% (38.1 - 51.0)
Сүүлийн 12 сарын туршид архи, согтууруулах ундаа огт хэрэглэгүй хүн амын эзлэх хувь	7.4% (5.7 - 9.1)	6.0% (4.4 - 7.7)	8.8% (6.6 - 11.0)
Сүүлийн 30 хоногт архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн амын эзлэх хувь	38.6% (34.6 - 42.7)	49.8% (44.7 - 54.8)	27.2% (23.0 - 31.3)
Архи, согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэсэн хүн амын эзлэх хувь (Сүүлийн 30 хоногт, 1 удаагийн уултаар эрэгтэйчүүд ≥5, эмгэгчийчүүд ≥4 стандарт уултын хэмжэгчээр хэрэглэсэн)	--	39.7% (35.0 - 44.4)	15.1% (12.4 - 17.7)
Жимс, хүнсний ногооны хэрэглээ			
Жимс хэрэглэсэн өдрийн дундаж тоо	1.2 (1.0-1.3)	1.0 (0.7-1.2)	1.4 (1.2-1.6)
Хоногт хэрэглэсэн жимсний дундаж хэмжээ, нэгжээр	0.4 (0.3-0.5)	0.3 (0.2-0.5)	0.5 (0.4-0.6)
Хүнсний ногоо хэрэглэсэн өдрийн дундаж тоо	4.8 (4.3-5.3)	4.6 (4.1-5.2)	4.9 (4.5-5.4)
Хоногт хэрэглэсэн хүнсний ногооны дундаж хэмжээ, нэгжээр	1.4 (1.2-1.7)	1.4 (1.1-1.6)	1.5 (1.3-1.8)
Хоногт дундажаар 5 нэгжээс бага жимс, хүнспий ногоо хэрэглэсэн хүн амын эзлэх хувь	92.3% (88.7-95.8)	93.4% (89.9-96.9)	91.1% (87.4-94.8)
Хөдөлгөөний идэвхий			
Хөдөлгөөний хомдолтой хүн амын эзлэх хувь (7 хоногт < 600 MET-минут)*	7.5% (5.2-9.9)	7.4% (4.7-10.1)	7.7% (5.3-10.1)
Бисийн хүч их шаардсан хөдөлгөөн хийдэг хүн амын эзлэх хувь (7 хоногт ≥ 3000 MET-минут)*	80.8% (75.7-85.8)	82.5% (77.7-87.4)	78.9% (72.9-85.0)
Хоногт идэвхитгэй хөдөлгөөн хийхэд зарцуулдаг дундаж голч хугацаа (минут)	342.9 (158.6-510.0)	347.1 (171.4-501.4)	337.1 (141.4-518.6)
Бисийн хүч их шаардсан хөдөлгөөн хийдэгтүй хүн амын эзлэх хувь	48.5% (43.3-53.6)	42.9% (37.3-48.4)	54.2% (48.5-59.8)

15-64 наасны хүн амын судалгааны үр дүн (95% CI)	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
ІҮРДЛЭН НАМДАЛТЫН ДҮНДАЖ ХЭМЖЭЭ			
Биенийн жингийн индекс - БЖИ (кг/м2)	24.6 (24.3-24.9)	24.3 (24.0-24.7)	24.9 (24.6-25.2)
Илуудэлжинтэй хүний эзлэх хувь, (БЖИ \geq 25кг/м2)	39.8% (37.1-42.5)	37.0% (33.0-41.0)	42.7% (39.9-45.5)
Таргалалттай хүний эзлэх хувь, (БЖИ \geq 30кг/м2)	12.5% (10.8-14.3)	11.1% (8.7-13.4)	14.1% (12.1-16.0)
Бүсэлхийн тойргийн дундаж хэмжээ	--	83.2 (82.2-84.3)	82.6 (81.7-83.5)
Систолын артерийн даралтын дундаж хэмжээ (мм.муб),	125.6 (124.3-126.9)	129.8 (128.4-131.1)	121.4 (120.0-122.8)
Диастолын артерийн даралтын дундаж хэмжээ (мм.муб)	78.9 (78.1-79.6)	79.6 (78.7-80.5)	78.1 (77.3-78.9)
Артерийн даралт ихэссэн хүний эзлэх хувь (САД \geq 140 мм.муб ба/эсвэл ДАД \geq 90 мм.муб болон даралт бууруулах эм хэрэглэдэг)	27.3% (24.9-29.8)	31.4% (28.2-34.6)	23.2% (20.7-25.7)
Артерийн даралт ихэссэн хүн амын дунд даралт бууруулах эм хэрэглэдэгтүй хүний эзлэх хувь, (САД \geq 140 мм.муб ба/эсвэл ДАД \geq 90 мм.муб)	61.1% (56.4-65.8)	71.9% (66.6-77.2)	46.0% (40.8-51.1)
ІҮРДЛЭН БИОХИМИЙН ШИНЖИЛГЭЭ			
Цусан дахь сахарын дундаж хэмжээ (ммоль/л)	4.7 (4.6-4.9)	4.8 (4.6-5.0)	4.7 (4.5-4.8)
Цусан дахь сахарын хэмжээ ихсэх эрдэлтэй хүн амын эзлэх хувь (захын цусан дахь сахар \geq 5.6 ммоль/л буюу > 6.1ммоль/л)	9.4% (7.4-11.5)	11.5% (8.5-14.5)	7.5% (4.5-10.4)
Цусан дахь сахарын хэмжээ ихсээн болон сахар бууруулах эм хэрэглэж буй хүний эзлэх хувь (захын цусан дахь сахар \geq 6.1ммоль/л)	6.5% (4.5-8.4)	8.9% (5.0-12.7)	4.1% (2.1-6.2)
Цусан дахь холестерины дундаж хэмжээ	5.0 (4.9-5.1)	5.1 (5.0-5.1)	5.0 (4.9-5.0)
Цусан дахь холестерины хэмжээ ихсэх эрдэлтэй буюу ихэссэн хүн амын эзлэх хувь (холестерин \geq 5.0ммоль/л)	41.7% (37.4-46.0)	43.8% (38.0-49.5)	39.8% (35.0-44.5)
ХБӨ-НИЙ ВИЙГЛЭГ ЭРДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛС:			
<ul style="list-style-type: none"> • Өдөр бүр тогтолцоо замхи татдаг хүн ам • Хоногт 5-аас бага нэгж жимс, ногдоо хэрэглэдэг хүн ам • Биенийн хүч бага шаардсан хөдөлгөөн хийдэг буюу хөдөлгөөний хомдолтой хүн ам • Илуудэлжин ба таргалалттай хүн ам (БЖИ \geq 25 кг/м2) • Артерийн даралт ихэссэн хүн ам (САД \geq 140 ба/эсвэл ДАД \geq 90 мм.муб эсвэл даралт бууруулах эм хэрэглэж байгаа) 			
Дээр дурьдсан эрдэлт хүчин зүйлс огт илрээгүй хүн амын эзлэх хувь	3.0% (1.7-4.2)	1.9% (0.8-3.1)	4.0% (2.4-5.6)
Дээрх эрдэлт хүчин зүйлсээс 3 ба түүнээс олон эрдэл илрэсэн 15 – 44 наасны хүн амын эзлэх хувь	19.4% (17.3-21.5)	26.0% (23.1-28.8)	12.4% (9.9-14.8)
Дээрх эрдэлт хүчин зүйлсээс 3 ба түүнээс олон эрдэл илрэсэн 45 – 64 наасны хүн амын эзлэх хувь	53.8% (49.4-58.1)	61.4% (55.4-67.3)	46.1% (41.7-50.5)
Дээрх эрдэлт хүчин зүйлсээс 3 ба түүнээс олон эрдэл илрэсэн 15 – 64 наасны хүн амын эзлэх хувь	26.4% (24.1-28.7)	33.1% (30.3-35.9)	19.4% (16.9-21.9)



БҮЛЭГ I
ҮНДЭСЛЭЛ, СУДЛАГДСАН БАЙДАЛ

Халдварт бус өвчин дэлхий дахинд

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын (ДЭМБ) 2008 оны мэдээгээр халдварт бус өвчин (ХБӨ) болох зүрх судасны өвчин, чихрийн шижин, амьсгалын замын архаг өвчлөл, хорт хавдар нь дэлхийн хүн амын нас баралтын шалтгааны 60 хувь, бага, дунд орлоготой орнуудын хүн амын нас баралтын шалтгааны 80 хувийг эзэлж байна Түүнчлэн, 2030 он гэхэд тамхидалтаас шалтгаалсан нас баралт бага, дунд орлоготой улс орнуудад 2 дахин ёсч 6,8 саяд хүрэх, хорт хавдраас үүдэлтэй нас баралт 11,8 сая болтлоо нэмэгдэх тооцоо гараад байна [3].

Хэдийгээр ийм тооцоо судалгаа байвч ХБӨ-өөс сэргийлэх боломжтойг олон орны туршилага харуулж байна. Амьдралын хэв маягаа өөрчилж, зохистой хооллон, биеийн жингээ тогтмол хэмжээнд байлгаж, архи, тамхины хэрэглээг багасгаснаар зүрх судасны өвчиний өвчлөл, нас баралтыг 80 хувь, 2-р хэв шинжийн чихрийн шижингт 90 хувь хүртэл бууруулах боломжтой нь тогтоогдоод байна. Энэчлэн зохистой хооллож, биеийн жингээ хэвийн түвшинд барьж амьдралынхаа туршид идэвхитэй хөдөлгөөнийг эрхэмлэвэл хорт хавдрын тохиолдлыг 1/3-р бууруулж болно хэмээн үзэж байна [9].

Монгол улс дахь ХБӨ-ний өвнөгийн байдал

Манай улсын хүн амын өвчлөлийн хэв маягт 1990-ээд оноос эхлэн тархвар зүйн өөрчлөлт орж, зан үйл, нийгмийн хүчин зүйлээс шалтгаалсан өвчлөлүүд болох цусны эргэлтийн тогтолцооны өвчин, чихрийн шижин, хорт хавдар, осол гэмтлийн шалтгаант өвчлөл давамгайлах болж улмаар хүн амын нас баралтын шалтгааны эхний байруудыг эзэлж жил ирэх тутам эдгээр өвчиний улмаас нас барсан хүний тоо нэмэгдсээр байна.

Хүн амын нас баралтын тэргүүлэх 5 шалтгааныг 2008 оны байдлаар 10 000 хүн амд тооцсоноор авч үзвэл:

- Цусны эргэлтийн тогтолцооны өвчин - 20.5
- Хавдар - 11.8
- Бэргэл хордлого гадны шалтгаант үр дагавар - 9.3
- Хоол боловсруулах тогтолцооны өвчин - 5.3
- Төрөх тойрны (перинаталь) үед үүсэх оёг - 2.4 байна.

Цусны эргэлтийн тогтолцооны өвчлөл, нас баралт нь манай улсын хүн амын өвчлөл, нас баралтын шалтгааны эхний байрыг тогтмол эзэлж байгаа бөгөөд жил бүр (2008 он) нас барж буй 3 хүний нэг нь энэ өвчинеөс улбаатай байна [1].

Хорт хавдрын дотор, умайн хүзүүний өмөн нь эмэгтэйчүүдэд тохиолдох хорт хавдрын хөөрдугаар байранд орох болж 2000-2008 онд 100 000 хүн амд ноогдох умайн хүзүүний хорт хавдрын тархалтын түвшин 38.8-68.4, өвчлөлийн түвшин 6.6-15.5, нас баралтын түвшин 3.4-4.0 болж тус тус нэмэгдсэн байна.

Хөхний өмөнгийн өвчлөл саяхан болтол нэн ховор өвчиний тоонд орж байсан бол суулийн жилүүдэд монгол эмэгтэйчүүдийн хөхний өмөнгийн өвчлөл жилээс жилд (2000-2008 он) нэмэгдэж нийт хорт хавдрын зургадугаар байранд буюу зонхilon тохиолдох хавдрын тоонд орж 100.000 хүн амд ноогдох тархалтын түвшин 12.5-20.6, өвчлөлийн түвшин 2.5-3.6, нас баралтын түвшин 0.8-1.3 болтлоо тус тус нэмэгдсэн байна.

Осол гэмтэл. Дэлхий дахинаа жил бүр 5 сая гаруй, өдөрт дундажаар 16 000 хүн осол, гэмтлийн улмаас амь насаа алдаж, үүнээс хэдэн мянга дахин олон хүн үүрдийн тахир дуттуу болж байна. Манай улсад осол, гэмтлээр нас барах тохиолдол сүүлийн жилүүдэд эрс нэмэгдэж, 1990 онд хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгааны дотор 5 дугаарт орж байсан бол 2000 оноос

хойш тогтмол 3 дугаарт орох болсон байна. Осол гэмтлийн шалтгаант нас баралтыг төрлөөр авч үзвэл 19.7% нь зам тээврийн осол, 16.3% нь амиа хорлох, 10.4% нь бусдад хорлогдсон ба 46.9% нь бусад ослоор нас баржээ [13].

Хүчирхийлэл. Монголд жендэрт суурилсан хүчирхийлэл болон хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаар хийсэн зарим судалгааны дүнгээр 3 эмэгтэй тутмын 1 нь хүчирхийллийн ямар нэгэн хэлбэрт өртдөг, 10 эмэгтэйн нэг нь зодуулдаг, 5 гэр бүл тутмын нэг нь хүчирхийллийн харилцаатай, 2 хүүхэд тутмын нэг нь хүчирхийлэлд өртдөг, 4 ахмад настны нэг нь гэр бүлийн хүчирхийлэлд өртдөг байна. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас шүүх эмнэлэлт хандагсдын дотор хүнд болон хүндэвтэр гэмтэлтэй хүний тоо өмнөх жилүүдээс 2,5 дахин ессен байна [12].

ХБӨ-ний зан үйлийн анхдагч ба хоёрдогч эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын байдал

“Халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын түвшин тогтоох судалгаагаар (2005 он) манай хүн амын 24.2 хувь нь өдөр бүр тогтмол тамхи хэрэглэдэг, хоногт 5 нэгжээс бага жимс, хүнсний ногоо хэрэглэдэг хүн амын тархалт 72.5 хувь, биеийн хүч бага шаардсан хөдөлгөөн хийдэг буюу хөдөлгөөний хомсдолтой хүн ам 23.1 хувь тус тус байв. Энэхүү судалгаагаар хүн амын 21.8 хувь нь илүүдэл жинтэй, 9.8 хувь нь тарган байсан байна. АДИӨ-ний тархалт 28.1 хувь, ЧШӨ-ний тархалт 8.2 хувь тус тус байжээ [2].

Энэ удаагийн судалгаагаар ХБӨ, осол гэмтлийн шалтгаан, эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын өнеогийн байдлыг тогтоож, улмаар ХБӨ-өөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад үнэлгээ өгэх, Монгол дахь МСС-ийн Эрүүл Мэндийн Төсөл хэрэгжих суурь үзүүлэлтүүдийг тодорхойлох шаардлагатай байлаа.

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

ХБӨ, осол гэмтлийн эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын одоогийн түвшин, чиг хандлагыг Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын батлагдсан арга аргачлалын дагуу тогтоож, ХБӨ, осол гэмтлээс сэргийлэх ажлын цаашдын төлөвийг тодорхойлоход чиглэнэ.

ЗОРИЛТУУД

- ХБӨ-ний анхдагч эрсдэлт хүчин зүйлс, осол гэмтлийн шалтгаан, тархалтын түвшинг тодорхойлох
- Цусны даралт ихсэлт, илуудэл жин, таргалалт, гиперхолестеринеми, гипергликемийн тархалтын түвшинг тогтоо
- ХБӨ-ний эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын чиг хандлагыг өмнөх судалгааны дүнтэй харьцуулж үнэлэх

АЧ ХОЛБОГДОЛ, ШИНЭЛЭГ ТАЛ

- Судалгаа нь ХБӨ-өөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөрийн явцад үнэлгээ өгөх, цаашдын үйл ажиллагааны чиглэлийг тодруулах үндэслэл болох төдийгүй ММСС-ийн Эрүүл Мэндийн төслийн үйл ажиллагаа хэрэгжих суурь үзүүлэлтүүдийг гаргана.
- Олон Улсын хэмжээнд баталгаажсан нэгдсэн арга зүйг өөрийн орны нөхцөлд тохируулан нэвтрүүлснээр эрүүл мэндийн судалгааны хөгжилд тодорхой хувь нэмэр оруулсан төдийгүй тоо баримтыг бусад орныхой харьцуулах боломжийг олгож байна.
- Судалгаанд ДЭМБ-ын “Шаталсан аргачлал” (STEPS), орчин үеийн программ хангамж, лаборатори болон статистик дүн шинжилгээний аргуудыг ашиглан эрсдэлт хүчин зүйлсийн түвшинг тодорхойлж, шинжлэх ухааны үндэстэй бодит тоо, баримтыг судлан тогтоосноор бодлого боловсруулагчид, хөтөлбөр, төслийн зохицуулагчдыг нотолгоонд суурилсан тоо баримтаар хангах юм.

БҮЛЭГ II
СУДАЛГААНЫ АРГА, АРГАЧЛАЛ

1. Судалгааны хүрээ

Монгол улсын засгийн газраас хэрэгжүүлж буй “ХБӨ-ний эрсдэлт хүчин зүйлсээс сэргийлэх, хянах” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн дунд хугацааны үнэлгээг хийх, Монголын Мянганы Сорилтын Сангийн Эрүүл Мэндийн төслийн хэрэгжилтийн суурь үзүүлэлтүүдийг тодорхойлох зорилгоор“ ХБӨ, осол гэмтлийн шалтгаан, эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын түвшин тогтоох” судалгааг явуулав.

ДЭМБ-ын ХБӨ-ний тандалтын тогтолцооны “Шаталсан судалгаа”-ны арга, аргачлалын дагуу ДЭМБ-ын зөвлөмжийг үндэслэн, өөрийн орны онцлогийг харгалzan судалгааны арга зүйг боловсруулж З шаталтайгаар уг судалгааг хийж гүйцэтгэлээ.

1. 1-ршат: Энгийн асуумж судалгааны аргаар-архи, тамхины хэрэглээ, хүнсний ногоо, жимсний хэрэглээ, хөдөлгөөний хомдол, артерийн даралт ихсэлт, чихрийн шижин өвчний түүх, эмчилгээ, зөвлөгөө, хөх, умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэлтийн байдал, осол гэмтэл, хүчирхийлийн тархалт, шалтгаан, нөхцөл байдал зэргийг тодорхойлов.


2. 2-ршат: Бие махбодийн хэмжилтийн аргаар сорил болон багаж ашиглаж-судалгаанд хамрагдагсын илүүдэл жин, таргалалт (биеийн жин, өндөр, бүсэлхий ба ташааны тойрог, биен агуулагдах өөхлөг эдийн хэмжээ), артерийн даралт ихсэлт, бие бялдрын чийрэгжилтийн түвшинг тодорхойлж тусгай шалтуураар үнэлгээ өгсөн.

3. 3-ршат: Лабораторийн шинжилгээний хуурай болон нойтон химиин аргаар-захын цусан дахь сахар, холестерин, триглицеридийн хэмжээг орон нутагт нь шууд (хуурай химиин арга) тодорхойлж, харин бага болон их нягттай липопротеидуудыг цусны сийвэнд (нойтон химиин арга) тодорхойлж үр дунг нэгтгэн дүгнэсэн болно.

2. Судалгааны хүн ам, түүврийн хэмжээ, түүвэрлэлт

Судалгаанд Монгол улсын 20 аймгийн 36 сум, Улаанбаатар хотын 6 дүүргийн 24 хороодын нийт 5638 хүн хамрагдлаа. Санамсаргүйгээр сонгогдсон 15-64 насны эрэгтэй, эмэгтэй хүмүүс судалгаанд хамрагдах боломжтой байв. Судалгаанд хамрагдахаар сонгогдсон хүн бүр мэдээлэл цуглуулах нэг ба хоёрдугаар шатны ажиллагаанд хамрагдсан ба жирэмсэн эмэгтэй, тахир дутуу болон хэвтрин хүмүүст бие махбодийн хэмжилт хийх боломжгүй байв. Санамсаргүйгээр сонгогдсон 25-64 насны 3 хүн тутмын 1 хүн нь судалгааны 3-р шат буюу биохимиийн шинжилгээнд хамрагдас.

Дүрслэл зураг 1. Судалгаанд сонгогдсон түүвэрлэлтийн анхны нэгж буюу кластерийн байршил



ХБӨ-ийг тандах шаталсан судалгааны аргачлалын дагуу судалгааны түүврийн хэмжээг тодорхойлохдоо өмнөх судалгааны эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын үзүүлэлтгүүдээс илүүдэл жин, таргалалтын түвшинг ($P=32.6\%$) суурь үзүүлэлтээр авч, 95%-ийн үнэн магадлал ($Z=1.96$), алдааны хязгаар ($p=0.05$), комплекс түүврийн нөлөөллийн коэффициент (1.5), насны бүлэг бүрт хүйсийн төлөөлөл тэнцвэртгэй байх (хүйс бүрт 5 насны бүлэг нийт 10) зарчмуудыг баримталж нийт 4840 орчим хүнийг хамруулах тооцоо гарснаас сонгогдсон хүмүүс судалгаанд оролцооос татгалзах магадлалыг 15%-иар тооцоолон нэмж нийт 5694 хүнийг судлахаар төлөвлөсөн болно (Томъёолол 1).

Түүврийн хэмжээг тооцоолсон томъёолол:

$$1. n = Z^2 \frac{P(1-P)}{\epsilon^2}$$

$$n = 1.96^2 \frac{0.3(1-0.3)}{0.0025} = 322.69$$

$$2. n \times \text{комплекс түүврийн коэффициент } x \text{ нас-хүйсийн үзүүлэлт} = 322.7 \times 1.5 \times 10 = 4840$$

$$3. n / \text{татгалзах магадлал} = 4840 / 0.85 = 5694$$

Монгол улсын нийт нутаг дэвсгэрийг хамруулан судалгааг зохион байгуулахаар төлөвлөж, судалгаанд хамрагдах хүн амыг олон үе шатат санамсаргүй түүврийн аргаар 4 шатлалт нэгж тус бүрээр сонгов. Хот суурин болон хөдөө орон нутгаас хамрагдах хүн амын зохистой харьцааг хангах, амьдралын хэв маяг, өвчлөлийн ялгааг тодорхойлохын тулд судалгааны түүвэрлэлтийг хот, хөдөөд тусад нь хийлээ.


Улаанбаатар хот, Дархан, Орхон аймгуудыг хот суурин газар, бусад аймаг сумдыг хөдөө орон нутагт оруулж түүвэрлэсэн болно. Судалгааны хүн амыг нийт 60 багц түүвэрлэлтийн нэгж буюу кластерт хувааж 1 кластераас 95 орчим хүн сонгож оролцуулав. Хот болон хөдөөд харьяалагдах судалгааны хүрээний 15-64 насны хүн амын тооны харьцаанд үндэслэн хот суурин газраас 28, хөдөө орон нутгаас 32 кластерүүг сонгон түүвэрлэлтийг хийв (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Хот, хөдөөгөөс сонгогдсон кластериийн тоо

Нутаг дэвсэр	Зорилтот хүн ам	Нийт хүн амд эзлэх %	Судалгааны хүн ам	Кластериийн тоо
Хот суурин	831802	0.5	2733	28
Хөдөө орон нутаг	919417	0.5	2961	32
Нийт	1751219	1.00	5694	60

Олон үе шатат санамсаргүй түүврийн анхны нэгж буюу кластер нь хот суурин газарт хороо, хөдөө орон нутагт сум; хоёр дахь нэгж нь хот суурин газарт өрхийн хэсэг, хөдөө орон нутагт баг; гурав дахь нэгж нь хот суурин ба хөдөө орон нутагт өрх байлаа (хотод хороо-өрхийн хэсэг-өрх-хувь хүн, хөдөөд сум-баг-өрх-хувь хүн шатлалт нэгж; (Дүрслэл 2).

Дүрслэл 2. Олон үет санамсаргүй түүврийн үе шатууд



Хот суурин газрын нийт 173 хороодоос 28 хороо, сонгогдсон хороо бүрээс тус бүр 3 өрхийн хэсгийт хүн амын тоонд нь тохируулан тэнцүүлэх байдлаар санамсаргүйгээр сонгов. Сонгогдсон өрхийн хэсгүүдийн өрхийн шинэчилсэн бүртгэлээс, санамсаргүй тоон хүснэгтэд үндэслэн судалгаанд хамрагдах 95 өрхийг сонгов.

Хөдөө орон нутгийн нийт 324 сумдаас судалгааны насын хүн амын тоонд нь тохируулан тэнцүүлэх байдлаар санамсаргүйгээр 32 сум, сонгогдсон sumaас тус бүр 2 багийг тус тус сонгов. Тухайн sumaас сонгогдсон багуудын өрхийн шинэчилсэн жагсаалтаас санамсаргүй тоон хүснэгтэд үндэслэн судалгаанд хамрагдах 95 өрхийг сонголоо (Хүснэгт 2).

Түүврийн эцсийн нэгж буюу хувь хүн нь сонгогдсон өрхийн 15-64 насын хүмүүсийн дотроос Кишийн аргаар, санамсаргүйгээр сонгогдлоо. Сонгогдсон өрхөөс зөвхөн 1 хүн судалгаанд хамрагдсан болно.

Мэдээлэл цуглуулсан цаг хугацаа. Судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг хөдөө орон нутагт 2009 оны 10-р сарын 8-ний өдрөөс 11-р сарын 2, Улаанбаатар хотод 2009 оны 12-р сарын 10-аас 12-р сарын 25-ны өдруудэд зохион байгуулав.

Судалгааны арга зүйн болоод судлаач бэлтгэх сургалтууд.

“ХБӨ, осол гэмтлийн шалтгаан, эрсдэлт хүчин зүйсийн тархалтын түвшин тогтоох” судалгааны арга зүйн сургалтыг НЭМХ нь ЭМЯ, ДЭМБ, ММСС-ийн Эрүүл Мэндийн төслийн багтай хамтран 2009 оны 9 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулав. Сургалт, семинарт ДЭМБ-ын ХБӨ-ний тандалтын судалгааны багийн ахлагч Леани Рили, судалгааны зохицуулах хорооны гишүүд, эрүүл мэндийн судалгаа, сургалт, уйлчилгээ, бисейн тамир, спортын байгууллагуудын удирдлага, олон улсын болоод төрийн бус байгууллагын төлөөлөл бүхий нийт 50 гаруй хүн оролцлоо.

Хүснэгт 2. Судалгаанд сонгогдсон түүврийн нэгж ба судалгааны хүн амьг төлөөлөх хувь

Аймаг/Хот	Кластерийн тоо	Хүн амьын тоо хувь
Улаанбаатар	24	2176 (40.0)
Хот		
Дархан	2	180 (3.3)
Эрдэнэт	2	190 (3.5)
Хөдөө		
Архангай	3	285 (5.2)
Баян-Өлгий	1	95 (1.7)
Баянхонгор	2	190 (3.5)
Булган	2	180 (3.3)
Дорнговь	1	77 (1.4)
Дорнод	2	184 (3.4)
Дундговь	1	82 (1.5)
Завхан	2	188 (3.5)
Өвөрхангай	2	180 (3.3)
Өмнөговь	2	151 (2.8)
Сүхбаатар	1	91 (1.7)
Сэлэнгэ	2	177 (3.3)
Төв	2	178 (3.3)
Увс	2	183 (3.4)
Ховд	2	184 (3.4)
Хөвсгөл	3	277 (5.1)
Хэнтий	1	95 (1.7)
Говь-Алтай	1	95 (1.7)

Судалгааны техникийн ажлын хэсгийн баг ДЭМБ-ын зөвлөхтэй хамтран үндэсний судлаач бэлтгэх сургалтыг 2009 оны 9-р сарын 16-21-ний өдрүүдэд нь зохион байгуулж нийт 50 гаруй үндэсний судлаач бэлтгэв. Сургалтын эхний 2 өдөр судлаачид судалгааны хүн амьг сонгох түүвэрлэлтийн арга, сонгогдсон хүн амд мэдээлэл түгээх, судалгаанд хамруулах арга ажиллагаатай танилцаав. Сургалтын гол хэсэг нь судалгааны мэдээлэл цуглуулах үндсэн хэрэгсэл болох гар компьютерийг ашиглах, харьцах зарчим, мэдээлэл оруулах арга, техник эзэмших хичээл байв. Түүнчлэн, судалгааны асуумжтай танилцаж, асуултуудын зорилго, агуулгын талаар товч ярилцаа. Сургалтын сүүлийн 2 өдөр судалгааны нэг, хоёр болон гуравдугаар шатны мэдээлэл цуглуулах ажлын арга аргачлалыг тухайн чиглэлийн эрдэмтэн, судлаач, мэргэжилтнүүд дэлгэрэнгүй байдлаар зааж, хичээл бүрийн дараа шаардлагатай дадлага ажлууд хийгдэв.

Туршилт судалгаа. Дээрх сургалтаар бэлтгэгдсэн судлаачдыг оролцуулан судалгааны бүхий л ѿ шатуудыг хамарсан туршилт судалгааг Улаанбаатар хотын 2 дүүргийн 80 гаруй хүмүүсийг хамруулан зохион байгуулав. Туршилт судалгаа нь мэдээлэл цуглуулах багийн ахлагч нар хороодоос судалгаанд хамрагдах өрхийн

хэсэг, өрх болоод хувь хүнийг зохих арга аргачлалын дагуу сонгож, өрхийн эмч, сувилагчтай хамтран сонгогдсон хүмүүст мэдээлэл түгээх ажлаар эхлэв. Мэдээлэл цуглуулах нийт 8 баг тус бүр 5 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр ажлаа эхэлж, баг тус бүр 9-10 хүнээс асуумж судалгаа аван, бие махбодийн хэмжилт хийж, 3-4 хүнийг биохимиин шинжилгээнд хамрууллаа. Туршилт судалгаа нь ярилцагч нарын харилцааны чадвар, асуултын утга санааг жигд зөв гаргаж буй эсэх, бие махбодын хэмжилт, лабораторийн шинжилгээний арга техник эзэмшсэн байдал болоод нийт судлаачдын РДА-тэй ажиллах чадвар зэргийг нягтлан үзэх зорилготой байв. Туршилт судалгааны явц, байдалд үндэслэн бие махбодийн хэмжилт хийх судалгааны дадлагыг дахин хийж, судлаач нэг бүрээр хэмжилт хийлгэн шалгаж баталгаажуулав.

Судалгааны мэдээлэл цуглуулсан байдал

ДЭМБ-ын боловсруулсан “ХБӨ-ний эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын шаталсан судалгаа” болон “Осол гэмтэл, хүчирхийллийн шалтгаан, тархалтын судалгаа”-ны олон улсын стандарт асуумжийг Монгол хэлнээ хөрвүүлэн, үндсэн утга санааг хадгалахын зэрэгцээ, өөрийн орны онцлог, шаардлагад тохируулан боловсруулж, англи хэлнээ дахин орчуулж ОУ-ын болон үндэсний зөвлөх мэргэжилтнүүд хянаасны дараа судалгаанд ашиглов.

Судалгааны иэгдүгээр шат буюу асуумжийн арга

Судалгаанд оролцогчийн нийгэм эдийн засгийн байдал, архи тамхины хэрэглээ, жимс хүнсний ногооны хэрэглээ, хөдөлгөөний идэвх, цусны даралт ихсэлт, чихрийн шижингийн түүх болоод эмийн бус эмчилгээний хувилбарууд, хөх, умайн хүзүүний хавдрын эрг илрүүлэлтийн байдал, осол гэмтэл, хүчирхийллийн шалтгаан нөхцөл байдал зэрэг мэдээллийг асуумжийн аргаар цуглуулж, үр дүнг нэгтгэлээ.

Архины хэрэглээг үнэлэх аргачлал: Архи, согтууруулах ундааны хэрэглээг “Стандарт уулт” хэмээх ухагдахуунаар илэрхийлэн үнэлгээ өгөв. Нэг стандарт уулт нь 10 грамм этилийн спирт агуулах хэмжээний архи согтууруулах ундааны төрөл зүйлтэй тэнцэнэ (Хүснэгт 3).

Архины хэрэглээг баримжаалан тооцоход дөхөм үзүүлэх зорилгоор 5 нэрийн согтууруулах ундааны төрлийг стандарт уултаар илэрхийлсэн зурагт хуудас бэлтгэж хэвлүүлсэн ба нийтлэг хэрэглэгддэг архи, согтууруулах ундааны төрлүүдийг стандарт уултаар илэрхийлсэн хүснэгт зэргийг хавсралтаар үзүүлэв.

Хүснэгт 3. Архины стандарт уулт

Согтууруулах ундаа	Хэмжээ	Этилийн спирт		Стандарт уултын хэмжээ
		агууламж	хэмжээ	
Архи	1 хундага / 50мл /	40%	20гр	2
Дарс	1 хундага / 100 мл /	12.5%	12.5гр	1.3
Шар айраг	1 шил / лааз 330мл /	4-5 %	15гр	1.5
Нэрмэл архи	1 аяга / 100 мл /	15%	15гр	1.5
Айраг	1 аяга / 500 мл /	5 %	25гр	2.5

Энэхүү судалгаанд сүүлийн 1 сард ямар нэг хэмжээгээр согтууруулах ундаа хэрэглэсэн хүмүүсийг “одоогоор архий хэрэглэгсэд” гэж авч үзсэн болно. Судалгаанд хамрагдагсдын архи, согтууруулах ундааны хоногийн хэрэглээний байдлаар нийт хүн амыг архины хэрэглээний эрсдлийн зэргээр 2 бүлэгт, архи согтууруулах ундаа хэрэглэгсдийг 3 бүлэгт хувааж, хүйс, насны байдлаар харьцуулж дүгнэлт өглөө [10] (Хүснэгт 4).

Хүснэгт 4. Архины хэрэглээний эрсдлийн зэргэг, хуйсээр

Эрсдлийн зэргэг			
Хүйс, этилийн спиртийн агууламж	Зохистой хэрэглээ	Дунд зэргийн эрсдэлтэй	Өндөр эрсдэлтэй

Эрэгтэй	<40гр	40-59.9гр	>60гр
Эмэгтэй	<20гр	20-39.9гр	>40гр

Архийг хэтрүүлэн хэрэглэгсэд гэдэг нь архи, согтууруулах ундаа хэрэглэгсэд нэг удаагийн уултаар эрэгтэйчүүд 5 буюу түүнээс олон, эмэгтэйчүүд 4 буюу түүнээс дээш стандартаар архи болон согтууруулах ундааг хэрэглэхийг хэлнэ.

Хүнсний ногоо, жимс, жимсгэний хэрэглээг үнэлэх аргачлал: Судалгаанд хамрагдсан хүн амын хооллолтын хэв маягийг тодорхойлохдоо жимс, хүнсний ногооны хэрэглээ, өөх тосны төрөл, хоногт хэрэглэдэг давсны дундаж хэмжээ зэргийг асуумжийн аргаар судлан үнэлгээ

өглөө. Жимс, хүнсний ногооны дундаж хэмжээг “нэгж” хэмжигдэхүүнээр илэрхийлсэн ба 1 “нэгж” нь 80 граммтай тэнцэнз. Мэдээлэл цуглуулахад дөхөм үзүүлэх үүднээс Монголчуудын нийтлэг хэрэглэдэг 14 төрлийн 21 нэрийн жимс, төмснөөс бусад 11 төрлийн 19 нэрийн хүнсний ногоог нэгжээр илэрхийлэн, б 1 төрлийн 11 нэрийн тос, өөхлөг бүтээгдэхүүн, 2 төрлийн давс зэрэг нийт 52 фото зураг бүхий “зурагт үзүүлэн” (showcard)-г боловсруулан, хэвлүүлж судалгаанд хэрэглэв. Энэхүү “зурагт үзүүлэн” (showcard)-г ашиглан “ердийн өдөр” дундажаар хэдэн нэгж жимс, хүнсний ногоо хэрэглэдэг болохыг асууж, бүртгэн үр дүнг тооцлоо. Хүнсний ногоо, жимсийг “Нэгж”-ээр илэрхийлсэн баримжаа хэмжээг харуулсан зурагт хуудсыг хавсралтаар толилуулав.

Давсны хэрэглээг *тооцохдоо* 500 грамм давсыг тухайн өрх хэд хоног хэрэглэдэгийг асууж, дундаж хоногийг тооцон гаргаад, өрхийн ам бүлийн тоонд хувааж өрхийн нэг гишүүний хоногт хэрэглэж буй давсны дундаж хэмжээг тооцоолж гаргав. *Өөх тосны хэрэглээний байдлыг* тодорхойлохдоо гэрийн нөхцөлд хоол хүнс бэлтгэхдээ давамгайлан хэрэглэдэг өөх тосны төрлийг асууж үнэлгээ өгсөн болно.

Хөдөлгөөний идэвхийг тодорхойлох аргачлал: Хөдөлгөөний идэвхийг цогц 16 асуултын тусламжтайгаар тодорхойлсон бөгөөд ажлын байр, ирж очих хөдөлгөөн болон чөлөөт цагаараа хийж буй хөдөлгөөний идэвхи, давтамжийг тодорхойлох аргаар үнэлэв. Ажлын байр, ирж очих зам, тээврийн хэрэглээ, чөлөөт цагаараа 10 минутаас доошгүй хугацаанд хөдөлгөөн хийдэг өдрийн тоо, хөдөлгөөн хийдэг нийт хугацааг цаг ба минутаар тооцон гаргасан болно. Энэхүү багц асуумжийн давуу тал нь тухайн хүн хоногт хэдэн цаг ба минут хөдөлгөөн хийсэн байдлыг тодорхойлохоос гадна хөдөлгөөний идэвхийн зэргийг тодорхойлох боломжтой юм.

Ажлын байр, ирж очих, чөлөөт цагаараа хийж буй хөдөлгөөний хоногт зарцуулсан дундаж голч (median) хугацааг МЕТ-ээр хэмжсэн (1 МЕТ хэмжигдэхүүн нь тайван сууж байх уед хүний бие махбодийн зарцуулж буй хүчилтөрөгч буюу илчлэгийн хэмжээ). Биесийн хөдөлгөөний идэвхийг биесийн хүч их, дунд зэрэг болон бага шаардсан зэргээр ангилан тооцсон байдал. Үүнд:

· Биесийн хүч их шаардсан хөдөлгөөнд

- 7 хоногт 3-аас доошгүй өдөр 1500 МЕТ-минутаас багагүй хугацаагаар нилээд эрчимтэй хөдөлгөөн хийх
- 7 хоногийн ихэнх өдрүүдэд 3000 МЕТ-г ажлын нэг хэсэг, ирж очих болон чөлөөт цагаараа зарцуулсан хугацааг нийтэд нь 3000 МЕТ-минутаас багагүй хугацаагаар явган явах гэх мэт нилээд болон дунд зэргийн эрчимтэй хөдөлгөөн хийх

· Биесийн хүч дунд зэрэг шаардсан хөдөлгөөнд

- 7 хоногийн 3-аас доошгүй өдөр идэвхитэй хөдөлгөөнийг өдөрт 20 минутаас доошгүй хугацаагаар хийх
- 7 хоногийн 5-аас доошгүй өдөр дунд зэргийн эрчимтэй хөдөлгөөн, тухайлбал алхах хөдөлгөөнийг өдөрт 30 минутаас доошгүй хугацаагаар хийх
- 7 хоногийн 5-аас доошгүй өдөр нилээд болон дунд зэргийн эрчимтэй хөдөлгөөнийг 600 МЕТ - минутаас багагүй хугацаагаар хийх

Биесийн хүч бага шаардсан хөдөлгөөн - Биесийн хөдөлгөөний хамгийн доод тувшин бөгөөд 7 хоногт биесийн хүч их ба дунд зэрэг шаардсан хөдөлгөөн хийдэггүй хүмүүсийг энэ зэрэглэлд хамааруулна. Биесийн хүч бага шаардсан хөдөлгөөн хийж буй хүмүүсийг хөдөлгөөний хомсдолтой (600 МЕТ - минутаас бага) хэмээн үнэлнэ.

Хөх, умайн хүзүүний хорт хавдарын эрт илрүүлэлтийн байдлыг судалсан аргачлал

Умайн хүзүүний хорт хавдрыг харж оношлох арга- цууны хүчлийн сорил (VIA - Visual inspection with acetic acid), умайн хүзүүний эсийн шинжилгээ - Pap тест (Papanicolaou test or Pap smear and Cervical cytology) зэрэг аргаар эрт илрүүлэлтийн байдлыг асуумжийн аргаар судлан үнэлгээ өглөө .

- Цууны хүчил, люголын сорил гэдэг нь умайн хүзүүг харж-оношлоход цууны хүчил болон люголын уусмалыг хэрэглэдэг арга юм. Цууны хүчил, люголын уусмалаар умайн хүзүүг арчиж ямар ч өсгөлтгүйгээр нүдээр оношлохыг – цууны хүчлийн (VIA) сорил гэж нэрлэдэг. Цууны хүчил, люголын сорилын өөрчлөлтийг зөвхөн умайн хүзүүний шилжилтийн бүсэд харна.
- Эсийн шинжилгээ- PAP тест буюу эс зүйн шинжилгээ нь эмэгтэйчүүдийн утгрээ, умайн хүзүүнээс турхэц авч тавиур шилэнд нимгэн түрхэж наалддацийг бэлтгэж тусгай будгаар (Папаар) будаж эсийг микроскопийн тусламжтайгаар харж оношлодог арга юм. Эсийн шинжилгээ нь умайн хүзүүний хавдрыг хортой, хоргүй, хавдарын урьдал болон үрэвслийн явцаас ялган оношлоход чухал ач холбогдолтой шинжилгээ байдаг.
- Хөхөө өөрөө шалгах арга гэдэг нь эмэгтэйчүүд сар бүр сарын тэмдэг ирсэнээс 7 хоногийн дараа цагийн зүүний дагуу тодорхой чиглэлээр хөхөө тэмтэрч өөрчлөлт байгаа эсэхийг шалгадаг арга юм.

Судалгааны хоёрдугаар шат буюу бие махбодийн хэмжилтийн арга

Хэмжилтийн аргаар биеийн жин, өндөр, бүсэлхийн тойрог, биед агуулагдах өөхлөг эдийн хэмжээ, arterийн даралт, бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшинг тодорхойлов.

Биеийн жиснг Итали улсад үйлдвэрлэгдсэн “GIMA” биеийн бүтцийг тодорхойлогч электрон жинлүүрийг ашиглан хэмжив. “GIMA” нь эрдэм шинжилгээ, судалгааны ажилд ашиглах боломжтой, биеийн жин, өөхлөгийн хувь, ус, булчин масс, ясны жин зэргийг 0.1%-ийн нарийвчлалтай хэмжих чадвартай, 4 хэмжилтийн үр дунг санах ойтой багаж юм.

Биеийн өндөр. Биеийн өндрийг “Somatometre-Stanley 04-116” багаж ашиглан тодорхойлсон.

Somatometre - өндөр хэмжигч нь 2 метр хүртэлх өндрийг хэмжих боломжтой, хэмжилтийн заалтыг миллиметрийн нарийвчлалтайгаар санти-метрээр илэрхийлдэг, судалгаанд ашиглахад тохиромжтой багаж юм.

Биеийн жиснгийн индекс. БЖИ-ийг тухайн хүний килограмаар илэрхийлсэн биеийн жингиийн утгыг түүний метрээр илэрхийлсэн өндрийн утгад харьцуулж тооцов.

БЖИ = Биеийн жин (Кг) : Биеийн өндөр (cm^2)

Бүсэлхийн тойргийг хэмжихэд миллиметрийн нарийвчлалтай, сунадагтуй, судалгааны ажлын зориулалттай, “GIMA waist meter” уян туузан метр ашиглав. Хэмжүүлэгчийн хавирганы доод нум болон талсаан толгойн дээд ирмэг хоёрын голч цэгийг дайруулан бүсэлхийн тойргийг хэмжлээ.

Биед агуулагдах өөхлөг эдийн хэмжээг дээрх “GIMA body fat scale” биеийн бүтцийг тодорхойлогч багажийг ашиглан хэмжив. Энэ нь биед агуулагдах өөхлөг эдийн хэмжээг тухайн хүний нас, хүйс, жин, өндрийн үзүүлэлтийг ашиглан биеийн жинд эзлэх хувиар илэрхийлж үнэлдэг (Хүснэгт 5).

Хүснэгт 5. Биеийн өөхлөгийн лавламж хэмжээ

Хүйс	Биеийн өөхлөгийн хэмжээ			
	Туранхай	Хэвийн жинтэй	Илүүдэл жинтэй	Тарган
Эрэгтэй	<10.0	10.0 -19.9	20.0- 24.9	25<=
Эмэгтэй	<20.0	20.0-29.9	30.0 – 34.9	35<=

Reference: Wardlaw,G.M., Kessel, M. (2000). Perspectives in Nutrition

Артерийн даралт тодорхойлох аргачлал: Судалгаанд хамрагдсан 15-64 насын хүмүүсийн артерийн даралтыг суугаа байрлалд OMRON Model MX3 автомат даралт хэмжигчээр баруун гарын бугалганд 3 удаа хэмжин эдгээр хэмжилтийн дундажийг тооцож үнэлгээ өгөв, Артерийн даралт ихсэлтийг оношлоходоо:

- Хэмжилтээр даралт 140/90 мм.муб-аас дээш ба/эсвэл даралт бууруулах эм хэрэглэж байгаа, артерийн даралт ихсээгүй боловч урьд нь эмч, эмнэлгийн ажилтнаар оношлогдсон эсвэл сүүлийн 2 долоо хоногт артерийн даралт бууруулах эм хэрэглэж байгаа хүмүүсийг артерийн гипертензтэй гэж авч үзэв.
- АГ-ийн шинэ тохиолдолд: Асуумжаар өмнө нь хэзээ ч даралтаа хэмжүүлж байгаагүй, даралтаа өмнө нь хэмжүүлж байсан ч даралт ихтэй гэж оношлогдож байгаагүй, сүүлийн 12 сард даралт ихэссэн, эм хэрэглээгүй гэсэн тохиолдлуудаас СДД 140 мм.муб-тай тэнцүү буюу түүнээс их, ба/эсвэл ДДД 90 мм.муб-тай тэнцүү буюу түүнээс их байгаа
- Эмийн эмчилгээнд үр дүнтэй АГ: СДД 140 мм.муб-аас бага, ба ДДД 90 мм.муб-аас бага, сүүлийн 2 долоо хоногт даралт бууруулах эм хэрэглэж байгаа зэргийг харгалзан үзсэн болно.

Бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшинг тодорхойлох аргачлал: Судалгаанд хамрагдсан 25-64 насын 3 хүн тутмын 1 хүнд бие бялдрын чийрэгжилтийн түвшинг бие махбодийн 5 чанар (хүч, хурд, уян хатан, тэсвэр ба тэнцвэр)-ыг үнэлэх сорилын аргаар тодорхойлсон [4].

- Хүчний чанарыг гар дээр сунайлтаар тодорхойлж 1 минутад гүйцэтгэсэн тоогоор үнэлгээ өгөв.
- Хурдны чанарыг байрандаа гүйлтгээр тодорхойлж 10 секундэд гүйцэтгэсэн гүйлтийн тоогоор үнэлгээ өгөв.
- Биеийн уян хатан чанарыг суугаа байдлаас бөхийлгөх байдлаар тодорхойлж тулхэлтийн тоогоор үнэлгээ өгөв.
- Биеийн тэнцвэрийг гарцаа алдлан зүүн хөл дээр өвдөг өндөр өргөж нүдээ анин зогсоо байдлаар хэмжих, нийт зогссон хугацаагаар үнэлгээ өгөв
- Биеийн тэсвэрийн чанарыг гүнзгий амьсгал авч гаргах байдлаар тодорхойлж амьсгал үлээж гаргах хугацаагаар үнэлгээ өглөө.

Судалгаанд оролцогч дээрх 5 чанар тус бүрт оноо авах ба эдгээрийн нийлбэр оноог тооцож доорх байдлаар үнэлгээ өглөө (Хүснэгт 6).

Хүснэгт 6. Бие бялдрын чийрэгжилтийн түвшинг үнэлэх аргачлал

Насны бүлэг	Үсгэн үнэлгээ				
	A	B	C	D	F
15-24	>25	21-24	17-20	13-16	<12
25-34	>24	20-23	16-19	12-15	<11
35-44	>21	17-20	13-16	9-12	<8
45-54	>17	12-16	8-11	4-7	<3
55-64	>15	11-14	6-13	2-5	<1

Судалгааны гуравдугаар шатанд ХБΘ-ний эрсдэлт хүчин зүйлсийн биохимийн үзүүлэлт болох захын цусан дахь *сахар*, *холестерин* болон *триглицерид*, *бага болон их нягттай липопротеид* дүүдүн хэмжээг тус тус тодорхойлсон. Accutrend GCT (Glucose, Cholesterol, Triglycerides) багажийн тусламжтайгаар захын цусан дахь сахар, холестерин, триглицеридийн түвшинг *хуурай химиин аргаар*, шинжлэгдэхүүн тус бүрд тохирсон тузан оношуураар шууд тодорхойлсон. Судалгааны мэдээлэл цуглуулах ажил намар орой хийгдсэн учраас багаж хэт хөрснөөс мэдрэг байдал нь өөрчлөгдөж дээрх үзүүлэлтүүдийн багажийн хэмжих хязгаараас их бага заалтууд илрээд олон гарсан тул үр дүнг дахин баталгаажуулах шаардлага гарсан. Шинжилгээг баталгаажуулахын тулд алдаа заасан мэдээлэл бүхий хүмүүсийн ийлдсэнд “Humalyzer 2000” хагас автомат анализатор ашиглан колориметрийн аргаар нийт холестерин, триглицеридийн хэмжээг дахин тодорхойлсон шинжилгээний дүнгээр үр дүнг тооцов.

Бага болон их нягттай липопротеини хэмжээг венийн цуснаас ялгасан ийлдсэнд төв лабораториид “Humalyzer 2000” хагас автомат анализатор ашиглан колориметрийн аргаар тодорхойлов. Сонгогдсон хүний судаснаас 7 мл өлөн цус хуруу шилэнд авч, авсан цусыг центрифугдэж, ийлдсийг ялган, бичил хуруу шилэнд хийж дугаарласан ийлдсийг явуулын хөлдөөгчинд хадгалан төв лабораторит зөвөрлөж аваачсан болно. Биохимийн шинжилгээний үзүүлэлтүүдэд үнэлгээ өгөхдөө ДЭМБ-аас баримталдаг ангиллыг ашиглалаа [10] (Хүснэгт 7).

Хүснэгт 7. Биохимийн үзүүлэлтүүдийг үнэлэх шалгуур үзүүлэлтүүд (ДЭМБ, 2005)

Шинжилгээний үзүүлэлт	Хэвийн	Эрсдэлтэй	Ихэссэн
Сахар	>5.6 ммоль/л	≥5.6 ммоль/л ба > 6.1ммоль/л	≥6.1 ммоль/л эсвэл сахар бууруулах эм хэрэглэж байгаа
Холестерин	>5.0 ммоль/л	≥ 5.0 ммоль/л ба >6.2 ммоль/л	≥ 6.2 ммоль/л эсвэл холестерин бууруулах эм хэрэглэж байгаа
Триглицерид	>1.7 ммоль/л	≥1.7ммоль/л ба > 2ммоль/л	≥2.0 ммоль/л
БНЛП	>3 ммоль/л	=>3 ммоль/л ба <4.15ммоль/л	≥4.15 ммоль/л
ИНЛП	Эр: >1.03 ммоль/л Эм: >1.29 ммоль/л	ИНЛП-ын түвшин буурсан Эрэгтэй: <1.03 ммоль/л; Эмэгтэй: <1.29 ммоль/л	

Судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг үндсэн 5 хүний бүрэлдэхүүнтэй 7 баг Улаанбаатар хот болон хөдөө орон нутагт хийж гүйцэтгэсэн. Судалгааны баг нь багийн ахлагч-1, мэдээлэл цуглуулагч-2, хэмжигч-1, лабораторийн ажилтан-1 хүн, орон нутгийн туслах-2 нийт 7-8 хүний бүрэлдэхүүнтэй ажиллав. Санамсаргүй түүврийн аргаар сонгогдсон өрхийн гишүүдэд судалгаа аваахас 2-3 хоногийн өмнө мэдээллийн хуудсыг тарааж, судалгааны зорилго, зорилтыг танилцуулсан бөгөөд судалгаанд сонгогдсон хүн бүр оролцох эсэх талаар бичгээр

зөвшөөрөл өгсөнийг үндэслэн оролцогчдыг тогтоосон болно. Судалгаанд оролцогсад нь хот суурин газарт сонгогдсон өрхийн эмнэлгүүд дээр, хөдөө орон нутагт сум, багийн эмнэлэг, төвүүдэд уригдан ирж судалгаа өгсөн ба судалгааны талбарт ирэх боломжгүй тохиолдлууд, ялангуяа хөдөө орон нутагт судалгааны баг өрхөд хүрч очин мэдээлэл цуглуулсан болно.

Мэдээлэл цуглуулах явцад хийгдсэн хяналт, шинжилгээ, үнэлгээ.ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын баталсан "ХБӨ-ний эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын судалгааны явцад хяналт шинжилгээ хийх ажлын удирдамж"-ийн дагуу томилогдсон 3 баг ЭМЯ, НЭМХ-ийн төлеөлөл бүхий тус бүр 2 хүний бүрэлдэхүүнтэйгээр хөдөө орон нутагт ажиллаж судалгааны багийн ажлын явцтай танилцаж, хяналт тавин, үнэлгээ өгч, шаардлагатай зохион байгуулалтын болон арга зүйн зөвлөгөө өгч, судалгааны ажилд дэмжлэг үзүүлж ажиллалаа. Улаанбаатар хотод мэдээлэл цуглуулах явцад НЭМХ-ийн захирлын баталсан удирдамжийн дагуу 2 баг Нийслэлийн Эрүүл Мэндийн Газар (НЭМГ)-ын НЭМ-ийн хэлтэс, дүүргүүдийн НЭМ-ийн нэгдлийн орлогч дарга нар, судалгааны зохицуулагчдын бүрэлдэхүүнтэйгээр судалгааны талбарт хяналт тавьж, дэмжлэг үзүүлж ажиллав.

Судалгааны мэдээлэл оруулах, цэвэрлэгээ: Судалгааны бүхий л үе шатны мэдээллийг PDA буюу гар компьютерийн тусламжтайгаар цуглуулсан тул судалгааны багуудад хэрэглэгдсэн нийт 35 PDA-д агуулагдах мэдээллийг eSTEPS manager-ээр дамжуулан суурин компьютерийн мэдээллийн баазад хуулибарласнаар мэдээлэл оруулах ажиллагаа дууссан болно. Esteps questionnaire designer программд хуулбарлагдсан дээрх мэдээллийг EPIDATA программд шилжүүлэн судалгааны мэдээллийдийг нэгтгэж, бусад статистик программуудад шилжүүлэн ажиллах боломжтой болсон юм. EPIDATA программ дээр судалгааны мэдээллийг нэг, хоёр, гуравдугаар шат тус бүрээр нэгтгэн, эдгээр мэдээллийн файлуудыг SPSS программд хөрвүүлэв. Судалгаанд хамрагдсан хүн бүрийн мэдээлэл нь кластер, өрхийн хэсэг, баг болон хувийн дугааруудаар ялгагдах зарчмыг үндэслэн эдгээр код, дугааруудын дэс дараа, давхардал, алгасалт, буруу кодлогдсон эсэх зэргийг нарийвчлан шалгаж засах ажиллагаа 7 хоног ургэлжлэв. Энэ үйлдлийн дараа судалгааны мэдээллийг бүхэлд нь нэгтгэн нэг файл болгож, нас, хүйсний үзүүлэлтүүдийг нягтилан шалгаж, хувьсууруудын дээд, доод хязгаар, орхигдсон болоод хэлбэлзлийн хязгаараас хэтэрсэн мэдээллийг илрүүлэх, засах ажилд 7 хоног зарцуулагдав. Эцэст нь судалгааны үндсэн мэдээллийн баазыг EPI INFO программд шилжүүлж дээрх үйлдлүүдийг дахин давтан нягталж шалгаснаар судалгааны мэдээллийн цэвэрлэгээ дуусгавар болсон болно.

Судалгааны мэдээллийг жинлэх: Энэхүү судалгаанд түүврийн хүн амаар төлөөлүүлэн судалгааны насын Монгол улсын нийт хүн амыг төлөөлөхүйц үзүүлэлтүүдийг гаргаж авах зорилт тавьсан. Энэ үүднээс судалгааны мэдээллийн үр дүнг жинлэх зайлшгүй шаардлага гардаг. Жин гэдэг нь судалгааны түүврийн нэгж дэх нэг хүн нийт хүн амын дундаас хичнээн хүнийг төлөөлж буйг илэрхийлэх тоо юм. Энэхүү судалгаанд хоёр төрлийн жинлэлт хийгдсэн нь хүн амын жинлэлт (population weighting) ба түүврийн жинлэлт (sample weighting) юм.

Энэхүү хоёр жинлэлтийн үржвэрээр үүссэн нийт жинлэлтийн хувьсуур (WStep1) судалгааны мэдээллийн боловсруулалтаар гарч буй бүхий л үр дүнд тооцогдож бодогдсон болно.

Судалгааны мэдээлэл боловсруулах

Судалгааны мэдээллийн статистик боловсруулалтыг ДЭМБ-ын ХБӨ-ний тандалт судалгааны багийн гишүүн Мелани Кованы удирдлагааар НЭМХ-ийн статистик боловсруулалтын баг хийж гүйцэтгэв. Судалгааны мэдээллийн статистик боловсруулалтыг EPI INFO программын 3.5.1 хувилбарыг ашиглан хийсэн. EPI INFO 3.5.1 нь комплекс түүвэрлэлтийн арга бүхий үндэсний түвшний судалгааны хүн амын мэдээллийн үр дүнд дүн шинжилгээ хийх зориулалт бүхий программ юм.

ХБӨ-ний эрсдэлт хүчин зүйлсийн байдлын үр дүнгүүд нь хүн амын дундах тархалтын % ба дундаж үзүүлэлтээр илэрхийлэгдлээ. Үр дүнгийн нарийвчлалын хэмжүүр (тархалтын хувь

болон дундгийн хэлбэлзэл) болоод бүлгүүдийн (нас, хүйс, хот хөдөө) ялгааг тодорхойлоход 95%-ийн итгэх хязгаар (95% CI)-ын хэлбэлзлийн утгуудыг ашиглав. Түүврийн хүн амд түшиглэсэн энэхүү судалгааны үр дүнгийн нарийвчлалд нөлөөлж болох түүвэрлэлтийн алдаа нь хэмжигдэж буй хувьсуурууд ба үр дүнгийн стандарт алдаагаар хэмжигдэнэ. Тархалтын хувь болоод дундаж үзүүлэлтэд гарч болох алдааны хязгаар нь 95%-ийн итгэх хязгаарын дээд, доод утгаар илэрхийлэгдсэн болно.

ХБӨ, осол гэмтлийн шалтгаан, эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын судалгааны бүхий л үр дүн буюу тархалтын хувь, дундаж үзүүлэлт нь хүн амын болоод түүврийн жинлэлтийн үзүүлэлтүүдээр тохируулга хийгдсэн тул судалгааны хүрээний нийт хүн амыг төлөөлөх боломжтой юм.

Харьцуулсан судалгааны үр дүнгийн боловсруулалт

ХБӨ-ний эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын анхны судалгааг 2005 онд хийж, эрсдэлт хүчин зүйлсийн суурь үзүүлэлтүүдийн үр дүнг гаргахдаа зөвхөн хүн амын жинлэлтийг тооцсон байдаг. Харин энэхүү давтан судалгааны эрсдэлт хүчин зүйлсийн үзүүлэлтүүдийн үр дүнг хүн амын болон түүврийн жинлэлтийг тооцон гаргаснаар үр дүнгийн нарийвчлал, нийт хүн амыг төлөөлөх чадвар улам илүү сайжирсан талтай. Гэвч судалгааны үр дүнгийн боловсруулалтын аргын энэхүү ялгаа нь хоёр судалгааны үр дүнг шууд харьцуулах боломжийг бууруулж байгаа юм. Иймээс харьцуулсан судалгааны үр дүнг гаргахдаа 2005 болон 2009 оны судалгааны мэдээлэлд дахин боловсруулалт хийж, үр дүнг 2008 оны хүн ам зүйн мэдээлэлд түшиглэн нас, хүйсний төлөөллийн ижил үзүүлэлтээр жинлэн, шууд харьцуулах боломжтой үр дүнг гаргалаа.

**БҮЛЭГ ШІ
СУДАЛГААНЫ ҮР ДҮН**

3.1 ХҮН АМ ЗҮЙН ҮЗҮҮЛЭЛТ

Хүн ам зүйн хэсэгт судалгаанд оролцсон хүн амын нас, хүйс, боловсролын түвшин, яс үндэс, ажил мэргэжил, өрхийн орлого, гэр бүлийн байдлыг харуулав.

ХБӨ-ний эрсдэлт хүчин зүйлсийн түвшинг тогтоох судалгаанд Монгол улсын 20 аймаг, Улаанбаатар хотын 15-64 насны нийт 5438, үүнээс эрэгтэй 2217, эмэгтэй 3221 хүн хамрагдлаа (Хүснэгт 8).

Хүснэгт 8. Судалгааны түүвэрлэлт (нас ба хүйсээр)

Насны бүлэг	Эрэгтэй		Эмэгтэй		Бүгд	
	Тоо	%	Тоо	%	Тоо	%
15-24	403	44.8	496	55.2	899	16.5
25-34	603	39.5	922	60.5	1525	28.0
35-44	568	39.3	876	60.7	1444	26.6
45-54	420	40.2	626	59.8	1046	19.2
55-64	223	42.6	301	57.4	524	9.6
15-64	2217	40.8	3221	59.2	5438	100.0

Судалгаанд хамрагдсан нийт 5438 хүний 82.1% нь халх, 2.0% нь казак, 15.9% нь бусад ястан байв. Тэдгээрийг насны бүлгээр авч үзвэл 15-24 насны 899 хүн, 25-34 насны 1525 хүн, 35-44 насны 1444 хүн, 45-54 насны 1046 хүн, 55-64 насны 524 хүн байна. Хотоос 2546 хүн, хөдөөнөөс 2892 хүн судалгаанд хамрагдажээ (Хүснэгт 9).

Хүснэгт 9. Судалгааны хэмжээ (яс үндэс, нас, хүйсээр)

Хүн ам зүйн үзүүлэлт	Судалгааны түүвэр	
	Н	Жинлээгүй %
Яс үндэс	Халх	4460
	Казак	107
	Бусад	866
Хот/ хөдөө	Хот	2546
	Хөдөө	2892
	Нийт	5438

Судалгаанд хамрагдсан хүмүүсийн тоо, хот хөдөө ба хүйсийн харьцаа харьцангуй тэгш байгаа бөгөөд насны бүлэг нь тухайн насны хүн амыг төлөөлж чадахаар сонгож авсан нь судалгааны үр дунд хүн амыг хот хөдөө, хүйс болон насны бүлгээр ялган боловсруулалт хийж, дүгнэлт өгөх боломжтойг харуулж байна.

Гэр бүлийн байдал

Судалгаанд хамрагдагсадын 74.0% нь гэрлэсэн, 17.3% нь гэрлэж байгаагүй, 4.3 % бэлэвсэн, 2.6% нь салсан, 1.2% нь хамтдаа амьдардаг, 0.6% нь тусдаа амьдардаг байна (Хавсралт I, 1-3).

5 хүн тутмын 4 нь хосоороо хамт амьдардаг ба бэлэвсэн эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 3.2%-иар илүү байна.

Боловсролын түвшин

Судалгаанд хамрагдсан хүн амын сургуульд суралцсан нийт жил дундахаар 10.4 байгаа бөгөөд энэ нь эрэгтэйчүүдэд 9.9, эмэгтэйчүүдэд 10.8 жил байна (Хүснэгт 10). Сургуульд суралцсан жил эмэгтэйчүүдэд эрэгтэйчүүдээс насны бүлэг бурд 0.9-1.4 хувиар илүү жил суралцсан байна.

Хүснэгт 10. Сургуульд суралцсан нийт жил (нас ба хүйсээр)

Насны бүлэг	Эрэгтэй		Эмэгтэй		Бүгд	
	Тоо	Дундаж	Тоо	Дундаж	Тоо	Дундаж
15-24	403	9.6	496	10.6	899	10.1
25-34	603	9.8	922	10.7	1525	10.3
35-44	568	10.3	876	11.3	1444	10.9
45-54	419	9.6	626	11.0	1045	10.4
55-64	223	10.3	301	9.6	524	9.9
15-64	2216	9.9	3221	10.8	5437	10.4

Судалгаанд хамрагдсан нийт хүн амын 1.4 хувь нь боловсролгүй, 1.8 хувь нь бүрэн бус бага (3-р анги төгссөн буюу бичиг үсэг тайллагаагүй), 9.7 хувь нь бага, 22.6 хувь нь бүрэн бус дунд, 25.9 хувь нь бүрэн дунд, 37.3 хувь нь тусгай дунд ба дээд, 1.3 хувь нь төгсөлтийн дараах боловсрол эзэмшилсэн байна (Хавсралт 1,5).

Боловсролын түвшинг хүйсээр авч үзвэл 15-64 насны эрэгтэйчүүд боловсролгүй 0.9 хувь, бүрэн бус бага 1-3 0.9 хувь, бага 4.6 хувь, бүрэн бус дунд боловсрол 6.2 хувиар тус тус эмэгтэйчүүдээс илүү байсан бол эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс бүрэн дунд 2.5 хувь, тусгай дунд ба дээд 9.3 хувь, магистр 0.8 хувиар тус тус илүү эзэмшилсэн ялгаатай байв. Үүнээс харахад эрэгтэйчүүд бүрэн бус дунд боловсролд эмэгтэйчүүдээс илүү хамрагдсан байсан бол бүрэн дунд боловсролоос дээш боловсрол эзэмшилтээрэгтэйчүүдэд харьцангуй өндөр байлаа.

Боловсролын түвшинг насны бүлгээр авч үзвэл бүрэн бус дунд боловсролын түвшин 15-24 насны эрэгтэйчүүд (33.3%) тухайн насны эмэгтэйчүүдийнхээс (27.6%) 5.7 хувиар дээгүүр байсан бол тусгай дунд болон дээд боловсролын түвшин насны аль ч ангилалд эмэгтэйчүүдэд эрэгтэйчүүдээс 2.2-20.7 хувиар дээгүүр байна. Энэ нь эрэгтэйчүүд 8 дугаар ангия төгсөөд цааш сурх асуудлаа хязгаарласнаас тэдний боловсролын түвшин хоцрох хандлагатай байгааг харуулж байна.

Харин төгсөлтийн дараах хетөлбөрт хамрагдалт 15-54 насанд аль ч насны ангилалд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 0.7-1.5 хувиар илүү хамрагдсан байгаа нь ажиглагдаж байна (Хавсралт I, 4-5).

Өрхийн орлого ба ажил эрхлэлт. Судалгаанд хамрагдсан хүн амын өрхийн орлогыг асуумжийн аргаар сүүлийн нэг жилийн дундаж түвшингээр тооцож үнэлгээнд ашиглав. “Сүүлийн нэг жилд танай өрхийн дундаж орлого хэд байсан бэ?” хэмээх асуултанд судалгаанд оролцсон 5298 хүн тодорхой хариулсан бөгөөд хүн амын сүүлийн нэг жилийн дундаж орлого 3138196.0 төгрөг байна.

45-54 насныхан амьдардаг өрхийн жилийн дундаж орлого хамгийн өндөр (3282050.2), 55-64 насныхан амьдардаг өрхийн жилийн дундаж орлого хамгийн бага (2970103.9) орлоготой байлаа.

Хэрэв уг орлогыг хөдөлмөрийн насныхан (18 наснаас дээш) олдог гэж үзвэл насанд хүрсэн нэг хүнд жилд 1283132.8 мянган төгрөгийн орлого ногдож байна (Хүснэгт 11).

Хүснэгт 11. Өрхийн нэг гишүүний жилийн дундаж орлого (насны бүлгээр)

Насны бүлэг	Бодит тоо	Өрхийн дундаж орлого (төг)	95% CI
15-24	840	1127826.8	1064210.1 – 1191443.6
25-34	1495	1421754.0	1363689.4 – 1479818.7
35-44	1419	1434386.2	1373701.3 - 1495071.0
45-54	1026	1094237.1	1033084.0 - 1155390.3
55-64	518	1094709.2	1014456.4 – 1174962.0
Total	5298	1283132.8	1253928.6 – 1312337.0

Судалгаанд хамрагдагсадын 57.4 хувь ажил эрхэлдаг ба ажил эрхэлдэг хүмүүсийн 44.9 хувь нь эрэгтэйчүүд 55.1 хувь нь эмэгтэйчүүд байна.

Хүн амын 21.5 хувь нь төрийн байгууллагад, 10.6 хувь нь төрийн бус байгууллагад, 20.4 хувь нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг, 47.5 хувь нь тогтмол цалин олгодогтүй хөдөлмөр эрхэлдэг байна. Төрийн байгууллагад эмэгтэйчүүд (22.7%) илүү ажиллаж байгаа бол эрэгтэйчүүд хувийн хэвлэлийн байгууллагад (24.9%) илүү хөдөлмөр эрхэлдэг байна (Хүснэгт 12).

Хүснэгт 12. Ажил эрхэлдэг хүн ам (нас ба хүйсээр)

Насны бүлэг	n	Төрийн байгууллага	Төрийн бус байгууллага	Хувиараа хөдөлмөр эрхэлдэг
Эрэтэй	15-24	402	7	4.5
	25-34	603	21.2	15.8
	35-44	568	24.5	13.9
	45-54	420	23.1	11.9
	55-64	223	20.2	5.8
	15-64	2216	19.7	11.5
Эмэгтэй	15-24	496	8.1	7.7
	25-34	922	21.4	13.2
	35-44	876	32.1	10.6
	45-54	626	31	8.5
	55-64	301	7.3	4.3
	15-64	3221	22.8	9.9
Дун	5437	21.5	10.6	20.4

Судалгаанд хамрагдагсадын 30,5 хувь нь ажил эрхлээгүй ба тэдний 39,1 хувь нь эрэгтэйчүүд, 25,3 хувь нь эмэгтэйчүүд байна.

Нийт хүн амын 18,6 хувь нь оюутан, 24,1 хувь нь гэрийн ажилтай, 16,5 хувь нь тэтгэвэр авдаг хүмүүс байна. Ажил эрхэлдэггүй хүмүүсийн 24,4 хувь нь хөдөлмөрийн чадвартай боловч тодорхой ажил эрхэлдэггүй, 6,1 хувь нь хөдөлмөрийн чадваргүйгээс ажил эрхэлдэггүй байна. Хөдөлмөрийн чадвартай боловч ажил эрхэлдэггүй хүмүүсийг хүйсээр авч үзвэл эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 9,9 хувиар илүү байгаа бол гэрийн ажилтай эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 20 хувиар илүү байна (Хүснэгт 13).

Хүснэгт 13. Ажил эрхлээгүй хүн амын судалгаа (нас ба хүйсээр)

Насны бүлэг	N	Оюутан	Гэрийн ажилтай	Тэтгэвэрт	Ажил эрхэлдэгтгүй		
					Хөдөлмөрийн чадвартай ажилгүй	Хөдөлмөрийн чадваргүй /тэтгэмж/	
	Тоо	%	%	%	%	%	
Эрэгтэй	15-24	297	61.3	8.8	0	19.5	2
	25-34	203	6.4	16.3	0.5	42.9	7.4
	35-44	163	0.6	17.2	4.3	40.5	11.7
	45-54	167	0	12.6	15	39.5	16.2
	55-64	142	0	3.5	65.5	14.1	11.3
	15-64	972	20.2	11.6	13	30.6	8.5
Эмэгтэй	15-24	385	67.8	15.6	0.5	12.5	0.5
	25-34	433	3.9	53.1	0.2	28.9	3
	35-44	291	1.7	47.8	3.1	30.9	5.8
	45-54	256	0	26.2	29.3	23.8	2.9
	55-64	245	0	4.9	87.3	3.7	2.9
	15-64	1610	17.6	31.6	18.7	20.7	4.6
	Дун	2582	18.6	24.1	16.5	24.4	6.1

3.2 АНХДАГЧ ЭРСДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ТАРХАЛТЫН БАЙДАЛ

Тамхи таталтын байдал

Хүн амын тамхи хэрэглэх сөрөг зан үйлийг тамхи татдаг эсэх, тамхи таталтын давтамж, хэдэн наснаас тамхийг татаж эхэлсэн, татсан хугацаа, өдөргүй хэдэн ширхэг тамхи татдаг, угаагүй тамхи хэрэглэдэг эсэх, ямар төрлийн тамхин бүтээгдэхүүн хэрэглэдэгт, гэргээ болон ажлын байрандаа дам тамхидалтад хэдий хугацаагаар өртдөг зэргээр тус тус тодруулан судалсан болно.

Судалгаанд хамрагдсан хүн амын тамхи таталтын тархалт 27.7 хувь (95% CI 26.0-29.4) байсан ба үүнээс, эрэгтэйчүүдийн 48.0 хувь (95% CI 44.5-51.5), эмэгтэйчүүдийн 6.9 хувь (95% CI 5.2-8.5) нь одоогоор тамхи хэрэглэж байна. Тамхины хэрэглээ эрэгтэйчүүдэд эмэгтэйчүүдтэй харьцуулахад бараг 7 дахин өндөр байна. Тамхи татдаг нийт хүмүүс болон эрэгтэй тамхи хэрэглэгсэдийн дотор 15-24 насныханд бусад насны бүлгүүдтэй харьцуулахад тамхины хэрэглээ харьцангуй бага байв. Харин эмэгтэй тамхи хэрэглэгсдийн дотор насны бүлгээр ялгаатай дун ажиглагдсангүй (Хүснэгт 14).

Тамхины хэрэглээг хот хөдөөгийн байдлаар авч үзэхэд судалгаанд хамрагдсан хот суурин газрын хүн амын 27.6 хувь (95%CI 24.8-30.3), хөдөөгийн хүн амын 27.8 хувь (95%CI 25.7-29.8) нь тамхи татдаг ба энэ үзүүлэлтэд статистик магадлал бүхий ялгаа байсангүй.

Хүснэгт 14. Тамхины хэрэглээний байдал (нас, хүйсээр)

Насны бүлэг (жилээр)	Эрэгтэй			Эмэгтэй			Нийт		
	n	Тамхи хэрэглээдэг хүн амын хувь	95% CI	n	Тамхи хэрэглээдэг хүн амын хувь	95% CI	n	Тамхи хэрэглэдэг хүн амын хувь	95% CI
15-24	403	35.0	27.3-42.8	496	4.0	1.9-6.0	899	19.9	15.5-24.2
25-34	603	55.5	50.6-60.4	922	9.1	5.8-12.4	1525	32.5	29.9-35.2
35-44	568	60.4	54.3-66.4	876	7.1	4.5-9.8	1444	33.6	30.5-36.7
45-54	420	52.4	46.0-58.7	626	10.9	7.3-14.4	1046	32.3	28.9-35.8
55-64	223	47.5	39.4-55.6	301	5.4	1.9-8.9	524	25.6	21.3-29.9
15-64	2217	48.0	44.5-51.5	3221	6.9	5.2-8.5	5438	27.7	26.0-29.4


Тамхины хэрэглээг давтамжаар нь авч үзвэл хүн амын 24.3 хувь (95%CI 22.9-25.7) нь өдөр бүр тогтмол, 3.4 хувь (95% CI 2.7-4.0) нь хааяа тамхи татдаг, харин 72.3 хувь (95%CI 70.6-74.0) нь тамхи огт татдаггүй эерэг хандлагатай байна (Хүснэгт 15).

Хүснэгт 15. Тамхины хэрэглээний давтамж

Насны бүлэг (жилээр)	n	Нийт хүн ам					
		Одоогоор тамхи хэрэглэж буй				Тамхи татдаггүй	95% CI
		Өдөр бүр	95% CI	Хааяа	95% CI		
15-24	899	16.4	13.0-19.9	3.4	1.7-5.1	80.1	75.8-84.5
25-34	1525	29.1	26.7-31.5	3.4	2.3-4.5	67.5	64.8-70.1
35-44	1444	29.2	26.7-31.8	4.4	2.8-6.0	66.4	63.3-69.5
45-54	1046	30.0	26.4-33.7	2.3	1.2-3.4	67.7	64.2-71.1
55-64	524	23.6	19.7-27.5	2.0	0.7-3.3	74.4	70.1-78.7
15-64	5438	24.3	22.9-25.7	3.4	2.7-4.0	72.3	70.6-74.0

Судалгаанд хамрагдсан хүн амын тамхи таталтын давтамжийг хүйсийн ялгаатай байдлаар тодруулахад эрэгтэйчүүдийн 43.0 хувь (95%CI 39.9-46.0), эмэгтэйчүүдийн 5.2 хувь (95%CI 3.8-6.7) нь өдөр бүр тогтмол, харин эрэгтэйчүүдийн 5.0 хувь (95%CI 4.0-6.1), эмэгтэйчүүдийн 1.6 хувь (95%CI 0.9-2.4) хааяа тамхи татдаг байна. (Дурслэл 3).

Дүрслэл 3: Тамхины хэрэглээний давтамж, хүйсээр



Тамхи хэрэглэгсийн хэрэглээний давтамжийг тодруулбал, 87.9 хувь (95%CI 85.8-90.0) нь өдөр бүр тогтмол тамхи татдаг байна. Түүнчлэн тамхи хэрэглэдэг эрэгтэйчүүдийн 89.5 хувь (95%CI 87.5-91.4), эмэгтэйчүүдийн 76.3 хувь (95%CI 66.5-86.0) өдөр бүр тогтмол тамхи татаж байсан ба энэ үзүүлэлтэд хүйсээр ялгаатай байдал ажиглагдсангүй (Хавсралт I, 7).

Тамхи татдаг хүмүүс ойролцоогоор 19.2 (95%CI 18.7-19.6) настайгаас тамхи татаж эхэлсэн ба энэ нь эрэгтэйчүүдийн хувьд 18.7 (95%CI 18.2-19.2) нас байхад эмэгтэйчүүдэд 23.2 (95%CI 21.3-25.1) нас байгаа нь статистикийн магадлал бүхий ялгаатай байна (Хүснэгт 16).

Хүснэгт 16. Тамхи хэрэглэж эхэлсэн дундаж нас

Насны бүлэг (жилийн)	Эрэгтэй			Эмэгтэй			Нийт хүн ам		
	n	Дундаж нас	95% CI	n	Дундаж нас	95% CI	n	Дундаж нас	95% CI
15-24	126	16.6	16.0-17.1	12	17.5	15.9-19.1	138	16.6	16.1-17.2
25-34	298	18.3	17.8-18.9	55	20.6	18.4-22.8	353	18.6	18.1-19.1
35-44	305	19.4	18.3-20.5	55	25.6	21.6-29.6	360	20.0	18.9-21.0
45-54	210	19.9	19.0-20.9	51	25.9	22.8-29.1	261	20.8	19.8-21.8
55-64	99	23.3	21.5-25.0	21	32.4	21.5-43.3	120	24.3	22.2-26.4
15-64	1038	18.7	18.2-19.2	194	23.2	21.3-25.1	1232	19.2	18.7-19.6

Тухайн тамхи татаж буй хүний тамхи татсан хугацаа нь өндөр эрсдэлийг дагуулж байдаг билээ. Судалгаанд хамрагдсан хүн амын дунд тамхи татаж буй жил дундажаар 15.8 (95%CI 14.9-16.6) жил бол эрэгтэйчүүд 16.1 (95%CI 15.1-17.0) жил, эмэгтэйчүүд 13.1 (95%CI 11.0-15.2) жил тус тус хугацаагаар тамхи татсан бөгөөд харин хүйсийн хувьд статистикийн магадлал бүхий ялгаатай байдал ажиглагдаагүй болно (Хавсралт I, 8).

Өдөр бүр тогтмол тамхи татдаг нийт хүмүүсийн 84.6 хувь (95%CI 78.8-90.3), үйлдвэрийн тамхи татдаг бол харин энэ үзүүлэлт хот сууринд амьдарч тамхи татдаг хүмүүсийн 99.6 хувь (95%CI 99.1-100.0), хөдөө орон нутгийнхны 71.0 хувь (95%CI 61.1-80.8) -ийг эзэлж байгаа нь статистик магадлал бүхий ялгаатай байна (Хавсралт I, 10).

Судалгаанд оролцож өдөр бүр тамхи татдаг гэсэн хариултыг өгсөн хүмүүс хоногт дундажаар 8.7 хувь (95%CI 7.8-9.6) ширхэг үйлдвэрийн тамхи татдаг бөгөөд эрэгтэйчүүд 8.9 хувь (95%CI 7.9- 9.8) ширхэг, эмэгтэйчүүд 7.0 хувь (95%CI 5.6-8.4) ширхэг янжуурыг тус тус татах байгаа нь наасны бүлэг болон хүйсийн хувьд статистикийн магадлал бүхий ялгаагүй байна.

Гэрийн дотор орчинд 42.9 хувь (95% CI 38.4-47.3) нь дам тамхидалтад ямар нэг хэмжээгээр өртдөг буюу 2 хүн тутмын 1 нь дам тамхидалтын эрсдэлт хүчин зүйлсийн орчинд амьдарч байна. Судалгаанд оролцсон хүн амын 35.6 хувь (95% CI 31.1-40.1) нь ажлын байрандаа дам тамхидалтад өртдөг байна.

Хүйсийн ялгаатай байдлаар авч үзэхэд эрэгтэйчүүдийн 38.2 хувь (95% CI 32.3-44.1), эмэгтэйчүүдийн 47.6 хувь (95%CI 43.3-51.9) гэрийн орчинд тамхитатаж байгаань статистикийн магадлал бүхий ялгаагүй байв. Ажлын байрандаа дам тамхидалтад эрэгтэйчүүдийн 43.3 хувь (95% CI 36.7-40.1), эмэгтэйчүүдийн 27.7 хувь (95% CI 24.0-31.3) өртдөг нь статистикийн магадлал бүхий ялгаатай байна.

Дүгнэлт

1. Монгол улсын хүн амын 27.7 хувь буюу 10 хүн тутмын гурав нь, 2 эрэгтэй тутмын нэг нь тамхи хэрэглэх эрсдэлт зан үйлтэй байна.
2. Тамхи хэрэглэдэг 4 хүн тутмын 1 (24.3%) нь өдөр бүр тогтмол тамхи татах байна. Эрэгтэйчүүдийн 43.0 хувь эмэгтэйчүүдийн 5.2 хувь тогтмол тамхи хэрэглэдэг байна.
3. Эрэгтэй, эмэгтэй тамхи хэрэглэгсдийн тамхи татсан нийт хугацаа болон өдөрт татдаг тамхины тоо хэмжээ ялгаагүй байгаа нь аль ч хүйсний тамхи татдаг хүмүүст эрсдэл өндөр байгааг харуулж байна.
4. Гэрийн дотоод орчинд дам тамхидалтад 2 хүн тутмын 1 нь, ажлын байранд 10 хүн тутмын 4 нь өртөж байгаа нь дам тамхидалтын орчин, тамхины угаанд өртдөг эрсдэлтэй хүмүүсийн хувь тодорхой хэмжээгээр өндөр байгааг харуулж байна.

Архины хэрэглээ

Энэхүү судалгаагаар хүн амын архи, согтууруулах ундааны хэрэглээний байдал, хэрэглээний давтамж, хэв маяг, эрсдлийн байдал зэргийг хүйс, насны булэг, байршилын үзүүлэлтүүдээр судлан, дүгнэлт өглөө.

Судалгааны хурээний нийт хүн амын 34.2 хувь (95%CI 28.7-39.6), үүнээс, эрэгтэйчүүдийн 24 хувь (95%CI 19.3-28.8), эмэгтэйчүүдийн 44.5 хувь (95%CI 38.1-51.0) архийг амьдралын туршид огт хэрэглэж байгаагүй гэжээ. Түүнчлэн судалгааны насны нийт хүн амын 7.4 хувь (95%CI 5.7-9.1) сүүлийн 12 сард архи хэрэглээгүй байсан ба энэ үзүүлэлтэд хүйсийн ялгаа ажиглагдсангүй (Хүснэгт 17).

Хүснэгт 17. Архины хэрэглээний байдал, насны булгээр

Насны булэг (жилийр)	n	Нийт хүн ам							
		Одоо архи хэрэглэгчид /сүүлийн 30 хоногт/	95% CI	Сүүлийн 12 сард архи хэрэглэгчид	95% CI	Сүүлийн 12 сард архи хэрэглээгүй хүмүүс	95% CI	Амьдралынхаа туршид архи огт хэрэглээгүй хүмүүс	95% CI
15-24	899	26.7	21.6-31.8	21.4	16.0-26.9	6.7	4.1-9.3	45.2	37.6-52.7
25-34	1525	47.5	42.1-53.0	19.1	15.7-22.6	7.6	5.7-9.5	25.7	20.1-31.4
35-44	1444	47.7	42.1-53.3	19.8	15.6-23.9	7.1	4.3-9.9	25.4	19.2-31.7
45-54	1046	44.0	39.1-48.9	18.8	15.0-22.6	8.4	6.0-10.9	28.8	23.3-34.4
55-64	524	33.0	28.0-38.1	15.7	10.4-20.9	9.3	5.9-12.6	42.1	34.1-50.0
65-69	5438	38.6	34.6-42.7	19.8	16.1-23.5	7.4	5.7-9.1	34.2	28.7-39.6


Архи, согтууруулах ундаа хэрэглэгчдийн 19.8 хувь (95%CI 16.1-23.5) сүүлийн 12 сард, 38.6 хувь (95%CI 34.6-42.7) сүүлийн 30 хоногт буюу одоогоор архи хэрэглэж байв. Сүүлийн 12 сард архи хэрэглэгчдийн дотор хүйсийн ялгаатай байдал ажиглагдсангүй. Харин эрэгтэйчүүдийн 49.8 хувь (95%CI 44.7-54.8), эмэгтэйчүүдийн 27.2 хувь (95%CI 23.0-31.3) нь сүүлийн 30 хоногт архи хэрэглэсэн ба одоогоор архи хэрэглэж байлаа (Хүснэгт 18).

Хүснэгт 18. Архины хэрэглээний байдал, хүйсээр

Хүйс	Одоо архи хэрэглэгчид /сүүлийн 30 хоногт/			Сүүлийн 12 сард архи хэрэглэгчид			Сүүлийн 12 сард архи хэрэглээгүй хүмүүс			Амьдралынхаа туршид архи огт хэрэглээгүй хүмүүс		
	n	%	95% CI	%	95% CI	%	95% CI	%	95% CI	%	95% CI	
Эрэгтэй	2217	49.8	44.7-54.8	20.1	15.9-24.4	6.1	4.4-7.7	24	19.3-28.8			
Эмэгтэй	3221	27.2	23.0-31.3	19.5	15.9-23.1	8.8	6.6-11.0	44.5	38.1-51.0			
Нийт	5438	38.6	34.6-42.7	19.8	16.1-23.5	7.4	5.7-9.1	34.2	28.7-39.6			

Архины хэрэглээний давтамжийн судалгаагаар, сүүлийн 12 сард архи согтууруулах ундаа хэрэглэгчдийн 62.0 хувь (95%CI 55.0-69.0) хааяа, 30.8 хувь (95%CI 25.2-36.2) сард 1-3 өдөр, 5.9 хувь (95%CI 3.6-8.3) 7 хоногт 1-4 өдөр, 0.7 хувь (95%CI 0.1-1.4) 7 хоногт 5-6 өдөр, харин 0.6 хувь (95%CI 0.2-0.9) өдөр бүр хэрэглэдэг гэж хариулжээ.

Дүрслэл 4: Сүүлийн 12 сард архи согтууруулах ундаа-хэрэглэсэн давтамж



Архины хэрэглээний давтамжийг хүйсээр авч үзэхэд:

- эрэгтэйчүүдийн 52.9 хувь (95%CI 44.7-61.2), эмэгтэйчүүдийн 75.8 хувь (95%CI 69.8-81.9) нь архийг сард 1-ээс багуу хаалаа
- харин эрэгтэйчүүдийн 37.2 хувь (95%CI 30.3-44.0), эмэгтэйчүүдийн 21 хувь (95%CI 15.9-26.1) нь сард 1-3 өдөр,
- эрэгтэйчүүдийн 8.3 хувь (95%CI 4.9-11.7), эмэгтэйчүүдийн 2.3 хувь (95%CI 0.9-3.6) нь 7 хоногт 1-4 өдөр,
- эрэгтэйчүүдийн 0.9 хувь (95%CI 0.2-1.6), эмэгтэйчүүдийн 0.4 хувь (95%CI 0.0-1.1) нь 7 хоногт 5-6 өдөр,
- эрэгтэйчүүдийн 0.6 хувь (95%CI 0.1-1.1), эмэгтэйчүүдийн 0.5 хувь (95%CI 0.0-0.9) нь өдөр бүр архи хэрэглэдэг гэж хариулсан байдлаас харахад архины хэрэглээний давтамж эрэгтэйчүүдэд өндөр эрсдэлтэй байна (Дүрслэл 3) (Хавсралт I, 12-13).

Архи, согтууруулах ундаа хэрэглэгчдийн хэрэглээний хэв маягийг сүүлийн 30 хоногт уусан тохиолдлын тоо болон нэг удаад уусан стандарт уултын хэмжээ зэргээр тодруулан судаллаа. Архи согтууруулах ундаа хэрэглэгчид сүүлийн 30 хоногт дундажаар 3.6 удаа (95%CI 2.7-4.6); үүнээс эрэгтэйчүүд 3.8 удаа (95%CI 2.9-4.8), эмэгтэйчүүд 3.3 (95%CI 2.1-4.6) удаа тус тус архи ууж хэрэглэсэн байв. Нэг удаагийн уултаар дундажаар 7.7 (95%CI 7.1-8.3) стандарт уулт хэрэглэсэн ба энэ үзүүлэлт эрэгтэйчүүдэд 9.2 стандарт уулт (95%CI 8.5-9.9), эмэгтэйчүүдэд 5.1 стандарт уулт (95%CI 4.5-5.6) тус тус байна. Аль ч насын бүлэгт эрэгтэйчүүд нэг удаагийн уулгаар эмэгтэйчүүдээс 2 дахин их стандарт уулт бүхий архи согтууруулах ундааг хэрэглэж байна. (Хүснэгт 19).

Хүснэгт 19. Архи согтууруулах ундаа хэрэглэгсдийн 1 удаагийн уултаар хэрэглэж буй стандарт уултын дундаж тоо (сүүлийн 30 хоногт)

Насны бүлэг (жилээр)	Эрэгтэй			Эмэгтэй			Нийт		
	n	Уултын тоо	95% CI	n	Уултын тоо	95% CI	n	Уултын тоо	95% CI
15-24	113	7.3	6.1-8.5	94	4.0	3.0-5.0	207	6.0	5.2-6.9
25-34	332	9.5	8.5-10.6	280	5.3	4.5-6.1	612	8.0	7.1-8.8
35-44	296	10.0	8.9-11.0	274	5.9	5.1-6.8	570	8.5	7.6-9.3
45-54	212	10.0	8.7-11.4	172	5.3	4.5-6.1	384	8.4	7.5-9.4
55-64	107	10.1	8.6-11.6	54	4.2	3.2-5.2	161	8.5	7.2-9.8
15-64	1060	9.2	8.5-9.9	874	5.1	4.5-5.6	1934	7.7	7.1-8.3

Архи, согтууруулах ундааны хэрэглээний 1 хоногт уух стандарт уултын дундаж үзүүлэлтэд түшиглэн судалгааны насыны нийт хүн амын хуреэнд архины хэрэглээний эрсдлийн байдлыг үнэлж үзлээ. Судалгааны дүнгээр нийт хүн амын 1.1 хувь (95%CI 0.4-1.8), үүнээс эрэгтэйчүүдийн 1.5 хувь (95%CI 0.6-2.4), эмэгтэйчүүдийн 0.7 хувь (95%CI 0.2-1.2) нь 3-р зэрэглэлийн буюу өндөр эрсдэлтэй хэрэглэгсэд байгаагаас үзэхэд эрэгтэйчүүдийн дунд архины өндөр эрсдэлтэй хэрэглээ 2 дахин их байна. Архины хэрэглээний эрсдлийн 2-р зэрэг буюу дунд зэргийн эрсдэлтэй хэрэглээний тархалтын байдал нийт хүн амын дунд 1.0 хувь (95%CI 0.5-1.5), үүнээс эрэгтэйчүүдэд 1.2 хувь (95%CI 0.5-1.8), эмэгтэйчүүдэд 0.8 хувь (95%CI 0.3-1.3) буюу хүйсийн ялгаагүй байв (Хүснэгт 20).

Хүснэгт 20. Архины хэрэглээний эрсдлийн байдал, нийт хүн амын дунд, хүйсээр

Хүйс	Дунд			Өндөр		
	n	%	95% CI	%	95% CI	
Эрэгтэй	2164	1.2	0.5-1.8	1.5	0.6-2.4	
Эмэгтэй	3212	0.8	0.3-1.3	0.7	0.2-1.2	
Нийт	5376	1	0.5-1.5	1.1	0.4-1.8	

Хоногт ууж хэрэглэх стандарт уултын дундаж үзүүлэлтэнд түшиглэн сүүлийн 30 хоногт архи хэрэглэсэн хүмүүсийн эрсдлийн зэргийг тогтоож үзэхэд нийт эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн 94.5 хувь (95%CI 92.1-96.9) нь бага, эрэгтэйчүүдийн 2.4 хувь (95%CI 1.1-3.7), эмэгтэйчүүдийн 2.9 хувь (95%CI 1.1-4.6) дунд, эрэгтэйчүүдийн 3.1 хувь (95%CI 1.4-4.7), эмэгтэйчүүдийн 2.6 хувь (95%CI 1.0-4.3) өндөр эрсдэлтэй бүлэгт тус тус хамарагдаж байв (Хүснэгт 21).

Хүснэгт 21. Архины хэрэглээний эрсдлийн байдал, архи согтууруулах ундаа хэрэглэгсэдийн дунд, хүйсээр

Хүйс	Бага				Дунд				Өндөр			
	n	Хэмжээ /гр/	%	95% CI	Хэмжээ /гр/	%	95% CI	Хэмжээ /гр/	%	95% CI		
Эрэгтэй	1125	<40	94.5	92.1-96.9	40-59.9	2.4	1.1-3.7	>60	3.1	1.4-4.7		
Эмэгтэй	885	<20	94.5	91.6-97.4	20-39.9	2.9	1.1-4.6	>40	2.6	1.0-4.3		

Архины хэрэглээний эрсдлийн нэг чухал үзүүлэлт бол архийг хэтрүүлэн уух явдал юм. Энэ нь 1 удаагийн уултаар эрэгтэйчүүд 5 буюу түүнээс дээш, эмэгтэйчүүд 4 буюу түүнээс дээш стандарт уултын хэмжээний архи согтууруулах ундааг ууж хэрэглэснээр тодорхойлогддог билээ. Судалгааны дүнгээр, архи хэрэглэдэг эрэгтэйчүүдийн 39.7 хувь (95%CI 35.0-44.4), эмэгтэйчүүдийн 15.1 хувь (95%CI 12.4-17.7) архийг хэтрүүлэн хэрэглэдэг ба архийг зохисгүй байдлаар хэрэглэдэг байдал эрэгтэйчүүдийг эмэгтэйчүүдтэй харьцуулахад 2.5 дахин илүү байв (Хүснэгт 22).

Хүснэгт 22. Архийг хэтрүүлэн хэрэглэгсдийн байдал, хүйсээр

Хүйс	Стандарт уулт	Архи хэтрүүлэн хэрэглэсэн хүний эзлэх хувь		
		n	%	95% CI
Эрэгтэй	≥5	2217	39.7	35.0-44.4
Эмэгтэй	≥4	3221	15.1	12.4-17.7

Архи, согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэх байдлыг насын бүлгээр судлахад 25-44 насын эрэгтэйчүүдийн талаас илүү хувь (51.5% ба 52%), мөн энэ насын 5 эмэгтэй тутмын 1 нь (18.7% ба 20.5%) архийг зохисгүй байдлаар хэрэглэдэг дадалтай байдал ажиглагдлаа (Хавсралт I, 16).

Сүүлийн 30 хоногт, архи согтууруулах ундааг ууж хэрэглэхдээ стандарт уултаас хэтрүүлж уусан тохиолдлын тоог тооцож үзэхэд эрэгтэйчүүд дундажаар 2.1 (95%CI 1.7-2.4), эмэгтэйчүүд 1.0 (95%CI 0.8-1.1) удаа тус тус хэтрүүлж уужээ. Мөн сүүлийн 30 хоногт, нэг удаагийн уултаар хамгийн их уусан стандарт уултын дундаж хэмжээг тооцож үзэхэд, архи, согтууруулах ундаа хэрэглэдэг нийт хүн амьн дунд 8.8 стандарт (95%CI 8.2-9.4), эрэгтэйчүүдэд 10.7 (95%CI 9.8-11.5), эмэгтэйчүүдэд 5.5 (95%CI 4.9-6.2) стандарт уулт тус тус байв (Хавсралт I, 17).

Дүгнэлт

1. Судалгааны насны 3 хүн тутмын 1 нь архи согтууруулах ундааг амьдралынхаа туршид огт хэрэглээгүй байна. Хүн амьн 38.6 хувь, эрэгтэйчүүдийн 49.8 хувь, харин эмэгтэйчүүдийн 27.2 хувь нь сүүлийн 1 сард буюу одоогоор архи хэрэглэж байна.
2. Эрэгтэйчүүдийн архи согтууруулах ундааны хэрэглээний давтамж эмэгтэйчүүдийнхээс илүү байна.
3. Нэг удаад уухдаа эрэгтэйчүүд 9.2 стандарт уулт, эмэгтэйчүүд 5.1 стандарт уултын хэмжээний архи согтууруулах ундааг хэрэглэж байна.
4. Эрэгтэйчүүдийн 39.7 хувь, эмэгтэйчүүдийн 15.1 хувь архийг хэтрүүлэн хэрэглэдэг ба архийг зохисгүй байдлаар хэрэглэдэг байдал эрэгтэйчүүдэд эмэгтэйчүүдтэй харьшуулахад 2.5 дахин илүү байв.

Жимс, хүнсний ногооны хэрэглээ

Судалгаанд хамрагдсан хүн амын жимс, хүнсний ногооны хэрэглээг “7 хоногийн хэрэглээний давтамж”, “хоногийн дундаж хэрэглээ” болон нийт хүн амын жимс, хүнсний ногоо хэрэглээний байдал зэрэг үзүүлэлтээр тус тус үнэлэв.

Жимсний 7 хоногийн хэрэглээний давтамж

Судалгаанд хамрагдсан хүн амын жимсний “7 хоногийн хэрэглээний давтамж”- ийт хүн амын байршил болон хүйсээр ангилан хүснэгт 23-д харуулав.

Хүснэгт 23. Жимсний 7 хоногийн хэрэглээний давтамж (хүйс, байршилаар)

Хүйс, байршил	Судлагдсан хүн амын тоо	Хэрэглэж буй өдрийн тоо	
		Дундаж	95% CI
Хүйс	Эрэгтэй	2217	1.0
	Эмэгтэй	3220	1.4
	Нийт	5437	1.2
Байршил	Хот	2546	1.5
	Хөдөө	2891	0.8
	Нийт	5437	1.2

Судалгаанд хамрагдсан нийт хүн ам 7 хоногийн 1.2 өдөр нь (95%CI 0.9-1.4) жимс хэрэглэж байгаагаас эмэгтэйчүүд 7 хоногт 1.4 өдөр, эрэгтэйчүүд 1.0 өдөр тус тус жимс хэрэглэж, эмэгтэйчүүдийн жимс хэрэглэсэн өдрийн тоо нь эрэгтэйчүүдийнхээс илүү байв (95%CI 1.2-1.6, 0.7-1.2) (Хавсралт I, 18).

Байршилаар авч үзвэл хотын хүн ам 7 хоногийн 1.5 өдөр (95%CI 1.3-1.7), хөдөөгийн хүн ам 0.8 өдөр нь (95%CI 0.5-1.1) тус тус жимс хэрэглэж, хотын хүн амын жимс хэрэглэсэн өдрийн тоо нь хөдөөгийн хүн амынхаас илүү байв (Хавсралт II, 2).

Долоо хоногт жимс хэрэглэсэн өдрийн тоог судалгаанд хамрагдсан хүн амын суурьшил ба хүйсээр ангилж үзвэл хотын эрэгтэйчүүд 1.3 өдөр (95%CI 1.0-1.6), хөдөөгийн эрэгтэйчүүд 0.6 өдөр (95% CI 0.4-0.9), хотын эмэгтэйчүүд 1.7 өдөр (95%CI 1.6-1.9), хөдөөгийн эмэгтэйчүүд 1.0 өдөр (95%CI 0.6-1.3) тус тус жимс хэрэглэж, хотынх нь хөдөөгийн хүн амынхаас илүү байв.

Жимсний 7 хоногийн хэрэглээний давтамжийг судалгаанд хамрагдсан хүн амын насын булгээр харьцуулахад 15-24 насын хүмүүс 7 хоногт 1.4 өдөр нь жимс хэрэглэсэн байгаа нь бусад насын булгийн хүмүүсийн 7 хоногийн жимсний хэрэглээний давтамжаас илүү байв (95%CI 1.1-1.6).

Хүн амын жимсний хоногийн дундаж хэрэглээ

Жимсний хоногийн дундаж хэрэглээг судалгаанд хамрагдсан хүн амын хүйс ба байршилаар ангилик, хүснэгт 24-д харуулав.

Хүснэгт 24. Жимсний хоногийн дундаж хэрэглээ (хүйс, байршилаар)

Хүйс, байршил	N	Өдөрт хэрэглэж буй хэмжээ (нэгжээр)	
		дундаж	95% CI
Хүйс	Эрэгтэй	2208	0.3
	Эмэгтэй	3206	0.5
	Нийт	5414	0.4
Байршил	Хот	2534	0.5
	Хөдөө	2880	0.3
	Нийт	5414	0.4

Хоногт жимс хэрэглэх хэмжээ нь нийт хүн амд 0.4 нэгж (95%CI 0.3-0.5) үүнээс эрэгтэйчүүд 0.3 нэгж (95%CI 0.2-0.5), эмэгтэйчүүд 0.5 нэгж (95%CI 0.4-0.6) жимсийг хоногт тус тус хэрэглэж, эмэгтэйчүүдийн дундаж хэрэглээ нь эрэгтэйчүүдийнхээс өндөр байв (95% CI 0.4-0.6, 0.2-0.5) (Хавсралт I, 19).

Хоногт жимс хэрэглэх дундаж хэмжээ хотын хүн амд 0.5 нэгж (95%CI 0.4-0.7), хөдөөгийн хүн амд 0.3 нэгж (95%CI 0.1-0.5) байсан бөгөөд хотынхон хөдөөгийнхнэөс өндөр байв. Харин дундаж хэрэглээг хүн амын насны бүлгээр харьцуулахад статистикийн магадлал бүхий ялгаа ажиглагдсангүй.

Хүнсний ногооны 7 хоногийн хэрэглээний давтамж

Судалгаанд хамрагдсан хүн амын темснөөс бусад хүнсний ногооны “7 хоногийн хэрэглээний давтамж”- ийг хүн амын хүйс болон байршилаар ангилан хүснэгт 25-т харуулав.

Хүснэгт 25.-Хүнсний ногооны 7 хоногийн хэрэглээ (хүйс, байршилаар)

Хүйс, байршил	N	Хэрэглэж буй өдрийн тоо	
		дундаж	95% CI
Хүйс	Эрэгтэй	2215	4.6
	Эмэгтэй	3220	4.9
	Нийт	5435	4.8
Байршил	Хот	2546	5.8
	Хөдөө	2889	3.8
	Нийт	5435	4.8

Судалгаанд хамрагдсан нийт хүн ам нь 7 хоногт дундажаар 4.8 өдөр (95%CI 4.2-5.3), эмэгтэйчүүд 4.9 өдөр, эрэгтэйчүүд 4.6 өдөр тус тус хүнсний ногоо хэрэглэсэн бөгөөд эмэгтэйчүүдийн хүнсний ногоо хэрэглэсэн өдрийн тоо нь эрэгтэйчүүдийнхээс илүү байв (95%CI 4.4-5.5, 4.0-5.2) (Хавсралт I, 20).

Хүнсний ногоог хотын хүн ам 5.8 өдөр (95%CI 5.5-6.1), хөдөөгийн хүн ам 3.8 өдөр (95%CI 3.0-4.6) тус тус хэрэглэсэн бөгөөд 7 хоногт хотын хүн амын хүнсний ногоо хэрэглэсэн өдрийн тоо нь хөдөөгийн хүн амынхаас илүү байв (95% CI 5.5-6.1, 3.0-4.6). Долоо хоногт хүнсний ногоо хэрэглэсэн өдрийн тоог хот, хөдөөгийн хүн амд хүйсээр ангилик үзвэл хотын эрэгтэйчүүд 5.8 өдөр (95%CI 5.5-6.1), хөдөөгийн эрэгтэйчүүд 3.6 өдөр (95% CI 2.8-4.4), хотын эмэгтэйчүүд 5.9 өдөр (95%CI 5.6-6.2), хөдөөгийн эмэгтэйчүүд 3.9 өдөр (95%CI 3.1-4.7) тус тус хүнсний ногоо хэрэглэж, хотын хүн ам болон хотын эмэгтэйчүүдийн хүнсний ногоо хэрэглэсэн өдрийн тоо нь хөдөөгийн хүн ам болон хөдөөгийн эрэгтэйчүүдээс илүү байв.

Хоногт хэрэглэх хүнсний ногооны дундаж хэмжээ

Дундаж хэрэглээг судалгаанд хамрагдсан хүн амыг хүйс, байршилаар ангилж, хүснэгт 26-д харуулав.

Хүснэгт 26. Хоногт хэрэглэх хүнсний ногооны дундаж хэмжээ

Хүйс, байршил	N	Өдөрт хэрэглэж буй хэмжээ (нэгжээр)	
		дундаж	95% CI
Хүйс	Эрэгтэй	2204	1.4 1.1-1.6
	Эмэгтэй	3207	1.6 1.2-1.9
	Нийт	5411	1.4 1.2-1.7
Байршил	Хот	2534	1.9 1.6- 2.2
	Хөдөө	2877	1.0 0.7-1.3
	Нийт	5411	1.4 1.2-1.7

Хоногт хэрэглэх хүнсний ногооны дундаж нь нийт хүн амд дундажаар 1.4 нэгж (95%CI 1.2-1.7), үүнээс эрэгтэйчүүд 1.4 нэгж, эмэгтэйчүүд 1.6 нэгж тус тус хүнсний ногоог хоногт хэрэглэж хоногт, эмэгтэйчүүдийн дундаж хэрэглээ нь эрэгтэйчүүдийнхээс өндөр байв (95% CI 1.2-1.9, 1.1-1.6) (Хавсралт I, 21).

Хоногт хэрэглэх хүнсний ногооны дундаж хотын хүн амд 1.9 нэгж, хөдөөгийн хүн амд 1.0 нэгж байсан бөгөөд хотын хүн амын дундаж хэрэглээ нь хөдөөгийн хүн амынхаас өндөр байв (95%CI 1.6-2.2, 0.7-1.3). Хүнсний ногооны дундаж хэрэглээг насын бүлгээр харьцуулахад 25-34 насын бүлгийн хүмүүс хоногт дунджаар 1.5 нэгж хүнсний ногоо хэрэглэсэн байгаа нь бусад насын бүлгийн хүмүүсийн дундаж хэрэглээнээс илүү байв (95% CI 1.1-1.9). Харин хоногт хэрэглэх хүнсний ногооны дундаж хэмжээг хүйсээр харьцуулахад 25-34 насын эрэгтэйчүүд хоногт 1.5 нэгж (95% CI 1.1-1.9), 15-24 насын бүлгийн эмэгтэйчүүд хоногт 1.7 нэгж (95%CI 1.4-2.0) хүнсний ногоо тус тус хэрэглэсэн байгаа нь бусад насын бүлгийн эрэгтэйчүүд ба эмэгтэйчүүдийн дундаж хэрэглээнээс статистикийн магадлал бүхий өндөр байв.

Хоногт хэрэглэх жимс, хүнсний ногооны дундаж хэмжээ

Судалгаанд хамрагдсан нийт хүн ам нь дунджаар 1.8 нэгж, үүнээс эмэгтэйчүүд 2.0 нэгж, эрэгтэйчүүд 1.7 нэгж жимс, хүнсний ногоог хоногт тус тус хэрэглэж байсан бөгөөд эмэгтэйчүүдийн хэрэглээ нь эрэгтэйчүүдийнхээс өндөр байв (95%CI 1.6-2.4, 1.3-2.0). (Хүснэгт 27) (Хавсралт I, 22)

Хүснэгт 27. Хоногт хэрэглэх жимс, хүнсний ногооны дундаж хэмжээ

Хүйс, байршил	N	Өдөрт хэрэглэж буй хэмжээ (нэгжээр)	
		дундаж	95% CI
Хүйс	Эрэгтэй	2217	1.7 1.3-2.0
	Эмэгтэй	3219	2.0 1.6 -2.4
	Нийт	5436	1.8 1.5-2.2
Байршил	Хот	2545	2.4 2.0-2.8
	Хөдөө	2891	1.3 0.8-1.8
	Нийт	5436	1.8 1.5-2.2


Хоногт хэрэглэх жимс, хүнсний ногооны дундаж нь хотын хүн амд 2.4 нэгж, хөдөөгийн хүн амд 1.3 нэгж байсан ба хотын хүн амын дундаж хэрэглээ нь хөдөөгийн хүн амын дундаж хэрэглээнээс өндөр байв (95%CI 2.0-2.8 ба 0.8-1.8) (Хүснэгт 27).

Судалгаанд хамрагдсан нийт хүн амын хоногт хэрэглэх жимс ба төмснөөс бусад хүнсний ногооны дундаж хэрэглээг “нэгж” хэмжигдэхүүнээр 3 ангилж, үзүүлэлтүүдийг насын бүлгээр мөн ангилж, хүснэгт 28-д харуулав. Нийт хүн амын 33,3% (95%CI 25.9-40.7) жимс, хүнсний ногоо огт хэрэглээгүй, 46,5 хувь (95%CI 40.2-52.9) хоногт 1-2 нэгж, 12.4 хувь (95%CI 8.9-16.0) 3-4 нэгж, зөвхөн 7,7 хувь (95%CI 4.2-11.3) нь хоногт 5 буюу түүнээс дээш нэгж жимс, хүнсний ногоо хэрэглэж байна. Нийт дунгээр хүн амын 92.3 хувь нь жимс, хүнсний ногоо огт хэрэглээгүй буюу хоногт 5-аас бага нэгж хэрэглэж байна (Дүрслэл 5) (Хавсралт I, 25).

Хүснэгт 28. Жимс, хүнсний ногооны хоногийн дундаж хэрэглээний үзүүлэлт, хүн амын насын бүлэг, “нэгж” хэмжигдэхүүний ангилалаар

Насны бүлэг /жинзэр/	N	Нийт						Хоногт 5 ба түүнээс дээш нэгж %	95% CI
		Хэрэглээгүй %	95%CI	Хоногт 1-2 нэгж %	95% CI	Хоногт 3-4 нэгж %	95% CI		
15-24	898	28.8	19.8-37.9	49.7	41.1-58.2	12.4	8.2-16.6	9.1	5.0-13.2
25-34	1524	34.2	25.8-42.6	44.8	37.7-51.8	12.9	8.8-17.0	8.2	3.0-13.3
35-44	1444	36.4	28.0-44.9	44.2	38.1-50.2	12.2	8.1-16.4	7.2	3.5-10.9
45-54	1046	38.1	31.5-44.8	45.6	40.0-51.2	10.7	7.2-14.2	5.5	2.7-8.3
55-64	524	34.7	26.6-42.8	45.0	37.2-52.8	15.3	9.6-21.0	5.1	0.6-9.5
15-64	5436	33.3	25.9-40.7	46.5	40.2-52.9	12.4	8.9-16.0	7.7	4.2-11.3

Дүрслэл 5. Хүн амын жимс, хүнсний ногооны хоногийн хэрэглээ нэгжээр



Жимс ба хүнсний ногоо хэрэглэсэн хүмүүсийн дунд 35-44 насын бүлгийхэн 36.4 хувь (95% CI 28.0-44.9), 45-54 насын бүлгийхэн 38.1 хувийг (95%CI 31.5-44.8) тус тус эзлэж байгаа нь бусад насын бүлгээс статистикийн магадлал бүхий өндөр байв. Харин жимс, хүнсний ногоо хэрэглэсэн хүн амын үзүүлэлтийг “нэгж” хэмжигдэхүүний ангилалаар авч үзвэл 46.5 хувь нь 1-2 “нэгж”, 12.4 хувь нь 3-4 нэгж, 7.7 хувь нь 5 ба түүнээс дээш хэмжээний жимс, хүнсний ногоог хоногт хэрэглэсэн бөгөөд судалгаанд хамрагдсан хүн амын дийлэнх нь (95%CI 40.2-52.9, 8.9-16.0, 4.2-11.3) хоногт 1-2 нэгж жимс, хүнсний ногоо хэрэглэсэн байв. 1-2 “нэгж” жимс, хүнсний ногоо хэрэглэсэн хүн амын үзүүлэлтийг насын бүлгээр авч үзвэл 15-24 насын бүлгийхэн 49.7 хувь (95%CI 41.1-58.2)-ийг эзлэж байгаа нь бусад насын бүлгийн хүн амын үзүүлэлтээс статистикийн магадлал бүхий өндөр байв (95%CI 41.1-58.2, 40.0-51.2, 38.1-50.2, 37.7-51.8, 37.2-52.8) (Хавсралт I, 23-24).


Хоногт хэрэглэх жимс ба хүнсний ногооны дундаж хэмжээг “нэгж” хэмжигдэхүүнээр 3 ангилж, үзүүлэлтүүдийг судалгаанд хамрагдсан хүн амын байршилаар ангилж, хүснэгт 29-д харуулав.

Хүснэгт 29. Жимс, хүнсний ногооны хоногийн хэрэглээний үзүүлэлт хүн амын байршил ба “нэгж” хэмжигдэхүүний ангилалаар

Байршил	Тоо	Эрэгтэй, Эмэгтэй						5 ба түүнээс дээш нэгж хэрэглээн үзүүлэлт /%/	95% CI
		Жимс, хүнсний ногоо хэрэглэгүй үзүүлэлт /%/	95% CI	1-2 нэгж хэрэглэсэн үзүүлэлт /%/	95% CI	3-4 нэгж хэрэглэсэн үзүүлэлт /%/	95% CI		
Хот	2545	14.6	11.2-18.1	58.1	49.6-66.7	15.9	11.5-20.3	11.4	5.5-17.2
Хөдөө	2891	51.3	38.9-63.7	35.4	27.7-43.0	9.1	3.8-14.4	4.2	0.3-8.2
Нийт	5436	33.3	24.5-42.0	46.5	39.6-58.5	12.4	8.8-16.0	7.7	4.1-11.4

Судалгаанд хамрагдсан нийт хүн амын 33.3 хувь (95%CI 24.5-42.0) нь, хотын хүн амын 14.6 хувь нь, хөдөөгийн хүн амын 51.3 хувь нь тус тус жимс, хүнсний ногоо хэрэглэдэггүй бөгөөд эдгээрийн дотор хөдөөгийн хүн амын үзүүлэлт өндөр хувийг эзлэж байв (95%CI 38.9-63.7). Харин жимс, хүнсний ногоо хэрэглэдэг хүмүүсийн 46.5 хувь нь 1-2 нэгж, 12.4 хувь нь 3-4 нэгж, 7.7 хувь нь 5 ба түүнээс дээш нэгжээр жимс, хүнсний ногоо хэрэглэдэг бөгөөд судалгаанд хамрагдсан хүн амын дийлэнх хувь нь (95%CI 39.6-58.5, 8.8-16.0, 4.1-11.4) хоногт 1-2 нэгж жимс, хүнсний ногоо хэрэглэсэн байв (Дурслэл 6).

Дурслэл 6. Хүн амын жимс, хүнсний ногооны хоногийн хэрэглээ, нэгжээр




Хотын хүн амын 58.1 хувь (95%CI 49.6-66.7), хөдөөгийн хүн амын 35.4 хувь (95% CI 27.7-43.0) нь тус тус хоногт 1-2 нэгж жимс, хүнсний ногоо хэрэглэсэн байхад хоногт 3-4 нэгж жимс, хүнсний ногоо хэрэглэж буй хүмүүсийн 15.9 хувь (95%CI 11.5-20.3)-ийг хот, 9.1 хувь (95%CI 3.8-14.4)-ийг хөдөөгийн хүн ам эзлэж байв. Мөн хоногт 5 ба түүнээс дээш нэгжээр жимс, хүнсний ногоо хэрэглэсэн хүмүүсийн 11.4 хувь (95% CI 5.5-17.2)-ийг хот, 4.2 хувь (95%CI 0.3-8.2)-ийг хөдөө орон нутгийн хүмүүс эзлэж байв. Эдгээр дунгээс үзвэл хотын хүн амын жимс, хүнсний ногооны хэрэглээний үзүүлэлт нь хөдөөгийн хүн амын жимс, хүнсний ногооны хэрэглээний үзүүлэлтээс статистикийн магадлал бүхий өндөр байна (Хавсралт II, 10-12).

Өөх тосны хэрэглээ

Гэрийн нөхцөлд хоол хүнс бэлтгэхдээ судалгаанд хамрагдсан хүн амын 77.1 хувь (95%CI 70.3-83.9) нь ургамлын тос, 17.1 хувь (95%CI 10.8-23.3) нь амьтны гаралтай тос, 5.5 хувь (95%CI 3.3-7.8) нь бусад төрлийн тос хэрэглэдэг, 0.3 хувь (95%CI 0.1-0.5) нь тосыг огт хэрэглэдэггүй байна.

Дүрслэл 7. Өөх тосны хэрэглээ (байршилаар)



Судалгаанд хамрагдсан эрэгтэйчүүдийн 73.7 хувь нь (95%CI 65.9-81.5) ургамлын тос, 20.3 хувь (95%CI 12.8-27.9) нь амьтны гаралтай өөх тос, 5.5 хувь (95%CI 3.2-7.8) нь бусад төрлийн ургамлын гаралтай тос тус тус хэрэглэсэн бөгөөд 0.4 хувь нь тосыг огт хэрэглээгүй байна.

Хотын хүн амын 94.1 хувь (95%CI 91.5-96.7) нь, хөдөөгийн хүн амын 60.7 хувь (95%CI 48.6-72.7) нь ургамлын тос хэрэглэж байна. Харин амьтны гаралтай тосны хэрэглээний үзүүлэлт нь хотын хүн амын дунд 2.3 хувь (95%CI 1.3-3.3) байхад хөдөөгийн хүн амын дунд 31.3 хувь (95%CI 19.9-42.8) байв (Дүрслэл-7).

Давсны хэрэглээ

Өрхийн нэг гишүүний хоногт хэрэглэх давсны хэмжээ 7.3 гр (95%CI 6.9-7.7) байгаагаас хөдөөгийн хүн ам хоногт дундажаар 8.1 г давс, хотын хүн ам дундажаар 6.5 г давс хэрэглэж байна. Хөдөөгийн хүн амын давсны хэрэглээ нь хотын хүн амын давсны хэрэглээнээс өндөр байв (95% CI 6.1-6.9, 7.5-8.6) (Хавсралт I, 26 ; II, 13).

Дүгнэлт

- Монголын хүн ам хоногт дундажаар 1.8 нэгж жимс, хүнсний ногоо хэрэглэж, энэ нь ДЭМБ-ын зөвлөмж хэмжээнээс 3.2 нэгжээр доогуур байна.
- Монголын хүн амын 92.3 хувь нь хоногт 5 нэгжээс бага жимс, хүнсний ногоо хэрэглэж байна. Хөдөөгийн хүн амын жимс, хүнсний ногооны хэрэглээ нь хотын хүн амынхаас 2 дахин бага байна.
- Хотын хүн ам хоол хүнсээс бэлтгэхдээ ургамлын тос, хөдөөгийн хүн ам амьтны гаралтай өөх тос түлхүү хэрэглэж байна.
- Хүн амын давсны хоногийн дундаж хэрэглээ 7.3 грамм байгаа ба, хөдөөгийн хүн амын давсны хэрэглээ хотын хүн амынхаас 1,6 граммаар их байна.


Ходолгөөний идэвхи

Нийт хүн амд хөдөлгөөнийг эрчим, зарцуулсан хугацаагаар болон хүйс, насын бүлэг, хот, хөдөөгөөр харьцуулан судалсан болно. Хөдөлгөөнийг эрчимээр нь өндөр, дунд эрчимтэй хөдөлгөөн, бага гэсэн 3 хэсэгт хувааж авч узсэн болно.

Өндөр (high) эрчимтэй идэвхитэй хөдөлгөөн. Судалгааны дүнгээс үзвэл идэвхтэй хөдөлгөөн хийдэг хүн амын тархалт 80% байгаагаас эрэгтэйчүүд (82.5%), эмэгтэйчүүд (78.9%) байна. Насны бүлгийн хувьд хөдөлгөөний эрчим эрэгтэйчүүдэд 15-24 насанд (85.6%) дээд цэгтээ хүрч нас ахих тусам аажмаар бууран 55-64 насанд (63.4%) доод цэгтээ хүрсэн бол энэ үзүүлэлт эмэгтэйчүүдэд 35-44 насанд (83.3%) дээд цэгтээ хүрч 55-64 насанд (73.2%) доод цэгтээ хүрсэн байна. Судалгааны дүнгээс харахад аль аль хүйсэнд 55-64 насанд идэвхтэй хөдөлгөөн хийдэг хүний хувь багассан, эмэгтэйчүүдэд идэвхтэй хөдөлгөөнхийх амьдралын хэв маяг эрчүүдээс 20 насаар хожуу байна (Дурслэл 8) (Хавсралт I, 27-29).

Идэвхтэй хөдөлгөөн хийж буй хүн амыг хот, хөдөөгөөр нь харьцуулан үзвэл хөдөөд (88.1%) өндөр эрчимтэй идэвхтэй хөдөлгөөн хийдэг хүн ам хотоос (73.3%) 14.8 хувиар илүү байна. Хотын эрэгтэйчүүд 75.1 хувь (95%CI 67.1-83.2) байгаа нь хөдөөгийн эрэгтэйчүүдийн 89.2 хувиин (95%CI 84.3-94.1) үзүүлэлтээс 14.1 хувиар, эмэгтэйчүүдэд энэ үзүүлэлт хотын эмэгтэйчүүд 71.7 хувиин (95%CI 63.1-80.4) байгаа нь хөдөөгийн эмэгтэйчүүдийн 87.0 хувиин (95%CI 79.6-94.3) үзүүлэлтээс 15.3 хувиар тус тус бага байна (Хавсралт II, 14-16).

Дурслэл 8. Идэвхитэй хөдөлгөөн хийдэг хүн амын хувь(насын бүлэг, хүсээр)



Дунд (moderate) зэргийн эрчимтэй идэвхитэй хөдөлгөөн. Нийт хүн амын 11.7 хувь (95%CI 8.7-14.7) дунд зэргийн эрчимтэй хөдөлгөөн хийдгээс эрэгтэйчүүд 10.0 хувь (95%CI 7.4-12.7), эмэгтэйчүүд 13.4 хувь (95%CI 9.4-17.4) байгаа бөгөөд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 3.4 хувиар илүү байна. Дунд зэргийн эрчимтэй хөдөлгөөн хийж буй байдлыг насын бүлгээр нь задлаж үзвэл эрэгтэйчүүд 15-44 насанд нас ахих тутамд (10.3%, 8.5%, 7.6%) аажмаар бууран 45-65 насанд (11.5%, 18.6%) нэмэгдэн хамгийн дээд цэгтээ хүрсэн бол эмэгтэйчүүдийн хувьд 15-24 насанд (16%) хамгийн дээд цэгтээ бууран 35-44 хамгийн доод цэгтээ (10.4%) хүрч 45-64 насанд аажмаар (13.2%, 14.4%) өссөн үзүүлэлттэй байна. Насны бүшийн хувьд авч үзэхэд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн 35-44 насанд дунд зэргийн эрчимтэй хөдөлгөөн нийтлэг бага байгаа ч нас ахих тусам 55-64 насандаа харьцангуй нэмэгдсэн зөрөг дүнтэй байна.

Хүн амыг хот, хөдөөгөөр нь дунд зэргийн эрчимтэй хөдөлгөөн хийж буй байдлаар нь ангилж үзвэл хотод хүн амын 15.3 хувь (95%CI 11.2-19.3) нь дунд зэргийн эрчимтэй хөдөлгөөн хийж байгаа бол хөдөөд үүнээс 8.2 хувь (4.1-12.3) буюу 2 дахин бага байна.

Биеийн хүч бага (low) шаардсан идэвхитэй хөдөлгөөн. Нийт хүн амын 7.5 хувь хөдөлгөөний идэвхгүй эрдэлт бүлэгт хамрагдаж байгаа бөгөөд үүнээс эрэгтэйчүүд 7.4 хувь (95%CI 4.5-10.3), эмэгтэйчүүд 7.7 хувь (95%CI 5.1-10.2), хот, хөдөөгөөр нь хүйсээр нь авч үзвэл эрэгтэйчүүдийн хувьд хотод 12.0 хувь (95%CI 7.3-16.7), хөдөөд 3.3 хувь (95%CI 1.4-5.2), эмэгтэйчүүдийн хувьд хотод 10.8 хувь (95%CI 7.1-14.6), хөдөөд 4.2 хувь (95%CI 1.6-6.7) байгаа нь хотын нийт хүн амын 11.4 хувь (95%CI 7.5-15.2), хөдөөгийн хүн амын 3.7 хувь (95%CI 1.7-5.8) хөдөлгөөний идэвхгүйд тооцогдож байна. Дээрх судалгаанаас үзэхэд хотын хүн амын 10 хүн тутмын 1 нь хөдөлгөөний хомсдолтой байна.

Өндөр эрчимтэй идэвхтэй хөдөлгөөн хийдэггүй байдал

Нийт хөдөлгөөний идэвх өндөртэй хүн амын 48.5 хувь (95%CI 43.1-53.8) нь ажлын байр, амралт чөлөөт цагаараа өндөр эрчимтэй идэвхтэй хөдөлгөөнийг хийдэггүй байна. Үүнээс эрэгтэйчүүдийн 42.9 хувь (95%CI 37.3-48.4), эмэгтэйчүүдийн 54.2 хувь (95%CI 48.2-60.1) нь өндөр эрчимтэй идэвхтэй хөдөлгөөн хийдэггүй бөгөөд энэ үзүүлэлт нь наасны бүлгийн хувьд хүйсийн ялгаваргүйгээр аажмáар жигд нэмэгдсэн байна (Хавсралт I, 30).


Өндөр эрчимтэй идэвхтэй хөдөлгөөн хийдэггүй нийт хүн амыг хот, хөдөөгөөр авч үзвэл энэ үзүүлэлт хотын хүн амд 54.5 хувь (95%CI 48.5-60.6), хөдөөгийн хүн амд 42.4 хувьтай (95%CI 34.1-50.8) байгаа нь хөдөөд хотоос 12.1 хувиар илүү өндөр эрчимтэй идэвхтэй хөдөлгөөнийг ажлын байр болон амралт чөлөөт цагаараа хийдэг үзүүлэлт гарч байна.

Нийт хүн амын ажлын байранд, ирж очиход, амралтын цагаараа идэвхтэй хөдөлгөөн хийдэг хувийг авч үзэхэд ажлын байранд 53.4 хувь (95%CI 49.1-57.6), ирж очиход 23.7 хувь (95%CI 20.7-26.7), амралт чөлөөт цагаар 23.0 хувьтай (95%CI 20.1-25.8) байна. Хүйсээр нь ангиж үзэхэд төдийлөн зөрүүгүй жигд байна.

Идэвхтэй хөдөлгөөний голч хугацаа өдөрт 342.9 минут (95%CI 158.6-510) байгаагаас эрэгтэйчүүд 347.1 минут (95%CI 171.4-501.4), эмэгтэйчүүд 337.1 минут (95%CI 141.4-518.6) байгаа бөгөөд наасны бүлгээр авч үзвэл өндөр эрчимтэй идэвхтэй хөдөлгөөн хийж буй хугацаа эрэгтэйчүүд (385.7 минут), эмэгтэйчүүдэд (364.3 минут) 35-44 насанддаа дээд цэгтээ хүрч 55-64 насанд эрэгтэйчүүдэд 234.3 минут (95%CI 47.1-450), эмэгтэйчүүдэд 297.1 минут (95%CI 107.1-467.1) болон доод цэгтээ хүрсэн байна. Өөрөөр хэлбэл наа ахиж тусам хүний идэвхтэй хөдөлгөөн хийх эрчим, голч хугацаа буурч байна (Хавсралт I, 31-36).

Идэвхтэй хөдөлгөөнийг өдөрт хийж буй голч хугацааг ажлын байр, ирж очих, амралт чөлөөт цагаар нь задалж харвал ажлын байранд 214.2 минут (95%CI 25.7-342.9), ирж очиход 30.0 минут (95%CI 11.4-85.7), амралт чөлөөт цагаараа 51.4 минутыг (95%CI 4.3-102.9) тус тус зарцуулж байгаагаас эрэгтэйчүүд ажлын байранд 225.7 минут (95%CI 51.4-342.9), ирж очиход 34.3 минут (95%CI 10-90), амралт чөлөөт цагаараа 34.3 минутыг (95%CI 0-85.7) зарцуулдаг бол эмэгтэйчүүд ажлын байранд 205.7 минут (95%CI 7.1-342.9), ирж очиход 30.0 минут (95%CI 12.9-77.1), амралт чөлөөт цагаараа 51.4 минутыг (95%CI 11.4-120) зарцуулдаг байна.

Дурслэл 9. Идэвхитэй хөдөлгөөнд хоногт зарцуулдаг голч хугацаа (Хүйс, байршил, ажлын байр, ирж очих, чөлөөт цагаар)



Хөдөөгийн хүн ам хотын хүн амаас илүү ург хугацааг хөдөлгөөн хийхэд зарцуулж байна. Идэвхтэй хөдөлгөөнийг хийхэд хоногт зарцуулж буй голч хугацаагаар нь салгаж харвал хотод эрэгтэйчүүд ажлын байранд 180 минут (95%CI 8.6-308.6), ирж очиход 25.7 минут (95%CI 4.2-60.0), амралт чөлөөт цагаараа 25.7 минутыг (95%CI 0-64.3) зарцуулдаг бол хөдөөд эрэгтэйчүүд ажлын байранд 257.1 минут (95%CI 109.3-360), ирж очиход 60 минут (95%CI 20-120), амралт чөлөөт цагаар 45 минутыг (95%CI 0-120) зарцуулж байна. Эмэгтэйчүүдэд энэ үзүүлэлт хотод ажлын байранд 171.4 минут (95%CI 0-300), ирж очиход 21.4 минут (95%CI 7.1-60.0), амралт чөлөөт цагаараа 47.1 минутыг (95%CI 8.6-102.9) зарцуулдаг бол хөдөөд эмэгтэйчүүд ажлын байранд 240 минут (95%CI 85.7-360), ирж очиход 60 минут (95%CI 21.4-120), амралт чөлөөт цагаар 60 минутын (95%CI 17.1-124.3) голч хугацааг тус тус зарцуулж байна (Дурслэл 9).

Дүгнэлт


- Нийт хүн амын 7.5 хувийг идэвхтэй хөдөлгөөн хийдэггүй, хөдөлгөөний хомсдолд орсон эрсдэлт бүлэг зээлж байгаа бөгөөд хотын хүн амын 10 хүн тутмын 1 нь энэхүү эрсдэлд өртсөн байгаа нь хөдөөгийн эрэгтэйчүүдээс хотын эрэгтэйчүүд 4, эмэгтэйчүүд 2 дахин их байгаа үзүүлэлтээс харагдаж байна.
- Нийт хүн амын хоногт идэвхтэй хөдөлгөөнд зарцуулах голч хугацааг тооцоход ажлын байранд 214.2 минут, ирж очих хөдөлгөөнд 30.0 минут, амралт чөлөөт цагаар 51.4 минут тус тус зарцуулдаг байв.
- Энэхүү судалгааны дүнгээс харахад ажлын байранд нийт хүн амын (53.4%) 2 хүн тутмын 1 нь идэвхтэй хөдөлгөөн хийж байгаа нь амьдралын эрүүл хэв маягийн талаархи мэдлэг, мэдээллийг ажлын байраар дамжуулан олгох үйл явц үр дүнтэй, хүртээмжтэй байх боломж байгааг харуулж байна.
- Насны бүлгийн хувьд авч үзвэл эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 20 насаар хожуу өндөр болон дунд зэргийн эрчимтэй идэвхтэй хөдөлгөөнийг хийж эхэлж байгаа нь мөн адил идэвхтэй хөдөлгөөний мэдлэг дутмагаас илүүдэл жинтэй болсон хойноо идэвхтэй хөдөлгөөн хийх шалтгаан болж байна.

Бие бялдрын хөгжил, чийрэгжилт

Сорил авах аргачилаалд зарим нэг өөрчлөлтийг оруулсан нь сорил авах хугацааг богиносгож, ажиллагааг багасгасан буюу энэ удаад бие бялдрын үндсэн 5 чанарт (хүч, хурд, уян хатан, тэнцвэр, тэсвэр) суурилсан таван сорилоор авсан. Бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд нийт 1949 хүн буюу судалгаанд хамрагдсан хүн амын 37.5 хувь (3 хүн тутмын 1) судалгаанд оров.


Судалгааны дунгээр бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорилоор судалгаанд хамрагдсан эрэгтэйчүүдийн 27.5 хувь, эмэгтэйчүүдийн 34.8 хувь нь “А-Хангалттай сайн”, эрэгтэйчүүдийн 26.5 хувь, эмэгтэйчүүдийн 24.9 хувь нь “В-Сайн”, эрэгтэйчүүдийн 28 хувь, эмэгтэйчүүдийн 23.2 хувь нь “С-Хангалттай”, эрэгтэйчүүдийн 15.7 хувь, эмэгтэйчүүдийн 13.2 хувь нь “Д-Дунд”, эрэгтэйчүүдийн 2.4 хувь, эмэгтэйчүүдийн 3.9 хувь нь “F-Хангалтгүй” гэсэн үнэлгээг тус тус авсан байна (Дүрслэл 10).

Дүрслэл 10. Бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин (хүйсээр)




Судалгаанд хамрагдсан нийт хүмүүсийн дотор А, В үнэлгээ авсан хүмүүс 57,4 хувь байгаагаас эрэгтэйчүүд 54 хувь, эмэгтэйчүүд 59,7 хувийг эзэлж байна. С буюу түүнээс доош үнэлгээ авсан хүмүүс 42,6 хувь байгаагаас эрэгтэйчүүд 46.6 хувь, эмэгтэйчүүд 40.3 хувьтай байгаа нь 2005 оны судалгаатай харьцуулахад эрэгтэйчүүдийн хувьд бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшин 15 хувиар ахисан байна.

Дүрслэл 11. Бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин (насны бүлгээр)



Энэ ахицыг тодотгох үүднээс эрэгтэйчүүдийг дангаар нь насны бүлгээр авч үзсэн дүрслэлээс харахад 15-24 насны эрэгтэйчүүдийн “А-Хангалттай сайн” үнэлгээ 2005 оны судалгааны дунгээс 0.6 хувиар өссөн боловч “В-Сайн” үнэлгээ нь 9.4 хувиар буурч “С” буюу түүнээс доош үнэлгээ авсан эрэгтэйчүүдийн хувь 97.9 хувь болон 2005 оны 80.2 хувийн үзүүлэлтээс 17.7 хувиар өссөн байна. Энэхүү өссөн шалтгаан нь бие бялдрын боловсрол олгох шатанд 2005 онд байсан доголдлууд одоо болтол хэвээрээ байгаатай шууд холбоотой байж болох талтай.

Дүрслэл 12. Бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин, эрэгтэйчүүдэд (насны бүлгээр)



Хэлцэмж

Хүн бүр өдөр тутам ажлын байр, ирж очих, амралт чөлөөт цагаараа өндөр болон дунд зэргийн эрчимтэй идэвхтэй хөдөлгөөнтэй байх, дасгал, хөдөлгөөн, спортоор хичээллэхийн давуу тал, ач тусын талаархи мэдлэг эзэмших, амьдралын зөв хэв маягт суралцах үйл явц хүний амьдралын бага наснаас боловсрол олгох үйл явцтай хамсахгүй, энэ талаархи мэдлэг мэдээлэл хангалтгүй, биеийн тамир, спортын хичээлийн хөтөлбөр, орчин нөхцөл өнөөгийн шаардлага, стандартад нийцэхгүй байгаа нь 15-24 насны залуусын бие бялдар, хөгжил чийрэгжилтийн түвшин хангалттай сайн, хөдөлгөөний идэвхтэй байхад эерэг нөлөө үзүүлэхгүй байна.

3.3. ХБӨ-НИЙ ХОЁРДОГЧ ЭРСДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ТАРХАЛТ

Илүүдэл жин ба таргалалт

Эрүүл мэндийн үзүүлэлтийн нэг болох илүүдэл жин, таргалалт нь ХБӨ-ний завсрлын эрсдэлт хүчин зүйлд хамаардаг. Судалгааны хүн амын дунд илүүдэл жин ба таргалалтын түвшинг тогтоох зорилгоор антропометрийн хэмжилт хийх арга зүй эзэмшсэн судлаачид судалгаанд хамрагдсан 15–64 насны 5314 хүний биений жин, өндөр, бүсэлхийн тойргийн хэмжээг тодорхойлсон юм. Антропометрийн судалгаанд хамрагдагсдын биений жингийн индекс (БЖИ), бүсэлхийн тойргийн дундаж хэмжээг тодорхойлж, улмаар илүүдэл жин ба таргалалтын тархалтын түвшинг тогтоож хүн амын нас, хүйс, байршилаар харьцуулан үнэлгээ дутнэлт өгсөн болно.

Судалгаанд хамрагдсан эрэгтэйчүүдийн биений дундаж жин 68.3 кг (95% CI 67.2-69.3), өндөр нь 167.4 см (95% CI 166.7-168.0) байна. Харин эмэгтэйчүүдийн биений жин 61.7 кг (95% CI 60.9-62.4), өндрийн дундаж үзүүлэлт 157.4 см (95% CI 156.9-157.9) байв (Хүснэгт 30).

Хүснэгт 30. Биений жин, өндрийн дундаж үзүүлэлт (нас ба хүйсээр)

Нас	Эрэгтэй				Эмэгтэй			
	Жин - кг		Өндөр - См		Жин - кг		Өндөр - См	
	Дундаж	95%CI	Дундаж	95%CI	Дундаж	95%CI	Дундаж	95%CI
15-24	62.9	61.4-64.5	168.2	167.2-169.3	56.4	55.0-57.8	158.2	157.4-159.0
25-34	70.3	68.6-71.9	168.1	167.1-169.2	62.1	61.0-63.1	158.2	157.5-158.9
35-44	72.0	70.0-74.0	166.8	165.9-167.8	64.9	63.9-66.0	156.7	155.9-157.6
45-54	71.9	70.3-73.6	166.1	165.1-167.0	67.1	65.7-68.5	156.0	155.2-156.8
55-64	72.0	68.8-75.2	163.9	162.9-164.8	66.6	65.1-68.1	155.1	154.0-156.3
15-64	68.3	67.2-69.3	167.4	166.7-168.0	61.7	60.9-62.4	157.4	156.9-157.9

Судалгаанд хамрагдсан хүн амын биений жин, өндрийн дундаж хэмжээг хот, хөдөөгөөр харьцуулан судлахад статистик магадлал бүхий ялгаа ажиглагдсангүй. Тухайлбал, эрэгтэйчүүдийн биений жингийн дундаж хэмжээ хот суурин газарт 69.3 кг (95% CI 67.6-71.0) бол хөдөө орон нутагт 67.3 кг (95% CI 66.2-68.5), харин тэдгээрийн биений өндрийн дундаж хэмжээ хотод 168.5 см (95% CI 167.7-169.2), хөдөөд 166.4 см (95% CI 165.3-167.4) байна (Хүснэгт 31).

Хүснэгт 31. Биений жин, өндрийн дундаж үзүүлэлт (хүн амын байршилаар)

Нас	Эрэгтэй				Эмэгтэй			
	Жин - кг		Өндөр - См		Жин - кг		Өндөр - См	
	Дундаж	95%CI	Дундаж	95%CI	Дундаж	95%CI	Дундаж	95%CI
Хот	69.3	67.6-71.0	168.5	167.7-169.2	62.1	61.2-63.1	158.1	157.3-158.8
Хөдөө	67.3	66.2-68.5	166.4	165.3-167.4	61.1	60.0-62.2	156.7	155.9-157.4
Бүгд	68.3	67.2-69.3	167.4	166.7-168.0	61.7	60.9-62.4	157.4	156.9-157.9

Эмэгтэйчүүдийн биений жингийн дундаж хэмжээ хот суурин газарт 62.1 кг (95%CI 61.2-63.1), хөдөө орон нутагт 61.1 кг (95%CI 60.0-62.2), тэдгээрийн биений өндрийн дундаж үзүүлэлт хотод 158.1 см (95%CI 157.3-158.8), хөдөөд 156.7 см (95%CI 155.9-157.4) байлаа (Хүснэгт 31).

БЖИ-ийн дундаж хэмжээ 15 – 64 насны эмэгтэйчүүдэд 24.3 (95%CI 24.0-24.7), эрэгтэйчүүдэд 24.9 (95%CI 24.6-25.2) байна. Эмэгтэйчүүдийн БЖИ-ийн дундаж хэмжээ эрэгтэйчүүдийнхээс ялимгүй өндөр байгаа боловч, энэ нь статистик магадлал бүхий ялгаагүй байв. Судалгаанд хамрагдсан аль ч хүйсийн хүмүүсийн дундаж БЖИ-ийн дундаж хэмжээ нас ахих тутам нэмэгдэх хандлага ажиглагдаж байгаа боловч статистик магадлалтай байсангүй. Гэхдээ 15–24 насны хүмүүсийн биеийн жин болон БЖИ нь бусад насны хүмүүсийн үзүүлэлтээс харьцангуй бага байгаа нь статистик магадлал бүхий байв (Хүснэгт 32).

Хүснэгт 32. Биеийн жингийн индексийн дундаж үзүүлэлт (нас ба хүйсээр)

Нас	Эрэгтэй			Эмэгтэй*			Бүгд		
	Тоо	Дундаж	95% CI	Тоо	Дундаж	95% CI	Тоо	Дундаж	95% CI
15-24	400	22.2	21.7-22.7	473	22.5	22.0-23.0	873	22.3	21.9-22.8
25-34	599	24.8	24.3-25.3	857	24.8	24.5-25.2	1456	24.8	24.5-25.2
35-44	564	25.8	25.2-26.4	867	26.4	26.0-26.8	1431	26.1	25.8-26.5
45-54	412	26.1	25.5-26.6	620	27.5	27.0-28.1	1032	26.8	26.3-27.2
55-64	222	26.8	25.7-27.9	300	27.7	27.0-28.3	522	27.2	26.6-27.9
15-64	2197	24.3	24.0-24.7	3117	24.9	24.6-25.2	5314	24.6	24.3-24.9

*жирэмсэн эмэгтэйг оролцуулаагүй

Түүнчлэн 15–54 насны эмэгтэйчүүдийн БЖИ-ийн дундаж хэмжээ нь нас ахих тусам нэмэгдэх хандлагатай байгаа нь статистик магадлал бүхий байлаа. Харин 45–54 ба 54–64 насны эмэгтэйчүүдийн БЖИ дундаж хэмжээ нь 27.5 кг/m² (95% CI 27.0-28.1) ба 27.7 кг/m² (95% CI 27.0-28.3)) статистик магадлал бүхий ялгаагүй байв.

Мен 15–64 насны нийт хүн амын БЖИ-ийн дундаж хэмжээ хот суурин 24.7 кг/m² (95%CI 24.3-25.0) болон хөдөө орон нутагт 24.6 кг/m² (95%CI 24.2-24.9) төдийлөн ялгаатай бус байна (Хүснэгт 33).

Хүснэгт 33. БЖИ-ийн дундаж үзүүлэлт (байршилаар)

Нас	Эрэгтэй			Эмэгтэй*			Бүгд		
	Тоо	Дундаж	95% CI	Тоо	Дундаж	95% CI	Тоо	Дундаж	95% CI
Хот	991	24.4	23.7-24.9	1508	24.89	24.5-25.3	2499	24.7	24.2-25.0
Хөдөө	1206	24.3	23.8-24.7	1609	24.90	24.4-25.4	2815	24.6	24.2-24.9
15-64	2197	24.3	23.9-24.7	3117	24.9	24.6-25.2	5314	24.6	24.3-24.9

*жирэмсэн эмэгтэйг оролцуулаагүй


Хот суурин ба хөдөө орон нутгийн эрэгтэй ба эмэгтэй хүмүүсийн БЖИ-ийн дундаж үзүүлэлт мөн статистик магадлал бүхий ялгаагүй байгааг дээрх хүснэгтээс харж болно.

Судалгаанд хамрагдагсдыг БЖИ-ийн эрсдэлийн үнэлгээгээр харьцуулан үнэлэхэд, 15–64 насны хүн амын 4.5 хувь (95% CI 3.2-5.8) нь туранхай, 55.7 хувь (95%CI 53.1-58.3) хэвийн жинтэй, 27.3 хувь (95%CI 25.3-29.2) нь илүүдэл жинтэй, харин 12.5 хувь (95%CI 10.8-14.3) нь таргалалттай байна (Хавсралт I, 36-38).

Биеийн жингийн эрсдэлийн үнэлгээгээр эрэгтэйчүүдийн 26.0 хувь (95%CI 23.2-28.7) ба 11.1 хувь (95%CI 8.7-13.4) нь илүүдэл жин ба таргалалттай байсан бол эмэгтэйчүүдийн 28.6 хувь (95%CI 26.3-31.0) ба 14.1 хувь (95%CI 12.1-16.0) нь тус тус илүүдэл жин ба таргалалттай байв.

Илүүдэл жин ба таргалалтын тархалтыг судалгааны хүн амын хүйсээр харьцуулан үнэлэхэд статистик магадлал бүхий ялгаа ажиглагдаагүй юм (Дүрслэл 13).

Дурслэл 13. Илүүдэл жин ба таргалалтын тархалт (хүйсээр)




БЖИ нь 25.0 ба түүнээс их байх тохиолдол буюу илүүдэл жин ба таргалалтын тархалт эмэгтэйчүүдийн дунд 42.7 хувь (95% CI 39.9-45.5), харин эрэгтэйчүүдийн дунд 37.0 хувь (95% CI 33.0-41.0) тохиолдож байгаа нь судалгааны дүнгээр тогтоогдлоо (Дурслэл 14).

Түүнчлэн илүүдэл жин ба таргалалттай 25–34 насны эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн эзлэх хувь 15–24 насны хүмүүстэй харьцуулахад огцом нэмэгдэж (2.2-2.5 дахин) байгааг судалгааны дун харуулж байна. Тухайлбал илүүдэл жин ба таргалалттай 15–24 насны эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн эзлэх хувь 15.7 хувь ба 19.1 хувь байгаа бол уг үзүүлэлт 25–34 насны эрэгтэйчүүдэд 2.5 дахин (40.1%), эмэгтэйчүүдэд 2.2 дахин (41.4%) нэмэгдэж бай.

Илүүдэл жин ба таргалалтын тархалт 15–44 насны аль ч хүйсийн хүмүүсийн дунд наснаас шууд хамаарч нэмэгдэх хандлага ажиглагдсан бөгөөд энэ нь статистик магадлал бүхий судалгааны дүнгээр нотлогдож байна. Харин 45–64 насны хүн амын талаас илүү хувь нь илүүдэл жин ба таргалалттай байсан ба тархалтын түвшинд статистик магадлал бүхий ялгаа ажиглагдаагүй (Дурслэл 14).

Дурслэл 14. Илүүдэл жин ба таргалалтын тархалт, насны бүлэг ба хүйсээр



Илүүдэл жин ба таргалалтын тархалт 45–64 насны хүн амын дунд хамгийн түгээмэл, тухайлбал эрэгтэйчүүдийн 55.9-60.3 хувь, эмэгтэйчүүдийн 65.8-67.7 хувь нь БЖИ 25 ба түүнээс их буюу илүүдэл ба таргалалттай байна.


Судалгаанд хамрагдсан хүн амын дунд илүүдэл жин ба таргалалтын тархалтыг хүн амын байршилаар харьцуулан үнэлэхэд статистик магадлал бүхий ялгаа ажиглагдаагүй юм. Тухайлбал, хот суурин газрын 15–64 насны нийт хүн амын 41.1 хувь (95%CI 37.5-44.7), хөдөөгийн хүн амын 38.5 хувь (95%CI 34.7-42.3) илүүдэл жин ба таргалалттай байна (Хүснэгт 34).

Хүснэгт 34. Биетийн жингийн эрсдэлийн үнэлгээ (хүйс болон байршилаар)

БЖИ	Эрэгтэй					
	Хот			Хөдөө		
	Тоо	Хувь	95%CI	Тоо	Хувь	95%CI
Туранхай (БЖИ <18.4)	30	5.2	2.7-7.8	35	4.0	2.2-5.8
Хэвийн жин (БЖИ 18.5-24.9)	512	55.7	49.4-61.9	684	60.8	56.2-65.4
Илүүдэл жин (БЖИ 25.0-29.9)	315	28.1	24.6-31.7	335	24.0	20.3-27.8
Таргалалт (БЖИ >30.0)	134	10.9	6.9-14.9	152	11.1	8.6-13.7
БЖИ	Эмэгтэй					
	Хот			Хөдөө		
	Тоо	Хувь	95%CI	Тоо	Хувь	95%CI
Туранхай (БЖИ <18.4)	48	5.1	2.6-7.6	41	3.7	2.3-5.0
Хэвийн жин (БЖИ 18.5-24.9)	679	51.9	48.5-55.4	762	53.9	50.0-57.8
Илүүдэл жин (БЖИ 25.0-29.9)	496	28.4	24.8-31.8	527	29.0	25.8-32.1
Таргалалт (БЖИ >30.0)	285	14.6	12.1-17.1	279	13.4	10.5-16.4

Хот, хөдөөгийн хүн амын дундах илүүдэл жин, таргалалтын тархалтыг хүйсээр харьцуулан үнэлэхэд статистик магадлал бүхий ялгаатай дун гаралгүй. Илүүдэл жин ба таргалалтын байдал 15–64 насны эрэгтэйчүүдийн дунд хот суурин газарт 39.1 хувь (95%CI 33.0-45.2), хөдөө 35.2 хувьтай (95%CI 30.2-40.1) байлаа (Дурслэл 15).

Дурслэл 15. Илүүдэл жин ба таргалалтын тархалт, байршил ба хүйсээр



Дээрх дурслэлээс харахад хот суурин газрын эмэгтэйчүүдийн 43.0 хувь (95%CI 39.4-46.5), харин хөдөөгийн эмэгтэйчүүдийн 42.4 хувь (95%CI 38.2-46.6) тус тус илүүдэл жин ба таргалалттай ($\text{БЖИ} \geq 25.0$) байна.

Бүсэлхийн тойргийн дундаж хэмжээ ба товийн таргалалтын тархалт

Судалгаанд хамрагдсан хүн амын зурх судасны өвчинд өртөх эрсдэлийг илрүүлэх зорилгоор бүсэлхийн тойргийг хэмжин, төвийн таргалалтын тархалтын түвшинг тодорхойлсон юм. Хоёр дахь шаталалын судалгаанд хамрагдсан 15–64 насын эрэгтэйчүүдийн бүсэлхийн тойргийн дундаж хэмжээ 83.2 см (95% CI 82.2-84.3), эмэгтэйчүүдэд 82.6 см (95% CI 81.7-83.5) байна. Бүсэлхийн тойргийн дундаж хэмжээг хүйсээр харьцуулан үзэхэд статистик магадлал бүхий ялгаа ажиглагдаагүй. Түүнчлэн бүсэлхийн тойргийн дундаж хэмжээ нь наснаас шууд хамаарч нэмэгдэх хандлага ажиглагдсан боловч батлагдаагүй болно (Хүснэгт 35).

Хүснэгт 35. Бүсэлхийн тойргийн дундаж хэмжээ (насын бүлэг ба хүйсээр)

Нас	Эрэгтэй			Эмэгтэй*		
	Тоо	Дундаж	95% CI	Тоо	Дундаж	95% CI
15-24	402	76.5	75.2-77.8	475	75.7	74.4-77.1
25-34	600	83.9	82.4-85.4	859	82.9	81.7-84.1
35-44	567	88.3	86.3-90.3	868	86.5	85.5-87.5
45-54	416	88.9	87.1-90.6	622	89.5	88.0-91.0
55-64	223	91.8	88.3-95.3	300	91.3	89.9-92.8
15-64	2208	83.2	82.2-84.3	3124	82.6	81.7-83.5

Бүсэлхийн тойргийн дундаж хэмжээ 25–34 насанд (эрэгтэйд, 83.9 см (95%CI 82.4-85.4), эмэгтэйд 82.9 см (95%CI 81.7-84.1)) байгаа нь 15-24 насын хүмүүстэй харьцуулахад статистик магадлал бүхий огцом нэмэгдэж байгаа дүн ажиглагдааж байна.

Судалгаанд хамрагдагсадын бүсэлхийн тойргийн дундаж хэмжээг хүн амын байршилаар буюу хот хөдөөгөөр харьцуулан үнэлэхэд статистик магадлал бүхий ялгаа ажиглагдаагүй (Хүснэгт 36).

Хүснэгт 36. Бүсэлхийн тойргийн дундаж хэмжээ (Байршил ба хүйсээр)

Нас	Эрэгтэй			Эмэгтэй*		
	Тоо	Дундаж	95% CI	Тоо	Дундаж	95% CI
Хот	992	83.5	81.8-85.2	1511	81.7	80.5-82.9
Хөдөө	1216	83.0	81.7-84.3	1613	83.5	82.1-84.9
15-64	2208	83.2	82.2-84.3	3124	82.6	81.7-83.5

Тухайлбал, бүсэлхийн тойргийн дундаж хэмжээг байршилаар үзэхэд хот суурин газарт амьдардаг эрэгтэйчүүдэд 83.5 см (95%CI 81.8-85.2), эмэгтэйчүүдэд 81.7 см (95%CI 80.5-82.9) байгаа бол, хөдөөгийн хүн амын хувьд уг үзүүлэлт эрэгтэйчүүдэд 83.0 см (95%CI 81.7-84.3), эмэгтэйчүүдэд 83.5 см (95%CI 82.1-84.9) байгааг дээрх хүснэгтээс харж болно.

Түүнчлэн судалгаанд хамрагдсан хүмүүсийн бүсэлхийн тойргийн хэмжээг ашиглан төвийн таргалалтын тархалтыг тогтоолоо. Бүсэлхийн тойргийн хэмжээ нь эрэгтэйчүүдийн хувьд 90 см ба түүнээс их, харин эмэгтэйчүүдэд 80 см ба түүнээс их байх тохиолдлыг төвийн таргалалтай хэмээн тооцсон болно.

Судалгаанд хамрагдсан 15–64 насын эрэгтэйчүүдийн 29.1 хувь (95% CI 25.8-32.4), эмэгтэйчүүдийн 55.7 хувь (95% CI 52.3-59.0) төвийн таргалалттай байна. Төвийн таргалалтын тархалт судалгааны хүн амын наснаас шууд хамаарч ихсэх хандлага 15–44 насын хүн амын дунд нилээд тодорхой ажиглагдааж байсан бөгөөд энэ нь статистик магадлалаар батлагдааж байна. Төвийн таргалалт 35-аас дээш насын аль ч хүйсийн хүмүүсийн дунд харьцангуй

түгээмэл тохиолдож байгаа бөгөөд 35–54 насны 4 эмэгтэй тутмын 3 нь, 55–64 насны 10 эмэгтэй тутмын 8 нь тус тус төвийн таргалалтай байгааг дээрх хүснэгтээс харж болно. Харин 55–64 насны 2 эрэгтэй хүн тутмын нэг нь төвийн таргалалттай байв (Хүснэгт 37).

Хүснэгт 37. Төвийн таргалалтын тархалт (насны бүлэг ба хүйсээр)

Нас	Эрэгтэй (БТ ≥ 90 см)			Эмэгтэй (БТ ≥ 80 см)		
	Тоо	Хувь	95% CI	Тоо	Хувь	95% CI
15-24	402	10.4	6.3-14.6	475	31.3	25.8-36.9
25-34	600	29.5	24.7-34.4	859	59.4	54.7-64.1
35-44	567	43.4	37.0-49.8	868	71.4	68.0-74.8
45-54	416	45.4	39.2-51.6	622	76.1	70.8-81.4
55-64	223	55.9	44.5-67.3	300	80.6	74.9-86.2
15-64	2208	29.1	25.8-32.4	3124	55.7	52.3-59.0

Төвийн таргалалтын тархалтыг судалгааны хүн амын байршилаар буюу хот, хөдөөгөөр харьцуулан судалж үзэхэд төдийлөн ялгаатай бус байна (Хүснэгт 38).

Хүснэгт 38. Төвийн таргалалтын тархалт (байршилаар)

Байршил	Эрэгтэй (БТ ≥ 90 см)			Эмэгтэй (БТ ≥ 80 см)		
	п	Хувь	95%CI	п	Хувь	95%CI
Хот	992	31.7	26.6-36.8	1511	53.1	48.8-57.4
Хөдөө	1216	26.9	22.9-30.9	1613	58.6	53.5-63.6
Нийт	2208	29.1	25.8-32.4	3124	55.7	52.3-59.1

Тухайлбал, төвийн таргалалтын тархалтын түвшин хот суурин газарт амьдарч буй эрэгтэйчүүдэд 31.7 хувь (95% CI 26.6-36.8), эмэгтэй хүмүүсийн 53.1 хувь (95% CI 48.8-57.4) байгаа бол хөдөөгийн эрэгтэйчүүд 26.9 хувь (95% CI 22.9-30.9), эмэгтэйчүүдэд 58.6 хувь (95% CI 53.5-63.6) байна.

Судалгаанд хамрагдсан хүн амын биед агуулагдах өөхлөг эдийн хэмжээ

Уг судалгаагаар эрэгтэй 2167, эмэгтэй 3048 нийт 5215 хүний биед агуулагдах өөхлөг эдийн хэмжээг “GIMA” биеийн өөх хэмжигч багаж ашиглан биеийн жинд эзлэх хувиар тодорхойлсон. Биед агуулагдах өөхлөг эдийн хэмжээг дараах лавлагаа үзүүлэлттэй харьцуулан жишиж үнэлгээ өгсөн юм (Хүснэгт 39).

Хүснэгт 39. Биед агуулагдах өөхлөг эдийн хэмжээг үнэлэх хязгаар

Хүйс	Биед агуулагдах өөхлөг эдийн хэмжээ , %-аар			
	Бага	Хэвийн	Их	Маш их
Эрэгтэй	<10.0	10.0-19.9	20.0-24.9	25≤
Эмэгтэй	<20.0	20.0-29.9	30.0-34.9	35≤

Судалгаанд хамрагдсан 15–64 насны эрэгтэйчүүдийн биед агуулагдах өөхлөг эдийн дундаж лавламж хэмжээний хэвийн хязгаараас хэтэрсэн буюу 22.2 хувь (95%CI 21.4-23.0), харин эмэгтэйчүүдийн хувьд лавламж хэмжээний хязгаарт буюу 29.3 хувь (95%CI 28.5-30.2) байна (Хүснэгт 40).

Хүснэгт 40. Биед агуулагдах өөхлөг эдийн дундаж хэмжээ (нас ба хүйсээр)

Нас	Эрэгтэй			Эмэгтэй*		
	Тоо	Дундаж	95%CI	Тоо	Дундаж	95%CI
15-24	391	17.9	16.7-19.2	464	24.3	23.3-25.3
25-34	592	22.3	20.8-23.7	842	28.7	27.7-29.6
35-44	558	25.1	23.9-26.4	846	32.4	31.6-33.1
45-54	408	26.6	25.5-27.7	607	35.0	33.9-36.2
55-64	218	28.2	26.6-29.7	289	37.2	34.5-39.8
15-64	2167	22.2	21.4-23.0	3048	29.3	28.5-30.2

Судалгаанд хамрагдсан 25 ба түүнээс дээш насны эрэгтэйчүүд, 35 ба түүнээс дээш насны эмэгтэйчүүдийн биед агуулагдах өөхлөг эдийн дундаж хэмжээ нь лавлагаа хэмжээний хязгаараас хэтэрсэн буюу таргалалттай байна. Харин 45-64 насны 4 эрэгтэй тутмын нэг, мөн насны 3 эмэгтэй тутмын нэг нь биед агуулагдах өөхлөг эдийн хэмжээ ихсэлттэй буюу таргалалттай байгааг судалгааны дүн харууллаа.

Судалгааны хүн амын биед агуулагдах өөхлөг эдийн дундаж хэмжээг хот, хөдөөгөөр харьцуулан үнэлэхэд статистик магадлал бүхий ялгаа ажиглагдаагүй (Хүснэгт 41).


Хүснэгт 41. Биед агуулагдах өөхлөг эдийн дундаж хэмжээ (байршилаар)

нас	Эрэгтэй			Эмэгтэй*		
	Тоо	Дундаж	95% CI	Тоо	Дундаж	95% CI
Хот	958	21.6	20.6-22.6	1447	29.4	28.3-30.6
Хөдөө	1209	22.7	21.6-23.9	1601	29.3	28.1-30.4
15-64	2167	22.2	21.4-23.0	3048	29.3	28.5-30.2

Биед агуулагдах өөхлөг эдийн дундаж хэмжээ хот суурин газрын эрэгтэйчүүдэд 21.6 хувь (95%CI 20.6-22.6), эмэгтэйчүүдэд 29.4 хувь (95%CI 28.3-30.6) байсан бол хөдөөд мөн үзүүлэлт эрэгтэйчүүдэд 22.7 хувь (95%CI 21.6-23.9), эмэгтэйчүүдэд 29.3 хувь (95%CI 28.1-30.4) байна.

Судалгааны дунгээс харахад биед агуулагдах өөхлөг эдийн хэмжээ их ба маших эрэгтэйчүүдийн эзлэх хувь эмэгтэйчүүдээс харьцангуй өндөр байна. Биед агуулагдах өөхлөг эдийн хэмжээ нь ихэссэн эрэгтэйчүүдийн эзлэх хувь 28.2 хувь (95%CI 16.0-20.4) байхад, эмэгтэйчүүдийн 17.8 хувь (95%CI 15.6-19.9) нь өөхлөг эдийн хэмжээ ихсэлттэй байлаа.


Дүрслэл 16. Биед агуулагдах өөхлөг эдийн хэмжээ ихсэлттэй хүн амын эзлэх хувь, насны бүлэг ба хүйсээр



Биед агуулагдах өөхлөг эдийн хэмжээ маш их хүн амын тархалтыг судалгааны хүн амын нас ба хүйсээр харьцуулан үнэлсэн дүрслэлийг ажиглахад өөхлөг эдийн биеийн жинд эзлэх хувь наснаас шууд хамаарч ихсэх зүй тогтол ажиглагдсан юм. Тухайлбал биед агуулагдах өөхлөг эдийн хэмжээ маш их эмэгтэйчүүдийн эзлэх хувь нас ахих тутам нэмэгдэх хандлагатай байгаа бөгөөд энэ нь статистик магадлал бүхий байна. Харин биед агуулагдах өөхлөг эдийн хэмжээ 15-34 насны эрэгтэйчүүдийн дунд наснаас шууд хамаарч нэмэгдэж байсан бөгөөд 35-64 насны эрэгтэйчүүдийн талаас илүү хувь нь биед агуулагдах өөхлөг эдийн хэмжээ их байгаа дун гарлаа (Дүрслэл 16).

Түүнчлэн биед агуулагдах өөхлөг эдийн хэмжээ маш их буюу таргалалттай эрэгтэйчүүдийн эзлэх хувь 34.0 хувь (95%CI 29.9-38.1) байхад, эмэгтэйчүүдийн 25.2 хувьд (95%CI 22.1-28.2) нь биед агуулагдах өөхлөг эдийн хэмжээ нь маш их байв (Дүрслэл 17).

Дүрслэл 17. Биед агуулагдах өөхлөг эдийн хэмжээ ихсэлттэй хүн амын эзлэх хувь, насны бүлэг ба хүйсээр



Биед агуулагдах өөхлөг эдийн хэмжээ нь маш их эрэгтэйчүүдийн эзлэх хувь тухайн насны өөхлөг эдийн хэмжээ маш их эмэгтэйчүүдээс харьцангуй өндөр байна. Тухайлбал биед агуулагдах өөхлөг эдийн хэмжээ маш их 45-54 ба 55-64 насны эрэгтэйчүүдийн эзлэх хувь тухайн насны эмэгтэйчүүдээс (өөхлөг эдийн хэмжээ маш ихтэй) 3.8 ба 4.3 хувиар тус тус харьцангуй өндөр байна.

Хот суурин газарт амьдарч байгаа тарган хүн буюу өөхлөг эдийн хэмжээ маш их 15-64 насны эрэгтэйчүүдийн эзлэх хувийг хөдөөгийн ижил насны эрэгтэйчүүдийн үзүүлэлттэй харьцуулахад статистик магадлал бүхий ялгаа илрээгүй байна (Хүснэгт 42).

Хүснэгт 42. Биед агуулагдах өөхлөг эдийн эрсдэлийн үнэлгээ (байршилаар)

Байршил	N	Биед агуулагдах өөхлөг эдийн хэмжээ							
		Бага		Хэвийн		Их		Маш их	
		Xувь	95%CI	Xувь	95%CI	Xувь	95%CI	Xувь	95%CI
Эрэгтэй									
Хот	958	6.5	3.0-10.0	41.6	34.1-49.1	17.6	14.1-21.2	34.3	28.8-39.8
Хөдөө	1209	3.2	1.5-4.8	44.4	38.7-50.2	18.7	15.8-21.5	33.8	27.9-39.6
Бүгд	2167	4.6	2.7-6.6	43.2	38.5-47.9	18.2	16.0-20.4	34.0	29.9-38.1
Эмэгтэй									
Хот	1447	15.2	10.0-20.4	41.1	37.9-44.4	16.8	13.7-20.0	26.9	22.7-31.1
Хөдөө	1601	14.1	9.7-18.5	43.8	39.9-47.7	18.7	16.0-21.5	23.4	19.3-27.4
Бүгд	3048	14.7	11.2-18.1	42.4	39.8-45.0	17.8	15.6-19.9	25.2	22.1-28.2

Тодруулбал, агуулагдах өөхлөг эдийн хэмжээ маш их эрэгтэйчүүдийн эзлэх хувь хотод 34.3 хувь (95%CI 28.8-39.8) байхад хөдөөд 33.8 хувь (95%CI 27.9-39.6) байна. Судалгаанд хамрагдсан 15–64 насны эмэгтэйчүүдийн дунд өөхлөг эдийн хэмжээ маш их байх тохиолдол буюу таргалалтын тархалт хот ба хөдөөд төдийлэн ялгаатай бус, тус тус 26.9 хувь (95%CI 22.7-31.1) ба 23.4 хувь (95%CI 19.3-27.4) байна.

Дүгнэлт

1. Монгол эрэгтэй хүний биеийн жин, өндрийн дундаж хэмжээ 68.3 кг, 167.4 см, эмэгтэйчүүдийнх 61.7 кг, 157.4 см байна.
2. Хүн амын БЖИ-ийн дундаж үзүүлэлт эрэгтэйчүүдэд 24.3, эмэгтэйчүүдэд 24.9 байна. БЖИ-ийн эрсдэлийн үнэлгээгээр нийт хүн амын 39.8 хувь нь илүүдэл жин ба таргалалтай, үүнээс 27.3 хувь нь илүүдэл жинтэй, 12.5 хувь нь таргалалттай байна.
3. Илүүдэл жин ба таргалалтын тархалт нас ахих тутам нэмэгдэх хандлагатай байгаа бөгөөд бүх насны бүлэгт илүүдэл жин, таргалалттай эмэгтэйчүүдийн эзлэх хувь эрэгтэйчүүдээс харьцангуй өндөр байв.
4. Судалгаанд хамрагдсан 15–64 насны эрэгтэйчүүдийн 29.1 хувь, эмэгтэйчүүдийн 55.7 хувь төвийн таргалалттай байна. 35-аас дээш насны 10 эмэгтэй тутмын 7 нь бүсэлхийн таргалалттай байна.
5. Нийт эрэгтэйчүүдийн 43 хувь, эмэгтэйчүүдийн 52.2 хувь нь биед агуулагдах өөхлөг эдийн хэмжээ их буюу маш их байна. Судалгааны хүн амын биед агуулагдах өөхлөг эдийн дундаж хэмжээ наснаас шууд хамаарч нэмэгдэх хандлага аль ч хүйсийн хүмүүсийн дунд ажиглагдсан болно.

Биохимийн үзүүлэлт

Цусан дахь глюкоз болон холестериний хэмжээг биохимийн үндсэн үзүүлэлт, триглицерид, бага нягттай липопротеин ба их нягттай липопротеины хэмжээг нэмэлт үзүүлэлтээр авч үзлээ.

Судалгаанд хамрагдсан гурван хүн тутмын нэгд цусан дахь глюкоз, холестерин, триглицерид, бага нягттай липопротеин ба их нягттай липопротеины түвшинг тогтоож эрдэлэйн үнэлгээг гаргав. Глюкозын хэмжээний үнэлгээ чихрийн шинжнгийн талаарх хэсэгт орсон тул энэхүү бүлэгт цусан дахь өөх тосны байдлын үнэлгээг иэтгэсэн болно.

Цусан дахь холестерины түвшин

Нийт холестерины түвшин тогтоо шинжилгээнд холестерины хэмжээг багасгах эм хэрэглэж буй хүмүүсийг мөн хамруулав. Судалгааны 3-р шатанд хамрагдсадын цусан дахь нийт холестерины дундаж хэмжээ 4.4 ммол/л байсан ба эрэгтэйчүүдийн дундаж хэмжээ 4.5 ммол/л байсан бол эмэгтэйчүүдийн холестерины дундаж хэмжээ 4.2 ммол/л байв (Хүснэгт 43). Эрэгтэйчүүдийн болон эмэгтэйчүүдийн нийт холестерины дундаж хэмжээний хувьд статистикийн ач холбогдол бүхий ялгаа ажиглагдсангүй. Насны бүлгээр харьцуулан судлахад 45-аас дээш насанд холестерины дундаж хэмжээ ихсэх хандлага аль ч хүйсэнд ажиглагдаж байгаа ч энэхүү ялгаа нь статистик магадлал бүхий бус байна.

Хүснэгт 43. Цусан дахь холестерины дундаж хэмжээ (ммоль/л)

Насны бүлэг	Эрэгтэй			Эмэгтэй			Нийт		
	Тоо	Дундаж	95% CI	Тоо	Дундаж	95% CI	Тоо	Дундаж	95% CI
25-34	193	4.4	4.1-4.7	272	4.2	3.8-4.6	465	4.3	4.0-4.6
35-44	193	4.4	4.0-4.7	304	4.1	4.0-4.3	497	4.3	4.0-4.5
45-54	136	4.6	4.3-5.0	232	4.4	4.1-4.7	368	4.5	4.2-4.8
55-64	84	4.7	4.2-5.3	124	4.4	4.0-4.8	208	4.6	4.1-5.0
25-64	606	4.5	4.2-4.7	932	4.2	4.0-4.4	1538	4.4	4.1-4.6

Нийт холестерины хэмжээ ихсэх эрсдэлтэй болон ихэссэн (≥ 5.0 ммол/л) хүний хувь 25.0 (95%CI 19.4-30.5) байсан ба энэ нь эмэгтэйчүүдийн дунд 22.5 хувь (95%CI 16.8-28.2)-ийн тархалттай, эрэгтэйчүүдийн дунд 27.4 хувь (95%CI 20.9-33.9) байсан нь статистик магадлал бүхий ялгаагүй байлаа. Нийт холестерины хэмжээ ихсэх эрсдэлтэй болон ихэссэн хүн амын тархалтын хувь нас ахих тусам нэмэгдэж байв (Хүснэгт 44).

Хүснэгт 44. Нийт холестерины хэмжээ ихсэх эрсдэлтэй болон ихэссэн (≥ 5.0 ммол/л) хүний хувь

Насны бүлэг	Эрэгтэй			Эмэгтэй			Нийт		
	Тоо	%	95% CI	Тоо	%	95% CI	Тоо	%	95% CI
25-34	193	21.2	14.6-27.7	272	20.6	12.0-29.1	465	20.9	14.4-27.4
35-44	193	27.9	19.4-36.5	304	18.5	12.8-24.3	497	23.2	16.9-29.5
45-54	136	33.6	22.0-45.2	232	27.9	18.6-37.2	368	30.8	21.9-39.7
55-64	84	36.0	19.6-52.3	124	29.1	19.0-39.1	208	32.3	20.9-43.6
25-64	606	27.4	20.9-33.9	932	22.5	16.8-28.2	1538	25.0	19.4-30.5

Цусан дахь нийт холестерины хэмжээ ихэссэн хүний хувь (≥ 6.2 ммол/л) судалгаанд хамрагдсан нийт хүний дунд 8.5 (95%CI 5.4-11.6) байсан ба энэ нь хүйсийн хувьд статистик магадлал бүхий ялгаагүй байв. Нийт холестерины хэмжээ ихэссэн хүн амын тархалт 55-64 насын бүлгийн эрэгтэйчүүдийн дунд хамгийн өндөр (19.6%) хувьтай (95%CI 4.8-34.4) байсан ч бусад насын бүлгийнхнээс статистик магадлал бүхий ялгаатай байдал ажиглагдсангүй (Хүснэгт 45).

Хүснэгт 45. Нийт холестерины хэмжээ ихэссэн (≥ 6.2 ммол/л) хүний хувь

Насны бүлэг	Эрэгтэй			Эмэгтэй			Нийт		
	Toо	%	95% CI	Toо	%	95% CI	Toо	%	95% CI
25-34	193	7.4	2.9-11.9	272	8.9	1.6-16.1	465	8.1	3.4-12.9
